

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-67

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/ 7-52

2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 52-67

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
08 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Р.Эрдэнэбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэхээр баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Өлзийбаяр, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн

дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, С.Эрдэнэболд, Д.Ганбат нарын тавьсан асуултад Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, П.Сайнзориг, О.Амгаланбаатар, Х.Тэмүүжин, Э.Болормаа, Б.Батбаатар, Н.Батсүмбэрэл, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, П.Сайнзориг, Ө.Шижир, Д.Ганбат, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Ц.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөх:

“4.4.3.7.Эх орны дуудлага-Эр цэргийн албаны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар зэвсэгт хүчин,

албан хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас дахин “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөх:

“4.4.3.7.Эх орны дуудлага-Эр цэргийн албаны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар зэвсэгт хүчин, албан хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 3 дахь заалтын “уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв,” гэсний дараа “шинжлэх ухаан,” гэж “Аж

үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний” гэсний өмнө “Технологи,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн гаргасан, Төслийн 4.4.1.3 дахь дэд заалтын “ёс суртахууны доголдол,” гэснийг хасах, 4.4.1.4 дэх дэд заалтын “ёс зүйтэй” гэснийг “хариуцлагатай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл үг хэлэв.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Л.Мөнхцацрал, Ю.Энхтуяа, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Бодлогын газрын захирал Г.Бямбасүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, ахлах

мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав, Зэвсэгт хүчний Жанжин штабын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Бүрэнтөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Г.Хосбаяр, Б.Батбаатар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Энхбаяр, Б.Батбаатар нар үг хэлэв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 01 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 32 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Та бүхэнд Байнгын хорооны гишүүдийн ирцийн мэдээг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар, Чинбаатарын Анар, Батын Батбаатар, Нацагдоржийн Батсүмбэрэл, Энхбатын Болормаа, Хажсекберийн Жангабыл, Нямтайшир Номтойбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Өлзийхүүгийн Шижир, Жадамбын Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр биш юм байна. Сайд нь байхгүй байгаа юм байна. Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Ингээд 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулаад та бүхэнд Улсын Их Хурлын даргын зөвлөлөөр батлагдсан 3 асуудлыг танилцуулъя. Нэгдүгээрх асуудал нь Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаад байгаа. Манай Байнгын хорооноос анхны хэлэлцүүлгийг хийж санал, дүгнэлтээ ТББХ-нд хүргүүлэх юм байна. Хоёрдугаарх нь болбол Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл, мөн Байнгын хороо хуралдаж, хоёр дахь хэлэлцүүлгээс гарсан

санал, дүгнэлтээ Төсвийн Байнгын хороонд хүргүүлэх гэсэн ийм асуудал байна. 3 дахь асуудал нь Дэд хорооны бүрэлдэхүүний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн.

Энэ 3 дахь асуудал маань бас өмнөх хуралдаанаар хойшилсон. Үүнтэй холбогдуулаад МАН-ын бүлэг болон АН-ын бүлгээс мөн бас өнөө өглөө дахиад хойшлуулах хүсэлтээ болбол ирүүлсэн байгаад байгаа. Нэрсээ ахин нягтална. Дараагийн 7 хоног хүртэл энэ асуудлыг хойшлуулах, 2 намын бүлгүүд дахиж нэрсээ нягталж, дахиж ирүүлэх гэсэн ийм хүсэлтийг ирүүлсэн байгаад байна. Үүнтэй холбогдуулаад энэ 3 дахь асуудлыг болбол дараагийн 7 хоног хүртэл хойшлуулахаар байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх ийм 2 асуудал болбол байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Номтойбаяр гишүүн. Номтойбаяр гишүүнээр тасалъя.

Н.Номтойбаяр: Өглөөний мэнд хүргэе. Төсвийн тодотгол орж ирж байгаа юм. Би энэ Байнгын хороонд Тусгай хяналтын дэд хороо байгаа юм. Тодотголоор гүйцэтгэх ажилтай холбоотой төсөвт тодотгол хийгдэх юм уу? Тэгээд наадах чинь зарчмын хувьд 2 дэд хороогоо байгуулахаа хойшлуулах гээд байна. Хэрвээ төсөв дагаад гүйцэтгэх ажлын зардалтай холбоотой тодотгол орж ирж байгаа болбол наадах чинь гацаанд орох тийм асуудал үүсээд байна. Тэгэхээр Хишигсүрэн тэрийг нь асуучихсан нь дээр байх. Тэгээд хойшлуулбал цаг хугацаатай хойшлуулахгүй болбол наадах чинь худлаа болно шүү.

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүний санал. Номтойбаяр гишүүний саналыг сонслоо. Ямар нэг дэд хороотойгоор холбогдуулж хэлэлцүүлэх ёстой ч гэдэг юм уу, гүйцэтгэх

ажиллагаа, төсөвтэй холбоотойгоор тодотгол орж байгаа ямар нэг зүйл болбол байхгүй байгаад байгаа. Тэгэхээр дэд хороог хойшлуулах асуудал болбол ямар нэг байдлаар төсвийн тодотголтой холбогдуулж хүндрэл чирэгдэл учруулах асуудал болбол байхгүй байна л гэсэн мэдээллийг бол өгч байгаа. Өөр саналтай гишүүд байхгүй байна.

Тэгвэл би хэлэлцэх асуудлаа 2-оор нь баталъя гэдгээр горимын саналаар санал хураачихъя. Ингээд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг 2 асуудалтайгаар буюу нэгдүгээрх нь тогтоолын төсөл, хоёрдугаарх нь төсвийн тодотголтой холбоотой 2 асуудал байна. Энэ 2 асуудлаар баталъя гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Эхлээд туршилтын санал хураалт нэгийг явуулаадахъя. Туршилтын санал хураалт амжилттай явагдлаа. Санал хураалтаа явуулъя. Хэлэлцэх асуудлыг 80 хувиар дэмжлээ.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ/

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. Эхний асуудал Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг Байнгын хорооны хуралдаанд оруулцаа. Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Идэшийн Батхүү Эдийн Засаг, хөгжлийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар нар ХЗДХЯ-ны ТНБД, орж ирж байна уу? Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын

үүргийг түр орлон гүйцэтгэгч гэсэн байна. Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны ТНБД, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Ганзоригийн Эрдэнэбулган ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Энхтүвшин Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Зэнэмядарын Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний газрын дарга, Доржпаламын Гантулга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, М.Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Тогоогийн Гантогтох ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-ын дарга, Дугаржавын Амгалан НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх гэсэн байна.

ГХЯ-ны ТНБД Лханаажавын Мөнхтүшиг байна. Ганхуяг дарга байна уу, Батлан хамгаалах яам байна уу? Гадаад харилцааны бодлогын газрын захирал Гүнтэвсүрэнгийн Бямбасүрэн, БХЯ-ны ТНБД, бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, ОБЕГ-ын дарга Ариунбуян дарга байна. ОБЕГ-ын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Лувсаншаравын Өлзийбаяр, Цөмийн энергийн комисс, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албан дарга Гунаажавын Манлайжав гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Тогтоолын төслүүд гишүүдэд тараагдсан байгаа байх. Гишүүдийн нэрсийг авъя. Номтойбаяр гишүүнээр тасалъя. Ганбат гишүүнээр тасаллаа, 3 гишүүн. Номтойбаяр гишүүний микрофоныг өгье.

Н.Номтойбаяр: Өглөөний мэнд хүргэе. ЗГ-ын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороогоор орж ирж байна. Тэгэхээр энэ Байнгын хорооны үндсэн чиг үүрэг гадаад бодлого буюу гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, аюулгүй байдлынхаа чиглэлийн хүрээнд эдийн засгийн аюулгүй байдалтай шууд холбоотойгоор энэ гишүүд энэ тал дээр илүү онцгойлон анхаарал тавиад асуугаад явах байх. Санал, дүгнэлт ч гэсэн тэгж гарна.

Тэгэхээр энэ эдийн засгийн хөтөлбөрийн хүрээнд гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг ирэх 4 жилд ямар төсөөллөөр харж байгаа юм бэ? Өнгөрсөн хугацаанд болсон маш олон асуудлууд гарсан. Гаднын хөрөнгө оруулагчид цагтаа 2 мянга гаруй тоологддог байсан бол одоо бараг 20 хүрэхгүй шахуу л болчихсон байх. Итгэл маш их алдарсан. Энэ ямар шалтгаантай вэ гэхээр засаглалтай ч холбоотой, эрх зүйн орчинтой ч холбоотой, санхүү эдийн засгийн орчинтой ч холбоотой маш олон л асуудлууд бий.

Тэгэхээр ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөрийн бодит хэрэгжилтийг хангахад бид гаднын хөрөнгө оруулалт, хүн хүч, чадварлаг нөөц, техник технологи, санхүүгийн хувьд ч гэсэн эрсдэлээ хуваалцах гээд гаднын хөрөнгө оруулалт, гадаад бодлого зайлшгүй шаардлагатай. Тэгээд энэ

талаар нэг ойлголт энэ Байнгын хороонд өгөхийг хүсэж байна.

2-т гэхээр эдийн засгийн аюулгүй байдал талаасаа одоо ер нь эдийн засгийн аюулгүй байдал хэдэн хувь хангагдаад байгаа юм бэ? Хэдэн хувь хангагдахгүй байгаа юм бэ? Хангагдаж байгаа нь ямар хөшүүргээр хангагдаад байгаа юм, хангагдахгүй байгаад байгаа шалтгаанууд нь яг юу юм бэ? Энэ хөтөлбөр хэрэгжсэнээрээ 4 жилийн дараа өнөөдрийн хангаж байгаа болон хангагдахгүй байгаа хувь хэмжээ яаж өөрчлөгдөх юм бэ? Энийг нэг тодорхой ойлголт авчихмаар байна.

Тэгээд банк санхүүгийн аюулгүй байдлын хувьд ч гэсэн ер нь яах ер нь юу болох гээд байгаа юм бэ? Хүнсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн юу болох юм бэ? Тэгэхээр илүү аюулгүй байдлын чиг баримжааны хүрээнд эдийн засаг, банк санхүүтэй холбоотой чиглэлээр энэ хөтөлбөр хэрэгжсэнээр ямар сайн зүйлүүдийг авчрах юм бэ? Өнөөдрийн ямар асуудлуудыг яаж шийдэж цэгцлэх гээд байгаа юм бэ? Энэ талаар нэг ойлголт авмаар байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү дарга, дараа нь ГХЯ-ны ТНБД Мөнхтүшиг дарга нар хариулцаа. Номер 2 Батхүү дарга.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын 2024-өөс 28 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт таны асуусан чиглэлүүдээр дараах тодорхой заалт арга хэмжээнд туссан байгаа. Тухайлбал энэ банк санхүүгийн даатгалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих асуудлууд байгаа. Тухайлбал гадаадын банкны салбар нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай банк санхүүгийн байгууллага байгуулах асуудлууд байгаа. Хөрөнгийн зах зээлийн

мэргэжлийн оролцогчдыг нэмэгдүүлэх, татварын таатай орчинд бүрдүүлэх, даатгалын сарыг дэмжих гэсэн асуултууд байгаа.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татвар болон нийгмийн даатгалын бодлогоор дэмжих асуудлууд бас туссан байгаа. Татварын тогтолцооны тогтвортой байдлыг хангах, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих асуудлууд туссан. Цахим татварын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх байгаа. Жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийн татварын орчныг сайжруулна. Ажил олгогч, даатгуулагч харилцан өгөөжтэй байхаар татварын орчныг зохицуулна. Ажил гүйцэтгэх хөлсөөр ажиллах гэрээнд НДШ уян хатан хөнгөлөлттэй байдлаар ноогдуулна. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн импортын татварыг дэмжинэ.

Бизнес хөрөнгө оруулалтын таатай орчныг дэмжих талаар бас дараах заалтууд оруулсан байгаа. Хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулан Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад багц хуулиудыг шинэчилнэ. Шинэ ААН-д тулгардаг саад хоригийг арилгаж, start up болон зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих монополын эсрэг арга хэмжээг авна. Зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулна.

Г.Тэмүүлэн: Мөнхтүшиг дарга 3 номер. Тэгээд нэмээд Номтойбаяр гишүүн нэмж тодруулъя.

Л.Мөнхтүшиг: ГХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхтүшиг байна. Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Эхний асуултын хувьд эдийн засгийн аюулгүй байдал, худалдаа эдийн засгийг дэмжих чиглэлээр гадаад бодлогын хүрээнд ямар ажлууд хийгдэх вэ гэдэг асуудалд хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам

байгуулагдсантай холбоотойгоор ГХЯ ирэх 4 жилд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл хөтөлбөрүүд энэ дотор эдийн засгийн томоохон 14 төсөл арга хэмжээ багтана. Энэ чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа нягт уялдаатай хамтран ажиллана.

Яамдын чиг үүргийн давхцалыг болбол өнгөрсөн засгийн үед бол байсан болбол сая их тодотгоод бодлого талаасаа Эдийн засаг, хөгжлийн яам зангидаад, ГХЯ, дипломат төлөөлөгчийн газрууд бол хэрэгжилт дээр онцгой анхаарч ажиллахаар ингэж төлөвлөж байгаа. Эдийн засгийн аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхтэй холбоотой асуултын хувьд яг эдийн засгийн аюулгүй байдал хэдэн хувиар хангаж байгаа гэдгийг болбол шууд ГХЯ-наас бол хариулахад хүндрэлтэй байна. Яг гадаад худалдаа Монгол Улсын худалдааны түнштэй холбоотой статистик мэдээлэл дээр болбол ерөнхийдөө манай улсын эдийн засаг худалдааны хувь хэмжээ болбол тодорхой харагдах болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Номер 2. Номтойбаяр гишүүн нэмж тодруулъя.

Н.Номтойбаяр: Мэдээж энэ Байнгын хороо бол аюулгүй байдал талаасаа л гол тэр өнцгөөс л харж таараа. Тэгэхээр дараа дараагийн тэгээд чуулган дээр ч гэсэн энэ асуудал хөндөгдөнө. Хамгийн чухал нь л энэ. Тэгэхээр ЗГ-т аюулгүй байдлын чиг үүрэг шууд л хамааралтай. ЗГ-ын толгой чинь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд байдаг. Чиг үүргийг хангах байгууллагууд нь хамтдаа л байж байдаг. Тэгэхээр энэ л их чухал байгаад байгаа юм л даа.

Нөгөө талаасаа энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг харахаар ямар эдийн засгийн системийг суурь зарчмаа болгож боловсруулсан гэдэг нь ойлгомжгүй байгаад байгаа юм. Барууны чиг баримжаатай юм уу, зүүнийх юм уу,

төвийг сахих юм уу? Тэгээд нэг Монголыг тойрсон эргэн тойрон, геополитикийн нөхцөл байдал, дотоод эдийн засгийн нөхцөл байдал эндээс гарах арга замаа улс төр, нийгэм, эдийн засгийн ямар үзэл баримтлалыг суурь зарчмаа болгож боловсруулсан юм бэ? Энийг би эртээд ЗГ-ын тэргүүнээс асуусан. Тэгээд Шадар сайд нь өмнөөс нь хариулаад тодорхой хариулт өгөөгүй. Энэ анхны гарааны эхлэл. Энийг анхнаасаа их тодорхой болгочихвол бид ч гэсэн Их Хурлын зүгээс хяналт тавих, хэрэгжилтийг нь дэмжих, холбогдох хууль, эрх зүйн орчнуудыг нь бүрдүүлж өгөх ойлгомжтой болчихмоор байгаа байхгүй юу. Тэгэхээр энд л нэг та хэд нэг маш тодорхой нэг хариулт өгчихмөөр л байгаад байгаа юм.

Тэгээд илүү юу гэдэг юм Ажлын хэсэг энийг ч хариулж чадаж байна, чадахгүй байна гэхээсээ илүүтэй цаашид нэг анхаарах нэг хэд хэдэн асуудлуудаа л та хэд нэг энэ хэлэлцүүлгийн явцад нэг тодорхой болгоодхооч. Тэгээд саяхан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хаалттай хуралдаан дээр нэг мэдээлэл хийсэн. Тэгээд тэрэнтэй яаж уялдаад байгаа юм бэ? Тэгээд дараа дараагийн хурлууд дээр миний болон бидний зүгээс асуух асуултын өнцөг бол энэ л байна.

Г.Тэмүүлэн: Нэмж тайлбар өгөх үү? Номер 2 Батхүү дарга.

И.Батхүү: Номтойбаяр гишүүний асуултад тайлбар өгье. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр олон зорилго, зорилтын хүрээнд олон арга хэмжээ төлөвлөгдсөн байгаа. Багцлаад бодлого талаас нь ерөнхий байдлаар хариулбал бол эрчим хүчний хамаарлаас ангижрах, эрчим хүчний бие даасан байдлыг хангах чиглэлийн асуудлууд туссан байгаа. Мөн хөдөө аж ахуйн салбарыг реформ хийж эдийн засгийг төрөлжүүлэх, экспортыг төрөлжүүлэх асуудлууд, хүнсний аюулгүй байдлын асуудлуудыг хөндсөн байгаа.

Банк санхүүгийн салбарыг бас бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг

нэмэгдүүлэх асуудлууд туссан байгаа. Хамгийн гол нь бол гаднын гуравдагч орны хөршүүдийн хөрөнгө оруулалтыг татах үүднээс манай экспортын зах зээлийг тэлэх, тухайлбал ОХУ, БНСУ бусад бүс нутгийн байгууллагуудтай чөлөөт худалдаа эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрүүдийг шинээр байгуулах ийм асуудлууд туссан байгаа.

Үндэсний аюулгүй байдал талаасаа бас нэг улсын хөрөнгө оруулалтын хэмжээ 30 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтууд байгаа. Энэ асуудлыг бас тусгайлан танд мэдээллийг хүргүүлье.

Бас нийгмийн талаасаа бас эдийн засгийн тогтвортой байдлыг хангах энэ хүрээд байгаа өсөлтийг хадгалах, тууштай хадгалах, валютын ханшиг тогтворжуулах, ядуурлын бууруулах гэх мэтчилэн олон асуудлыг дурдсан байгаа. Энэ багц асуудлууд нийлээд бас үндэсний аягүй аюулгүй байдал талаасаа бас бид нарын зорилт тавьж байгаа гэж үзэж болно.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Саяын Номтойбаяр гишүүний асуултад зарим зүйл нь дурдагдаж байгаа учраас товчлоод хэлэхэд ингээд 2010 онд үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлагдаад 14 жил болж байгаа. Энэ 14 жилийн хугацаанд болбол тухайн баримт бичигт бол тодорхой хугацаа заасан зорилтуудыг тавьсан байсан. Энэ нь болбол яг эдийн засагтай шууд холбоотой. Нэгд нь болбол товчлоод хэлэхэд эрчим хүчний хараат байдлаас 100 хувь гарна гэсэн зорилт тавьж байгаа.

2-т нь болбол шатахуунаа дотоодоосоо 100 хувь хангадаг болно гэсэн зорилтууд тавьж байгаа. Ингээд 2020 он болчихсон 4 жил өнгөрчихсөн байгаа. Тэгэхээр ЗГ бол 24-өөс 28 оны 4

жилийн ингээд хөтөлбөр оруулж ирж байгаа гэнгүүт нөгөө талд нь болбол үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал маань зүгээр албан бус байдлаар ингээд судлаад харахаар зорилт тавьсан хөтөлбөрүүдийн 70 хувь нь хэрэгжээгүй байгаа. 6 төрлийн аюулгүй байдал байгаа шүү дээ. 6 төрлийн аюулгүй байдал гэж тодорхойлсон зорилтууд нь ихэнх нь аягүй их доголдолтой байгаад байгаа. Тэгээд энэ талаар болбол ойрын үе бид нар энэ нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаа эдийн засаг тулгамдаж байгаа сорилт, дээрээс нь бүс нутгийн энэ аюулгүй байдал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал дээр бас зарим талаар дахин тодорхойлох шаардлагатай болсон учраас миний найдаж байгаагаар ойрын хугацаанд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бас дахин шинэчлэгдэх байх гэж харж байгаа юм.

94 онд анхных нь байсан, 2010 онд 2 дахь нь байсан, одоо өдий үед болбол ингээд 3 дахь нь болчихсон. Тэр тусмаа энэ хамтарсан ЗГ-ын үед бас энэ үндэсний стратегийн гэж хэлж болохуйц эдийн засгаа тэлж болохуйц тэр хөшүүргүүдийг бодлого болгож гаргахын тулд үүнийгээ бид нар энэ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтайгаа уялдуулж гаргах шаардлагатай. Тэгэхээр одоо ингээд цаг хугацааны хувьд болбол ЗГ эмхлэгдсэн байгуулагдаад мэдээж хөтөлбөр бол гараад явна. Энэ зуур бас ойрын 1, 2 жилийн дотор үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дахиад шинэчлэгдэж гарах зайлиггүй шаардлагатай байгаад байгаа юм.

Тэгэхээр ер нь болбол яг энэ уялдаагаа хангаад, болж өгвөл бас яг энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулах тэр баг, тухайн субъектүүд байгаа шүү дээ тэр субъектүүд, тэр судлаачидтай бас эхэлж юмаа сайн уялдуулаарай л гэж хүсэх гээд байгаа юм. Тэгж уялдуулж байж гарахгүй болбол энд жишээлбэл нэг хүнд

оногдох ДНБ-ийг 10400 ам.доллар болгоно гээд одоогоос 12-оос 13 үзүүлэлтээр энэ ЗГ-ын бодлого, үйл ажиллагааны үр дүнг 4 жилийн дараа дүгнэх юм байна л даа. Өчигдөр ХЗБХ-н дээр бол 12 нь 13 болоод ороод ирж байх жишээтэй. Энэ шалгуур үзүүлэлт нь бол нэг зорилт байгаа. Гэхдээ нөгөө талдаа энэ аюулгүй байдал дээр анхаармаар байна.

Яг төгсгөлд нь бас нэг санаа хэлчихэд бид нар ингээд олон төсөл хөтөлбөрүүдийг ярьдаг. Жишээлбэл Улсын Их Хурлын чуулган дээр жишээлбэл Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц эд нар гээд тодорхой зүйлүүд ярьж байгаа. Монгол Улсыг яг тэр нөгөө энэ аюулгүй байдлын хувьд таны хэлж байгаа шиг эрчим хүч.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 6 номер албан тушаал, нэрээ танилцуулаарай, 6 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам зөвлөх Эрдэнэбат байна. Сая Номтойбаяр гишүүний асуулт болон Эрдэнэболд гишүүний асуултад нэмээд хариулчихъя гэж бодож байна. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр ямар үзэл баримтлал гэх үү онолын хүрээнд хийгдсэн бэ гэж эхний асуулт байх шиг байна. Тэгээд тэрэн дээр болохоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын хөгжлийн бодлого урт хугацаанд тогтвортой байна гээд үүний дагуу хууль батлагдаад Эдийн засаг, хөгжлийн яаман дээр энэ ажил маань зангидагдаад явж байгаа. Энэтэй холбоотойгоор энэ үйл ажиллагааны хөтөлбөр маань 4 бүлэгтэй. 4 бүлгийнхээ юу гэдэг юм илүү чанарыг харсан учраас хүн, эдийн засаг, төр нөгөөдөх нь бүсчилсэн хөгжил гэж ингэж бүлэглээд явж байгаа.

Дээрээс нь үйл ажиллагааны хөтөлбөр дээр эрсдэлийг эрсдэлийн менежмент гэж бас тодорхой хэсэг орж ирсэн байгаа. Энэ дээр бид нар тулгарч байгаа гадаад, дотоод эрсдэлүүдийгээ тооцоод энд тохируулсан менежментийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ

гээд тодорхой заалтууд орчихсон байгаа. Дээрээс нь яг хэрэгжүүлэх зорилтуудаа бас тодорхойлоод хавсралтаар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүн, хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт зорилтод түвшин гээд тавьчихсан. Тэгээд энэ болохоороо нэлээн шинэлэг нь болохоороо гадаад, дотоод индексүүдийг түлхүү оруулж ирсэн байгаа. Жишээлэхэд аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотойгоор good country буюу сайн засаглалын индекс гэх мэтчилэнгээр энэ индексүүдийг оруулж ирснээрээ энэ ажил маань илүү чанартай, бид нар ажлаа төлөвлөх, хүрэх үр дүн, зорилтоо илүү тодорхой болгож гаргаж ирсэн гэж бодож байгаа.

Яг тодорхойлсон заалтууд гэвэл 3.1.1 дээр Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг ханган, үндэсний аюулгүй байдалд хөгжил дэвшлийг хангах, гадаадад таатай орчин бүрдүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэн ажлыг үргэлжлүүлнэ гэх мэтчилэнгээр нэлээн хэдэн заалтууд ингээд тус тусад нь орчихсон байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Эдийн засгийн аюулгүй байдал гэхээр бид нар ингээд хэвшмэл ойлголтоосоо бас жоохон ангижрах хэрэгтэй юм шиг байгаа юм. Одоо ингээд стратегийн орд, тэрийг тойрсон ингээд лиценз, ингээд төр ингээд менежментийг нь хийнэ гэдэг явцуурлаасаа гадна энэ хувийн хэвшлийн үйл ажиллагааг ажиллагаанд саад болохгүй, бизнесийн орчинд төр ингээд монопольтохгүй байх нь өөрөө эдийн засгийн аюулгүй байдал гэдэг концепц манай үзэл баримтлал дээр байгаа юм. Энийг ер нь энэ бодлого боловсруулж байгаа, шийдвэр гаргаж байгаа хүмүүс ойлгохгүй байгаа.

Тийм ч учраас энэ жил сонгуулийн өмнө цементийн салбарыг алсан,

сонгуулийн өмнө улаан буудайн салбарыг алсан, одоо ингээд дүүрэн рапс тарьж байна. Үндсэндээ болбол энэ ЗГ-ын сонгуулийн зориулсан ийм юмнууд болоод байгаа шүү. Тэгэхээр нэгэнт хамтарчихсан юм чинь хамтарсан ЗГ гэдэг утгаараа энэ нэг хэт аймаар экстрем эдийн засгаа алсан энэ чиглэлийн юмнуудыг л багасгамаар байгаа юм. Тэгэхгүй болохоор бид нар ингээд хувийн хэвшил гэдгийг болбол хувь хүмүүс гэж ойлгоод, төрийг болбол стратегийн бизнес гэж ингэж ойлгоод байдаг.

Гэтэл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын углуурга суурь чинь өөрөө энэ чөлөөт нийгмийн үзэл санаа, ардчилал, хүний эрх, бизнесийн энэ орчин гэдэг юмаа хамгаалах дээр явна шүү. Тэрнээс биш мөрдөстэй генералуудын нууцын зэрэглэлтэй хавтсан дотор үндэсний аюулгүй байдлын хэсэгхэн зүйл байдаг. Бодитоороо яг шударга бизнес эрхэлж байгаа хүмүүс өнөөдөр боломжгүй хүмүүс нь мянга мянгаараа Солонгос руу явж байгаа. Энд болбол бид нар хүний нөөц, эдийн засгийн аюулгүй байдал чинь энд алдагдаад байгаа шүү. Энийг бодлогодоо тусгаарай л гэж хэлэх гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Үгүй ээ тэгээд би асуулт асуух гээд байдаг энэ сайд нар нь байх ёстой юм уу, байхгүй байх ёстой юм уу? Би бол Монголын ард түмний элч бөгөөд нийт сонгогчдын 10 хувийг төлөөлөөд сууж байна л даа, 200 мянган хүнийг. Тэгээд асуумаар асуумаар юмнууд байх юм. Юу ч болсон тэгээд хариулах үгүйг нь харъя л даа.

Үндэсний аюулгүй байдлын асуудал маш чухал. Ер нь Үндсэн хуульд бол заачихсан байгаа шүү дээ. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулна гээд. Бас дотор нь бол ард түмний засаглах эрхийг хангана гэж байгаа. Ард түмэн засаглахдаа бол сонгуулиар засаглаж

байгаа юм л даа 1 дүгээрт. Энэ юм чинь тэгээд энэ ЗГ-ын энэ мөрийн хөтөлбөр энэ юманд чинь яг тусгагдаж чадсан уу? Би бол Ардын намыг 68 суудалтай олонх гэж ойлгоод байгаа. Монголын ард түмэн тэр хөтөлбөрийг нь дэмжээд саналаа өгсөн. Цомхон, чадварлаг төр байна гээд заачихсан байгаа. Цомхон, чадварлаг байж чадаж байгаа юу?

Хамгийн гол юм бол бид бүхэн 2 том гүрний дунд оршиж байна. Тэгээд юу гэж хэлдэг вэ гэхээр бид нар ард түмнээсээ асуух ёстой. Ард түмнийг төлөөлсөн улсууд байдаг. Тийм учраас нэг хэдхэн хүн тоталитар дэглэмд байгаа юм уу ингэж шийдэж барьдаггүй гээд хэлж байдаг. Энэ хамгийн гол зарчим. Гэтэл 2, 3 нөхөр суугаад л янз бүрийн бичиг баримт дураараа зураад л. Одоо тэгвэл яах юм цаашидаа энэ хөршүүдээс тулгана шүү дээ. Үгүй ээ та 3 л мэддэг юм чинь та 3 юм уу, та 2 ч юм уу мэдээд шийд гэж ингээд тулгах нь л дээ. Тэгэхээр маш эмзэг болно гэж би ойлгож байна.

Тэгээд эдийн засгийн, эрүүл мэндийн энэ бүх юмнууд маш эмзэг байна. Энэ 4 жилийн хөтөлбөр чинь хэрэгжих юм уу, зүгээр нэг хий хоосон цаас юм уу, өмнөх 4 жилийн хөтөлбөрүүд хэрэгжсэн үү? Зүгээр захаас нь би дурдъя. Дарханы замыг хэчнээн жил хийв, хэчнээн олон хүн тэр замд нас барав. Нөгөө нефтийн үйлдвэр чинь хэдэн жил явж байна вэ, удахгүй нефть шатахуун тасрах шинж байдал руу орох гээд байна. Өмнөх нь тасарч байсан энэ явдал давтагдах уу, үгүй юу? Хэзээ тэр юм чинь орох юм бэ?

Нөгөө талаас их олон асуудал байна ингээд яривал. Тэгээд нөгөө угаасаа суурь бүтэц нь ингээд хазгай муруй барьчихсан болохоор бүх юм нь хазгай муруй ингээд цаашаа ингээд яваад байна шүү дээ. Энэ юмыг засаж залруулах хэрэгтэй. Яаж зөв болгох юм бэ? Энэ талаар та нарын бодлыг сонсьё л доо? Юу гэж бодож байгаа юм бэ та нар бодвол мэргэжилтнүүд л байлгүй. Тэгээд тэр сайд нарыг нь дуудмаар байна.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам хариулах уу, 2 номер. Дээрээс нь сайд нарыг дуудаарай. Дараагийн асуудал бас төсөв байгаа. Сангийн сайд зайлиггүй байх ёстой. Асуултад хариулъя.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн ТНБД Батхүү. Ганбат гишүүний асуултад хариулъя. 2020-оос 24 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний тайлангийн эх сурвалжаас харахад 2023 он оны байдлаар 73,7 хувьтай хэрэгжсэн байна гэж тайлагнасан байна. Энэ хэрэгжилтэд удаашируулсан гол шалтгаанууд нь бол зарим төслүүдийн санхүүжилт эх үүсвэр шийдвэрлэхэд асуудалтай байсан, Төсвийн хэмнэлтийн тухай хууль анхны тооцоолсон төсөвт хүрээгүй зэрэг, үнийн өсөлт зэрэг шалтгаанууд, бас ковидын нөхцөл байдал, бас геополитик нөхцөл байдалтай холбогдоод үүссэн гэсэн нэг тайлбар байна. Бас цар тахал, хилийн хориотой холбоотой тээвэрлэлтийн асуудлаас шалтгаалаад төсөл арга хэмжээнүүдийн материал, технологи тээвэрлэлт дээр асуултууд асуудлууд гарсан, нийлүүлэлт тасалдсан асуудал байна гэх мэтчилэн иймэрхүү асуудлууд гарч байсан байна.

Таны дурдсан бусад асуултуудтай холбоотой энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.1 дээр чадварлаг, цомхон, чадахуйн зарчимд суурилсан, төрийн албыг бэхжүүлэх, төрийн алба албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, төрийн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний төрлийг оновчилж, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан төрийн захиргааны албан хаагчийн тоог зохистой хэмжээнд хүргэнэ гэсэн арга хэмжээ туссан байгаа.

Мөн 4.2.4.2 дээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд Хотын зөвлөл, захирагчийн сонгуулийг цахимаар явуулж, орсон суугчдаас иууд сонгох эрх зүйн орчныг бүрдүүлж, шинээр байгуулсан хотуудыг зохион байгуулна гэсэн заалтыг бас тусгасан байгаа.

Эрүүл мэндийн чиглэлээр бас туссан заалтыг танд танилцуулъя. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж буй хүчин зүйлс архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжих боловсрол олгоно. Олон улсын зохистой дадал, стандартыг бүрэн нэвтрүүлэхийн зэрэгцээ эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортын импортыг бүрэн цахимжуулан, иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшил технологи, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналт нэвтрүүлнэ гэсэн заалт бас орсон байгаа.

Бас хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр 4.2.3.2 дээр олон улсын үнэлгээний цогц системийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгоно гэх мэтчилэн заалтууд туссан байгаа.

Г.Тэмүүлэн: Тэгье Ганбат даргаа. Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт сайд бас орж ирсэн байна. Ганбат гишүүнд нэмж тодруулъя.

Д.Ганбат: Тэр энэ мөрийн хөтөлбөр дээр байгаа юмаа л уншаад байх шиг байна. Би гол нь зарчмыг нь асуугаад байна л даа. Яг тэр ард түмний засаглах эрх хангагдаж чадаж байгаа юм уу? Сонгуулиар ард түмэн саналаа өгсөн, тэр нь тусгагдаж чадсан уу?

Нөгөө талаар тэр Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, заалт хэрэгжиж байгаа юу? Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулна л гэж байгаа юм. Тэгээд энэ ардчилсан нийгэм нь мөн юм уу? Ийм зүйлийг юу гэж ойлгоод байгаа юм бэ? Тэгээд ард түмэн хамаагүй болчихсон уу энийг л асуугаад байна л даа. Сонгууль гээд баахан юм болоод ингээд үр дүн нь гараад ингэчихсэн байгаа. Тэгээд хэвийн явмаар байна шүү дээ, 8 жил олигтой сөрөг хүчингүй явлаа. Тэгээд энэ чинь болохгүй гээд энэ юмыг чинь дэлхий нийтээрээ ардчилал гэдэг зүйлийг чинь гаргаж ирээд, хамгийн боловсронгуй тогтолцоо нь энэ юм гээд. Тэр тусмаа Монгол Улсад хамгийн сайн нийцэх нь, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ганц нийцэж байгаа ийм тогтолцоо чинь өнөөдөр ардчилал шүү дээ. Үгүй ээ энэ юмаа амьдрал дээр хэрэгжүүлэхгүй ингэж байгаад ингэж явахаар чинь аягүй сулраад байна шүү дээ.

Цаашидаа энэ чинь аягүй эмзэг болж байна. Эдийн засгийн, гадна, дотнын нөхцөл байдал маш хүнд байна. Тэр бензин шатахуунаар хангаж чадах уу, үгүй юу, ямар болчихсон юм бэ? Удахгүй бензин шатахуун тасарна гээд яриад байх юм. Тэр нь үнэн ч юм уу, худлаа ч юм уу, тэр хангамж энэ тэрээ бэлдсэн юм уу, үгүй юм уу гэх мэтчилний. Энэ байдлаас болоод өнгөрсөн 2, хэзээ ч билээ дээ ган гачиг болж байх үед бол тэгээд нөгөө өвлийнхөө бэлтгэлийг хангаж чадаагүй шүү дээ. Маш олон мал алдсан, зуд болсон, маш их олон хүн ядуурал руу орсон зүүн аймагт. Ийм юмнаасаа тэгээд сургамж авдаггүй юм уу?

Г.Тэмүүлэн: Их л олон асуултууд л асуулаа даа. Яамнууд чиглэл чиглэлээрээ, саяын бензин түлштэй энэ Аж үйлдвэр, уул уурхайн яам, Эрдэс баялгийн яам бусад эдийн засгийн төслүүд Эдийн засгийн хөгжлийн яам. Хэн хариулах вэ? Гараа өргөөд яваарай. 6 номер.

Ц.Эрдэнэбат: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ бид нар 2024-өөс 28 он хүртэл үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа таны хэлсэн.../үг тасрав/

Г.Тэмүүлэн: Өөрийгөө танилцуулаарай, хэн билээ, ажлын хэсэг нэрээ танилцуулаарай.

Ц.Эрдэнэбат: Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам зөвлөх. Ганбат гишүүний асуултад хариулъя. Яг энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөхдөө яг таны хэлсний дагуу бүтэн бүлгийг болохоор хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гээд тэр нөгөө ард түмний засаглах эрхийг гэдэг агуулгын дээр нь нэр дээр нь оруулж өгсөн. Тэгээд энэ бүлэг дээр юу байгаа вэ гэхээр энэ дээр уншихаар төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Монгол үндэсний үнэлэмжийг нэмэгдүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад бодлогын нээлттэй, олон тулгуурт зарчмыг баримтална гэж агуулгаар нь туссан байгаа юм. Тэгэхээр миний бодлоор бол яг таны хэлсэн асуулттай холбоотой агуулгууд энэ 4 дүгээр бүлэг дээр ингээд тараагдаад орчихсон байгаа байх гэж бодож байна. Үлдсэн тодорхой сэдвүүдээр бусад яамнууд хариулах байх.

Г.Тэмүүлэн: 3 номер.

Л.Мөнхтүшиг: ГХЯ-ны ТНБД-ын албан үүрэг түр гүйцэтгэгч Мөнхтүшиг. Эрдэнэболд гишүүн болон Ганбат гишүүний асуултад дурдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай холбоотой асуудлаар товч хариулт өгье. ГХЯ-ны зүгээс УАБЗ-ийн ажлын албатай хамтраад сүүлийн 2 жил гаруй хугацаанд Монгол Улсын хөгжлийн гадаад таатай

орчныг бүрдүүлэх энэ чиглэлээр бас дүн шинжилгээ хийж байгаа. Тэгээд УАБЗ-ийн дэргэд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөх асуудлыг хариуцсан ажлын хэсэг байгуулагдаад сүүлийн 2 жил гаруй хугацаанд ажиллаж байгаа.

Эрдэнэболд гишүүний асуултад дурдсан энэ баримт бичгийг боловсруулахдаа сайтар дүн шинжилгээ хийх, энэ ажлын хэсэгт орж байгаа гишүүд хамгийн гол нь энэ судлаачдын оролцоог хангах гэдэг дээр бол бид онцгой анхаарч байгаа. ГХЯ-ны шинэ бүтцэд ч гэсэн дүн шинжилгээний хэлтсийг бол бодлогоор оруулж ирсэн. Мөн цаашилаад Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлоготой холбоотойгоор ГХЯ бүтцэдээ ч болон хүний нөөцдөө онцгой анхаарч байгаа энэ бодлогуудыг ингэж оруулж явж байгааг танд хэлье.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн болсон уу? 1 дүгээр заалт дууссан тул тогтоолын төслийн 2 дугаар заалттай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүд сайн нэрсээ өгөөрэй. Сая өмнөх асуулт дээр бас Шижир гишүүн, Болормаа гишүүдийн нэрс ороогүй байсан. Төхөөрөмж шинэ байгаа учраас бас нэлээн яагаагүй байх шиг байна. Нэрсээ оруулаарай. Батбаатар гишүүнээр тасалъя. Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Би эхний асуудалтай, одоо асуудалтай 2 дахь асуудлаа бол хамтатгаад 2 асуулт байна. Нэг нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас, нөгөөдөх нь Гадаад яамнаас. Эхнийх нь юу вэ гэхээр сүүлийн үед Ойрх Дорнод, Америк, Хятад, Тайвань, ингээд Ойрх Дорнод, Орос, Украин гээд ингээд дэлхий дээр геополитикийн нөхцөл байдлууд бас харьцангуй сайн биш бас урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна. Тэгээд энийг дагасан эдийн засаг удаашираад, Европын орнуудын үйлдвэрлэл, аж үйлдвэрлэлийн өсөлтийн бууралт, бууралт зэрэгтэй холбоотой дэлхийн улс орнууд ер нь

төсвөө аль болох танах тал руугаа ингээд эдийн засгийн бодлого төлөвлөлтөө хийгээд байгаа юм.

Гэтэл манай мөнгөний бодлого улсын төсвийн эдийн засаг 2 нь ингээд хоорондоо авцалдахгүй зөрүүтэй. Тэгээд үүн дээр бас Монголбанкны байр суурь ямар байдгийг бас мэдмээр байгаа юм. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуух нь бол юу вэ гэхээр бид нар нийтдээ үндсэндээ 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл эдийн засгийн тэлэлт чинь өөрөө тухайн үед 6 тэрбум байсан бол одоо ингээд тодотголтойгоо өнөөдөр 31 тэрбум болчихож байгаа юм, их наяд болчихож байгаа юм. Тэгээд яг хэрэглэгчдийн буюу яг иргэдийн худалдан авах чадвар энийг дагаад нэмэгдсэн үү гэхээр үгүй. 2018 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэг өрхийн хэрэглээ гээд дунджаар аваад үзэхэд 30 мянган төгрөгөөр ойр зуурын хэрэглээгээ авчихдаг байсан бол одоо энэ 60 мянга болчихсон ийм бас судалгаанууд байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам маань цаашидын төлөвлөлтөө юу гэж харж байгаа юм бэ гэдэг юм байгаа юм.

Нөгөө талаас эдийн засгийн аюулгүй байдал гэдэг бол өнөөдөр 1 улсаас хараат байгаа байдал дээр бол бид нар эдийн засгийн хараат аюулгүй байдлыг Эдийн засгийн яам нь юу гэж дүгнэж байгаа юм бэ? Нийт гадаад худалдаа маань өөрөө ихэнх, хэд, хэд шахуу урд хөрштэйгөө. Зөвхөн АНУ-тай гэхэд 360 сая орчим долларын л гадаад худалдаа хийж байна шүү дээ. Тэгээд нөгөө энэ мөрийн хөтөлбөр дээр чинь нөгөө Солонгорсон эдийн засаг гэдэг бид нарын аягүй гоё олон жил яриад байдаг юм байхгүй байна л даа. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн яам өөрөө энэ төлөвлөлтөө яаж хийж байгаа юм бэ?

Би зүгээр ганц, хоёр жишээ хэлэхэд жишээ нь сая газар тариалантай холбоотой юм яваад 450 мянган га-д улаан буудай тарьдаг байсан бол энэ жил

180 мянган га-д тарьсан байгаа юм. Тэгтэл ОХУ бол экспо бид нарт улаан буудай өгч байгаа, худалдаж байгаа улс орон байнга ийм хэмжээнд байж чадах уу гэдэг нэг асуудал үүснэ. Тэгэхээр гадаад нөхцөл байдал энийгээ яаж харж байгаа юм бэ? 2025, 2026, 2027 оны мөрийн хөтөлбөрт энэ чинь та нарт аягүй том хүндрэл болж ирнэ шүү гэдгийг 1 дүгээрт асуумаар байгаа юм.

Хоёрдугаарх нь Гадаад бодлогын яамнаас ер нь яах вэ намайг ажил хийж байхад Тамга дээр байж байхад Гадаад яаман дээр нэг мөнхийн л нэг асуудал байдаг нь дипломат төлөөлөгчийн газруудын асуудал. Тэгээд л ажилчдын нийгмийн хангамжийн асуудал гээд л ингээд л манай иргэд болохоор юу гэж боддог вэ гэхээр гадаадад байгаа дипломат төлөөлөгчийн газар л нэг тийм жаргалын газар гэж боддог. Гэтэл яг бодитоор бас энэ тийм ойлголт бас байдаггүй. Тэгээд энэ дээр бас ГЯЯ маань яаж ажиллаж байгаа юм бэ? Сая энэ төсвийн тодотголоор нэмэгдэж байгаа төсвийг харахаар үйл ажиллагаатай холбоотой л зардлууд ихэнх нь харагдаад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээрээ бас яаж анхаарч ажиллаж байгаа юм гэдэг ийм 2 асуулт байна.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүний асуултад хариулъя. 2 номер.

И.Батхүү: Эдийн засаг? хөгжлийн яамны ТНБД Батхүү. Шижир гишүүний асуултад хариулъя. Бид нар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах аливаа эдийн засгийн бодлогын асуудлуудыг гаргахдаа байнга энэ гадаад орчны шинжилгээ хийж ажиллаж байгаа. Энэ дээрээ ч гэсэн холбогдох судалгааны байгууллагууд, бусад яамнууд, дипломат төлөөлөгчдийн газар олон төрлийн эх сурвалжийг ашигладаг. Энэ 24-өөс 28 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарч болох болзошгүй эрсдэлүүд ер нь том утгаараа авч үзээд хэд хэдийг ингэж гаргасан байгаа.

1 дүгээрт нь бол түүхий эдийн эрэлт үнэ буурах эрсдэл байгаа. Монгол Улсын эдийн засаг өөрөө уул уурхайн хамаарал өндөртэй, экспортын голлох бүтээгдэхүүн бол уул уурхайн бүтээгдэхүүн байдаг. Гол худалдан авагч зах зээл болох БНХАУ-ын зах зээлийн эдийн засгийнх нь өсөлт удааширах, үл хөдлөх хөрөнгийн салбар гэх мэтчилэн эдийн засгийн дэд салбаруудын асуудлуудыг байнга харж байгаа. Зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын зах зээл дээрх үнэ буурах эрсдэлийг бас ажиглаж байгаа.

Дээр нь эрчим хүчний дутагдлын асуудал байгаа. Эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай байгаа нь бол эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжүүлэхэд бас хязгаарлагч хүчин зүйл болдог. Тэгээд энэ өөрийнх нь салбарынх нь суурилагдсан эх үүсвэрийн техник хэрэгслийн эвдрэл гэмтлээс үүдэлтэй нийлүүлэлтийн таслахаар бол бас онцгой нөхцөл байдлууд үүсэх эрсдэлтэй байгаа. Цахилгаан дамжуулах агаарын шугамуудын осол гэмтлүүд бас бас эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ.

Дэлхийн эдийн засгийн эргэлт өөрөө бас таны сая дурдсан сая геополитикийн нөхцөл байдлууд бас амаргүй, ер нь их өрнөл нь их хурдацтай явагдаж байна. Тухайлбал ОХУ Украйны нөхцөл байдал, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөнүүд байна, БНХАУ Тайванийн бас сөргөлдөөн байгаа. Түүхий эдийн үнийн нийлүүлэлт бас газрын ховор элемент бусад төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэлт дээр бас гаргаж байгаа улс орнуудын ялгаатай байр суурь хоорондоо сөргөлдөх асуудлууд байна.

Дээр нь нэмэгдээд бас үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбогдож яригдаад байгаа юм бол хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдлын асуудлууд бас Монгол Улсын энэ ЗГ-ын үйл

ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бас томоохон эрсдэлүүд учруулахаар байгаа. Дээр нь уур амьсгалын өөрчлөлтүүд бас байгаа. Байгалийн гамшигт үзэгдэл, ган зудын давтамж, нөлөөллийн хэмжээ, өвөлжилт, хаваржилтын хүндрэл гээд эдгээр эрсдэлүүдийг аль болох шийдвэрлэх, ЗГ өөрөө контрол тавьж болох арга хэмжээнүүдээ хэрэгжүүлэх талаасаа үйл ажиллагааны хөтөлбөрөө бас тодорхой хэмжээнд бичсэн гэж ойлгож болно.

Эрчим хүчний чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, хөдөө аж ахуйн салбар бусад уул уурхайн бус салбаруудын өрсөлдөх чадварыг сайжруулах, бодлогын реформууд хийх, гадагшаа экспортлох зах зээлийг нь тэлэх, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах асуудлууд бас тусгагдаж байгаа. Улс орнуудын хамаарлыг бууруулах үүднээс бас энэ газрын тос, уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн эрэлт.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Бусад асуултуудад нэмж хариулъя. Хаанаас яах вэ? Гадаад яам Мөнхтүшиг дарга 3 номер.

Л.Мөнхтүшиг: ГХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхтүшиг. Шижир гишүүн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр өнөөдрийн байдлаар ГХЯ, Дипломат төлөөлөгчийн газарт нийтдээ 50 гаруй, 50 дипломат төлөөлөгчийн газартай ажиллаж байгаа. Таны саяын дурдсанчлан Дипломат төлөөлөгчийн газрын ажлын ачаалал, ажилтнуудын нийгмийн асуудал бол хурцаар тавигдаж байгаа. Өнөөдөр ГХЯ-ны орон тоо, цалин ялангуяа орон тооны хувьд болбол бид социализмын үетэйгээ үндсэндээ адилхан шахуу явж байгаа.

Тэгэхээр өнөөдөр болбол Монгол Улс НҮБ-ын гишүүн бүх оронтой дипломат харилцаатай. Одоо олон улсын нөхцөл байдал, геополитикийн

зөрчилдөөнтэй холбоотойгоор гадаад харилцаа, гадаад бодлогын чиглэлээр бид маш идэвхтэй ажиллах зайлшгүй шаардлагатай энэ цаг үед ажиллаж байна. Тэгэхээр энэ хүрээнд бол ГХЯ-ны зүгээс шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. Өнгөрсөн онд бид ҮАБЗ дотоод албаны энэ чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолтой холбоотой асуудалтай бас фронтод ажиллаж байгаа ажилтнуудаа болбол онцгой анхаарах ёстой гэдэг энэ болбол зөвлөмжийг бол бид авсан. Тэгээд энэ хүрээнд болбол эхний ээлжид ГХЯ хүний нөөцдөө онцгой анхаарах, ингэхдээ байгаа нөөц боломжоо хамгийн оновчтойгоор ашиглах, хүн хүчээ оновчтой ашиглах гэдэг дээр онцгой анхаарч байна.

Дараагийн ээлжид болбол орон тоогоо нэмүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг дэмжих замаар төвдөө буюу Монголдоо ажиллаж байгаа дипломатууд дипломат төлөөлөгчийн газруудад ажиллаж байгаа ажилтнууд энэ их огцом эрс ялгааг аль болох бууруулах энэ чиглэлд бас хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодруулъя. Энэ нөгөө миний өмнөх хуралдаан дээр бас хэлээд байгаа юм манай эрх барьж байгаа МАН-ын мөрийн хөтөлбөр дээр бас байгаа байхгүй юу. Тэн дээр юу байгаа вэ гэхээр маш тодорхой бичсэн байдаг юм байна лээ өмнөтгөл дээрээ. Монгол улсын өнгөрсөн 30 хэдэн жилийн хугацаанд хийсэн урт ба богино хугацааны бүх мөрийн хөтөлбөр, хөгжлийн бодлогууд нь хэрэгжээгүй гэдэг бүүр яг Ардын намын мөрийн хөтөлбөр дээр байгаа. Тэгээд тэн дээр 96 онд батлагдсан мөрийн хөтөлбөр ч тэр, 2018 онд батлагдсан 3 тулгуурт хөгжлийн бодлого ч тэр, одоо бид нарын хэлэлцээд байгаа мөрийн хөтөлбөр ч тэр

ерөнхийдөө та бидний ингээд яриад байгаа бүх үг, өгүүлбэр яг үүгээрээ л суучихсан байгаа. Жоохон жоохон л өөрчлөгдсөн байгаа. Яг үүгээрээ суучихсан байгаа шүү. Та хэд хараарай. Нөгөө агуулгууд нь л агуулга нь хэвээрээ, өгүүлбэрүүд нь өөрчлөгдсөн.

Тэгээд бид нар дахиад 33 дахь жил дээрээ, 34 дэх жил дээрээ дахиад л нэг ийм хөгжлийн хөтөлбөр гээд л нэг юм батлах гээд л хэдүүлээ сууж л байна л даа. Тэгээд сая Эдийн засаг, хөгжлийн яамны хариулт дундаа хөгжлийн хөтөлбөр нь урт хугацаанд тогтвортой байна гээд хариулж байна лээ. Гэтэл одоо бид нар чинь сүүлийн 3 жил 8 удаа өөрчилчихсэн шүү дээ. Тэгээд энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам энийгээ өөрчлөхгүй гэдэг баталгаа юу байгаа юм бэ? Өмнөх мөрийн хөтөлбөрүүд дээр хийсэн дүгнэлт юу байгаа юм, үр дүн юу байгаа юм бэ? Би өмнө нь бас асууж байсан тэр ДНБ бүтээгдэхүүнийг 10 мянган долларт хүргэхийн тулд жил бүр 14 хувийн өсөлттэй эдийн засаг явна шүү дээ. Тэгтэл тийм улс дэлхий дээр байна уу гэдэг эхний асуудал.

2 дугаарт 2024 оны улсын төсөв өөрөө 27 хувьд тэлсэн. Гэтэл дайн хийж байгаа Орос 23 хувь тэлсэн шүү дээ. Тэгээд бид нар ингээд дайн хийж байгаа улсаас илүү улсын төсвийн тэлэлттэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам нь цаашид гарах эрсдэлээ юу гэж харж байгаа юм бэ, яаж дүгнэж байгаа юм бэ? Нэг мөрийн хөтөлбөр, хөтөлбөртөө тараачихсан заалтуудыг уншчихсан л даа. Тэрийг нь энд хариулт болгож авмааргүй байна. Яг энэ дээр яамны бодлогын баримт, яамны бодлого нь өөрөө яаж явж байгаа юм бэ, яаж харж байгаа юм бэ гэдгийг уг нь тодорхой би ингээд 2, 3 хурал дамнаад л асуугаад яваад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Их тодорхой асуулт л асуулаа. Батхүү дарга хариулъя номер 2.

И.Батхүү: Шижир гишүүний нэмэлт асуултад хариулт өгье. Нэг хүнд ноогдох ДНБ-ийг тооцохдоо нэрлэсэн дүнгээр, бодит дүнгээр гэж 2 янзаар тооцдог байгаа. Бодит эдийн засгийн өсөлтийг 24 онд 5,6 хувь, 25 онд 8 хувь, 26-аас 28 онд 6,5 хувьтай өснө гэж Эдийн засаг, хөгжлийн яамнаас төсөөлж байгаа. Нэрлэсэн ДНБ-ий хувьд жилд дунджаар 14-өөс 15 хувиар өснө гэж, Дэлхийн ихэнх улс орнууд бол нэрлэсэн үнээрээ бол өндөр өсөлттэй байдаг. Олон улсад бол эдийн засгийн өсөлтийг ярихдаа бодит үнээр ярьдаг учраас дандаа бага хувь хэмжээнүүд яригдаад байдаг юм.

Манай төсөөллөөр бол нэрлэсэн ДНБ 2023 онд 70 их наяд байгаа, 24 онд 79, 28 онд 132 их наяд төгрөг хүрнэ гэсэн тооцоололтой байгаа. Энийгээ доллароор авч үзэх юм бол 23 онд 20 тэрбум доллар гэх мэтчилэн ингээд 28 онд 39 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоотой байгаа. Энэ дээр долларын ханшаа бид нар яг одоо ЗГ-ын гаргасан зорилтын хүрээнд барьж явах юм бол таны дурдсан тэр нэг хүнд ноогдох ДНБ ам.доллароор 10 мянган долларт хүрнэ гэсэн зорилт нь бол боломжтой зорилт байгаа. Зүгээр математик агуулгаараа шууд өсөлтийг нь тооцох юм бол жилд 14 хувь гэдэг тооцоолол гарч байгаа байх.

Энэ дээр бол эдийн засгийн бодлогоо тууштай авч яваад, гадаад валютын нөөцийг алдахгүйгээр ер нь 10 тэрбум долларт хүргэнэ гэдэг зорилт нь бол цаад агуулгаараа ам.долларын ханшийг өсгөхгүй байх, төгрөгийн ханшийг тогтвортой барих гэсэн агуулга байгаа. Энэ дээр нэмээд инфляцыг бас бага түвшинд барих ёстой. Бид нарын хувьд бол 3 хувийн гэсэн зорилт тавьж байгаа. Шат дараатай 3 хувь хүртэл буулгана гэсэн зорилт тавьж байгаад, салбаруудад эдийн засгийн реформ хийж байгаатай холбоотой бас үнийн дарамт үүсэх эрсдэл байгаа учраас 5 хувь, тэгээд сүүлдээ бол ер нь бол нэг оронтой тоондоо барина.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн болсон уу? Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа, бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Би маш тодорхой асуултууд асууна, тэгээд хариулаад өгөөрэй. Монгол Улс бол газар нутгийн хувьд хөрш орнуудтайгаа ямар нэгэн маргаан байхгүй. Гэхдээ ОХУ-тай хиллэж байгаа энэ газар нутгийн асуудал дээрх НҮБ-д бас зохих журмын дагуу бүртгүүлэх асуудал явж байгаа. ОХУ-тай хамтарсан хил шалгалтын асуудал ямар түвшинд явж байгаа вэ? Энийгээ хурдан эрчимжүүлж бас тодорхой процедурын дагуу энэ хилийг Нэгдсэн Үндэстний Байгууллагууд бол албан ёсоор бүртгүүлэх ажлыг бас хийх бололцоо энэ 4 жилд гарч байгаа юу гэдэг зүйл дээр бас хариулт өгөөч.

2 дугаарт энэ төвийн эрчим хүчний систем гээд говийн аймгууд Дархан, Эрдэнэ, Сэлэнгэ, Төв аймаг, Улаанбаатар гээд маш том эдийн засгийн төвлөрлийн энэ хэсгүүдийг хамарч байгаа. Энэ дээрээ яг найдвартай эх үүсвэрүүдийг барих асуудлууд нь таг гацдаг, улс төрждөг, гадна, дотнын эрх ашгууд орж ирдэг. Харин энэ дээрээ төвийн эрчим хүчний системийн найдвартай эх үүсвэрүүдийг дарамт болдог, унагаах гэж байгаа, системийн хувьд доголдуулах гэж байгаа сэргээгдэх эрчим хүчний төслүүд ямар нэгэн лоббигоор маш их хэмжээний байдлаар орж ирж байна. Энэ дээр ямар баланс барьж байгаа юм бэ? Энэ ЭХЯ энийг төлөвлөх гэхээсээ илүүтэй Эдийн засгийн яамны лобби яваад байна уу?

Сая ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр чинь битүү тийм нарны эрчим хүчний эх үүсвэрүүд. Бид энэ Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийнхаа хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, цаашидаа байгуулсан энэ гэрээнүүддээ нэмэлт, өөрчлөлт оруулах уу, үгүй юу гэдэг асуудлаа шийдэж байж бас энэ зарим томоохон сэргээгдэх эрчим хүчний ялангуяа нарны, салхины энэ

зүйлүүдийг авч явмаар байна. Энийг би Чойжилсүрэн сайдад бүүр тодорхой хэлсэн. Гэтэл яг энэ дээр өнөөдөр хэрэглэгчдийн нуруун дээр энэ нүүрсээр ажиллаж байгаа цахилгаан станцууд нь эдийн засгийн хувьд алдагдалтай, тэгээд либералчлах энэ яг зааг дээр маш их хэмжээний ийм төслүүдийг хэрэгжүүлнэ гээд энэ эрчим хүчний либералчлалыг зогсоох өнгө аягтай ийм төслүүд цаана нь ер нь шургагдсан байна. Энэ дээр яг тодорхой хариулт авъя.

2 дугаарт НҮБ-ын бүх орнуудтай ерөнхийдөө дипломат харилцаа тогтоож байгаа. Тэгэхдээ бид нар Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага эргээд НҮБ түүний төрөлжсөн зарим байгууллагууд, ялангуяа энэ Швейцар, Тайланд дахь энэ элчин сайд, төлөөлөгчийн газрын орон тоог зоригтой нэммээр байна. Ингэж байж бид нар түүн дээрээс шинэ мэдлэг, цаашидаа ямар чиг баримжаатай эдийн засаг явах гээд байна гэдэг зүйлийг харах байхгүй юу. Ерөөсөө хүн нь хүрэлцдэггүй. Жишээ нь бид нар вакцин хайж бусад орнуудаар гүйхээсээ илүүтэйгээр Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр эмийн ямар патент хэн бүртгүүлэх гэж байгаа дээр ярилцаж чадвал бөөний үнээр хамгийн түрүүнд авах бололцоотой.

Гэтэл Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр бид нар тоодоггүй. Өнөөдөр Монгол Улс нэрсийн дарааллаар тэргүүлэх Ази Номхон далайн бүсийг тэргүүлэх бололцоо бүрдэж байгаа мөртөө энийгээ бид нар ашиглахгүй ингээд pass хийх гэж байгаа байхгүй юу. Маш харамсалтай. Энд дэлхийн урлаг, соёл.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя 3 номер.

Л.Мөнхтүшиг: ГХЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхтүшиг Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Тэр хөрш орны, хөрш орнуудтай газар нутгийн маргаан

байхгүй. Тэрэнтэй холбоотой асуултад хариулахад Монгол Оросын хилийн хамтарсан шалгах комисс байгуулагдсан. Өнгөрсөн оноос эхлээд үйл ажиллагаа явуулж байна. Ирэх жил хойд хилээ бид хянан шалгаж тэмдэглэжүүлэх ажил дуусна. Энэ ажлын явц өнөөдрийн байдлаар 75 хувьтай явж байна. Тэгэхээр ирэх он дууссаны дараа таны хэлсэн хилээ шалгаж, 2 тал баталгаажуулж, тэмдэг шинэ тэмдэглэгээгээ хийчхээд, тэрний дараагаар олон улсад бүртгүүлэхтэй холбоотой асуудлаа хийхээр төлөвлөж байгаа.

Таны сүүлийн дурдсан асуултад хариулахад ГХЯ нь хүний нөөцийнхөө бодлогод онцгой анхаарч байгаа гэдгийг би түрүүн дурдсан. Энэ хүрээндээ орон тоогоо мэдээж нэмэгдүүлэхийг зорьж байгаа. Гэхдээ тэрийг хүлээхгүйгээр энэ дипломат албанд ажиллаж байгаа хүн бүр цаг үеэ маш, ухаарч, хандлагаа өөрчлөх цаг болчихсон байгаа. Дипломат алба өөрөө. Тэгэхээр энэ шинэчлэлийг бол хийж байгаа. Тэгэхээр бид нээлттэй эх сурвалжаас ажиллахаас илүүтэй одоо аль болох ийм идэвхтэй дипломат үйл ажиллагаа явуулах энэ цаг мөч нь болсон гэдэг утгаараа ГХЯ-н дээр төсөв болон бусад ажиллах аргачлал хэлбэр дээр шинэчлэлийг хийж байгааг бас танд дуулгая.

Тэгээд Тайланд, Швейцарт бол та хэлсэн яг Нэгдсэн Үндэстний Байгууллагуудын бас бүсийн төвүүд байдаг. Энэ дээр бид байгаа хязгаарлагдмал хүний нөөц орон тоогоо яаж хооронд нь оновчтойгоор хуваарилах вэ гэдэг дээр эхний ээлжид анхаарна. Алсдаа хүний нөөц орон тоогоо нэмээд, цалингаа нэмэгдүүлэх энэ боломжуудыг ЗГ-тайгаа тэр хүрээндээ яриад шийдэхээр төлөвлөж байгаа.

Г.Тэмүүлэн: ЭХЯ 6 номер дээр Тавинбэх дарга.

Н.Тавинбэх: ЭХЯ ТНБД. Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Энэ удаагийн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт сэргээгдэх эрчим хүчний түүн дотроо нар, салхины эх үүсвэр 4 том төслийг хэрэгжүүлэхээр нийт суурилагдсан хүчин чадал нь дотоодод нийлүүлэхээр 800мвт, экспортын зориулалттай 500мвт-ын төслүүд орж ирсэн. Бид цэвэр ногоон технологид шилжих ёстой. Энэ шилжилтийн ажлыг бид бас шилжилтийг хийхдээ болоод шилжсэний дараах хэрэглэгчдийн цахилгаан хангамжид эрсдэл үүсэхгүйгээр хийх ёстой. Бас ийм алдаа оноо манай улсад төдийгүй дэлхийн олон нийтэд гарч байна.

Манай улсын хувьд бас онцлогтой. Хүйтний улирал удаан хугацаанд үргэлжилдэг хүйтэн. Тийм учраас бид энэ шилжилтийг болбол нягт нямбай бусдаас илүү хийх ёстой. Манай улсын эрчим хүчний одоо байгаа системд бас онцлог байна. Ялангуяа тогтвортой үйлдвэрлэл явуулдаггүй нар, салхины эх үүсвэрүүдтэй зохицож ажиллах, тэдний үйлдвэрлэлийн хэмжээ өөрчлөгдөх үед орон зайг нөхөж ажиллах тийм боломжтой эх үүсвэрүүд алга. Дийлэнх эх үүсвэрүүдийн дийлэнх болсон нүүрсний технологитой эх үүсвэрүүд бол ийм чадамжгүй байдаг. Энэнээс болоод бид хүссэн хэмжээгээр сэргээгдэх түүн дотроо саяын хэлдэг хувьсах нар, салхины эх үүсвэрүүдийн оролцоог нэмэгдүүлэх бас шилжилтийг хурдан хийх бас боломж технологийн боломж муутай байгаа юм.

Өчигдөр энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгагдсан нар, салхины эх үүсвэрүүдийг болбол яг миний түрүүний хэлдэг хүчин чадлаар оруулбал бид нар тохируулга хийж чадахгүй. Миний түрүүний хэлдэг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Би яах вэ Гадаад яамнаас бас 2, 3 зүйлийг анхаараач гэж байгаа юм. Сангийн яам бас энэ дээр

анхаараач. Ирэх 4 жил Монгол Улс НҮБ болон түүний төрөлжсөн эвсэл бол ОУБ-даа хэчнээн тайлан хамгаалах вэ? Энэ хамгаалах дээр ямар бүрэлдэхүүн оролцох вэ? Энэний зардлыг ерөнхийдөө гадаад харилцааны нэгдмэл бодлогын хувьд Гадаад хэргийн сайд дээр Сангийн яам тавих талаас анхаараач. Бид хэд ковидын үеэр яах вэ цахимаар хамгаалаад их давуу талтай байсан боловч одоо ир гэдэг. Ирэх гээд тэгэхээр зардал мөнгө байдаггүй энэ доогуур чинь ингээд тэгээд Монгол Улсын тайланг 4 жилдээ нэг очиж хамгаалах асуудал дээрээ бөөн зардал мөнгөний проблемтой. Тэгээд ерөөсөө энэ бид хэд Хэмнэлтийн хууль гэдэг зүйлээр ерөөсөө гадаад зардал байхгүй гээд нэг баахан ингээд хий ингээд хийрхчихсэн. Тэгээд ингээд яв гэдэг. Ингээд нэг бас нэг асуудлууд үүсдэг шүү. Энийг 1 дүгээрт анхаарчих.

2 дугаарт энэ олон улсын гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор энэ орчуулгуудыг зөв болгох, 2 дугаарт энэ мэдээллийн сан үүсгэж ер нь өмнө нь явуулж байсан тайлангуудаа архивлаж үлдээх энийгээ баяжуулаад хүргүүлдэг тэр систем рүү явмаар байна.

2 дугаарт энэ эмийн квотыг халаач. Ерөөсөө энэ эмийн квотын цаана чанаргүй эм, хуурамч эм орж ирдэг. Харин эмийг импортоор оруулж ирж байгаа компаниудыг оруулж ирэх эмийг нь квот хэчнээн хэмжээ болон аль боомтоор хэзээ орж ирэх тэр мэдээллийг нь 12 сардаа авчихдаг ийм байдлаар зохицуулж болдоггүй юм уу? Яг ингээд чанартай эм хэрэглэж болдоггүй дандаа квот тогтоочихсон. Яг энэ квотын цаана чинь угаасаа угаасаа л ийм нөхцөл байдлууд өрсөлдөөн байхгүй, энэ зах зээлийг цөөн хэдэн компаниуд авчихсан. Нэрлэж болно шүү дээ. Бүгд улс төрчид байж байгаа. Тэгчхээд ингээд Монгол Улсын нийт валют ч бас урсаж байгаа. 2 дугаарт иргэдийн эрүүл мэндийн асуудал байгаа. Тэгээд бид хэд гадаад улсад очоод ядаж толгойны эм уухад ямар байдаг билээ? Эндээс аваад ухаар ямар байдаг билээ?

Тэгээд энэ нэг эмийн асуудлыг нэг жоохон либерал, арай өөр өнцгөөр квот тогтоогоод чи оруулж ир гэх биш, ерөнхийдөө лицензтэй компаниуд нь оруулж ирье. Тэгэхдээ энийгээ урьдчилж.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал гэж ойлгох уу. Эмийнх дээр ЭМЯ-ны ТНБД Очирбат, 6 номер.

Д.Очирбат: Гишүүний асуултад Очирбат ЭМЯ-ны ТНБД. ЭМЯ эм, эмнэлгийн хэрэгсэл дээр нэлээдгүй бас анхаарч байгаа. Өнгөрсөн жилийн хугацаанд Чинбүрэн гишүүн эмийн сонсгол хийсэн. Энэтэй холбогдуулаад ч мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль батлагдан гарсан. Орон нутгийн болон төрийн өмчийн худалдан авалтынхаа хуульд бид нар өөрчлөлтүүдийг хийсэн байгаа. Өөрөөр хэлбэл хуучин бид нар Тендерийнхээ хуульд байсан хямд үнэтэй буюу 1 дүгээрт нь хямд үнэтэй, 2 дугаарт нь болбол заавал эх орондоо үйлдвэрлэгч байдаг байна гэсэн энэ Тендерийн хуульдаа өөрчлөлт оруулсан. Ингэснээрээ бид энэ жилээс өгсүүлээд ЭМЯ-наас олон улсад жишигт хэрэглэгдэж байгаа, олон улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа, олон улсын чанартай тэр түүхий эд, эмийг шууд худалдан авалт хийхээр бэлтгэл ажлыг хангаад НҮБ-ын Хүн амын сантай хамтран ажиллаж байгаа юм.

Хамгийн эхний худалдан авалтыг бид 12,5 тэрбум төгрөгөөр элэгний Д вирусийн эмийг бол бас иргэддээ худалдаж эхний 100 эмийг бол худалдаж авч өгсөн. Цаашидаа түрүүн хэлсэнчлэн шууд худалдан авалтаар ЭМЯ-наас хамгийн чанартай ОУБ-ын түвшинд тэр нөгөө чанарын өндөр эмийн хяналттай байгууллагуудаас худалдаж авдаг тогтолцоог мөрдөж хэрэгжүүлж ажиллана. Мэдээж дундуур нь болбол зарим нэгэн зохицуулалттай эмүүд бол аж ахуйн нэгж компаниуд оруулж ирдэг тэр зохицуулалтаараа оруулна.

Г.Тэмүүлэн: Амгаланбаатар гишүүн асуултаа асууя.

О.Амгаланбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд гишүүдийн асуултад хариулж байгааг сонсохоор энэ геополитикийн асуудал хэцүү байна, энэ дэлхийн дайны асуудал хэцүү байна гэдэг ийм л юм ерөнхийдөө их хариулж байна л даа. Тэгэхээр яг үнэхээр нөгөө манай хөдөөгийнхөн ярьдаг л даа. Үнээ сувайрахад бух буруутай гэдэг түүнтэй адилхан тэгвэл тэр геополитик гэж яриад байгаа тэр дайны чинь Орос Украины асуудал чинь тэр Ойрх Дорнодын асуудал чинь яг энэ Монгол Улсын эдийн засагт, энэ Монгол хүний, Монгол Улсын хөгжилд яг ямархуу хэмжээний нөлөөлөл үзүүлээд байгаа юм бэ гэдэг дээр яг хийгдсэн судалгаа та нарт байхгүй шүү дээ. Яг ийм нөлөө үзүүлж байна гээд. Тэгээд бүх юмыг нэг ингээд нэг буруутныг дандаа гаднаас хайдаг, буруутан чинь энэ дотроо байгаа шүү дээ.

Харин ч эсрэгээрээ 2 бух ингээд хооронд нь хоорондоо мөргөлдөж байхад хажууд нь нохой ч байдаг юм уу хуцаж байхад болбол огт тоодоггүй шүү дээ. Тэгэхээр энэ чинь Монгол Улсад харин ч эсрэгээрээ их эерэг ийм нөлөөлөл үзүүлнэ. Тэгэхээр та хэд тэр юмыг дандаа ийм нөгөө буруутныг бусдаас хайж байснаас энийгээ илүү давуу тал болгох ийм боломж болбол байгаа юм гэдгийг бол энд хэлье.

Тэгээд 2016 онд нэг Монгол хүүхэд энэ манцуйтай хүүхэд 15 сая төгрөгийн өртэй шүү гээд ингээд тухайн үед энэ МАН ийм сонгуулийн сурталчилгааг хийж байсан. Тэрнээс хойш 8 жилийн дараа өнөөдөр нэг Монгол хүн тэр манцуйтай хүүхэд чинь 35 сая төгрөгийн өртэй болчихсон. Нэг жилд 1 тэрбум долларын өрийг нэмээд ингээд тавиад явчихсан байж байгаа шүү дээ. Тухайн үед тэр эхний 4 жил ч гэдэг юм уу, энэний чинь зөвхөн хоёрхон жил гаруй нь л тэр ковидын үе байсан байх. Тэгээд ингээд

бусдаас бурууг хайдгаа болимоор байна гэдгийг бол хэлье.

Тэгээд энэ БХЯ-наас бас асууя. Ингээд сая яриад байгаа дайн болоод байна. Энэ батлан хамгаалах тогтолцоо чинь бол одоо яг социалист тогтолцоогоор ингээд гагцхисан байж байгаа шүү дээ. Энийг энэ дэлхийн энэ дайнаас харж байгаад яаж хурдан өөрчлөх вэ гэдэг тэр зүйлээ оруулж ирэхгүй бол би аймгийн Засаг даргаар 2 удаа сонгогдон ажиллаж байна. Энэ орон нутгийн хамгаалалт гэдэг зүйл болбол нэг нэр төдий цаасан дээр л байгаад байдаг. Энийгээ маш хурдацтай өөрчлөөд тэр баг цэргийн зохион байгуулалтад оруулах юм уу энэ тал дээр энэ үйл ажиллагааны хөтөлбөрт гэдэг юм уу юу ч бараг шахуу алга. Дөнгөж нэг ийм нэг дурдчихсан л байж байна. Тэгэхээр энийгээ тодорхой болгоод, маш яаралтайгаар энийгээ өөрчлөхгүй болбол энэ батлан хамгаалах салбар чинь болбол ерөөсөө огт шинэчлэгдэхгүй байна гэдгийг болбол хэлье.

Тэгээд дээр нь энэ Эдийн засгийн хөгжлийн яамнаас асуух нь бид нарын яг энэ Монгол Улсын хөгжилд хамгийн саад учруулаад байгаа зүйл чинь энэ засаг захиргааны социалист бүтэц юм биш үү? Тэгэхээр энэ дээр та нарын хийсэн ямар судалгаа байна вэ?

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам хариулъя. Номер 2, номер 2 ТНБД Батхүү.

И.Батхүү: Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Улсын Их Хурлаар батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлэг бол бүсчилсэн хөгжлийн асуудлаар бичигдсэн байгаа. Бүсчилсэн хөгжлийн асуудал нь бол өөрөө яг эдийн засаг, нийгмийн бүхий л салбар, байгаль орчны, эдийн засгийг төрөлжүүлэх гэх мэтчилэн олон талын өнцгөөс Монгол Улсын түүх

соёл, байгалийн нөөц, дэд бүтцийн холболт, бэлэн байдал, хүн амын бүтэц гэх мэтчилэн олон талаас нь хараад яг эдийн засгийн хөгжлийг харсан тийм үзэл баримтлалын дагуу бичигдэж байгаа.

Энэ хүрээндээ бас засаг захиргааны хувьд бас тухайн нэг аймаг сумын хөгжлийн асуудал гэхээсээ илүү хамтарсан байдлаар бүсийн хөгжил, тухайн бүс дотроо болон бусад гадаад зах зээлүүд рүү ямар боомтоор, ямар замаар холбогдох вэ, яаж бүс орон нутагтаа боловсруулж байгаа бүтээгдэхүүнээ гаргах вэ, яаж хамтарч хөгжих вэ гэдэг асуудлуудыг хөндсөн байгаа. Яг энэ бүсчилсэн хөгжил дээр жишээ нь нийслэлийн хэмжээнд бол бас тийм засаг захиргааны тодорхой хэмжээний өөрчлөлтийн асуудлууд яригдаж байдаг. 20 минутын хот гээд концепцын хүрээнд тодорхой жижиглэсэн зохион байгуулалтаар бас ийм иргэдэд хамгийн ойр зайд бүх төрлийн нийгмийн, төрийн үйлчилгээ авах боломжоор хангана гэсэн асуудлууд явагдаж байгаа.

Сая бас түрүүчийн асуултуудад нь дурдсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бас тодорхой засаг, захиргааны өөрчлөлтийн асуудлуудыг бас би заалтаар нь танд уншаад өгье. Асуултад хариуллаа.

Г.Тэмүүлэн: Амгаланбаатар гишүүн нэмж тодруулах уу? Батлан хамгаалах 6 номер.

Д.Ганхуяг: БХЯ-ны ТНБД Ганхуяг. Гишүүний асуултад хариулъя. Орон нутгийн хууль Орон нутгийн хамгаалалтын тухай хууль батлагдсанаараа бид өнөөдрийг хүртэл 10 гаруй аймагтай орон нутгийн хамгаалалтыг Засаг даргын удирдлага дор БХЯ-наас дэмжлэг үзүүлээд бид бол явж байгаа. Энэ орон нутгийн хамгаалалтад бол Хамгаалалтын хуулиар зохион байгуулагдаж байгаа энэ ажиллагаа нь бол маш их үр дүнтэй. Ард иргэдийг өөрсдийнх нь галт зэвсэг, унаа

хөсөгтэй нь авчирч цэргийн бэлтгэлд сургаж ингэж явж байгаа.

Үүнтэй холбогдолтойгоор бид 3 намын хөтөлбөрт 4.4.3-д зэвсэг, техникийг шинэчлэх мөн 4.4.3.3-д батлан хамгаалах тогтолцоо гэдэгт орон нутгийн хамгаалалтын талаар бол тусгасан байгаа. Мөн орон нутгийн хамгаалалттай холбоотойгоор бид бүтцийн өөрчлөлтөөр БХЯ-н дээр Орон нутгийн хамгаалалтын газар гэж шинээр бас байгуулсан. Ингээд бүтцийн өөрчлөлтөө хийж эхэлж байна.

Өнгөрсөн жил зэвсэгт хүчний зэвсэг, техникийн бодлогыг хуульчлан Их Хурлаар батлагдсан. Бид Аюулгүй байдлын зөвлөл нууц байдлаар зэвсэг техникийн шинэчлэлтэй холбоотой төсөв зардлыг бол гаргаад танилцуулаад явж байгаа. Сүүлийн хэдэн жил бол энэ салбарт бол зэвсэг техникийн шинэчлэлд бол мөнгө хуваарилагдаагүй. Бид тэгэхдээ зүгээр суугаагүй өнөөдөр гадаадын зээл тусламж, тусламж хандиваар бол 1 их наяд орчим зэвсэг, техникийн шинэчлэлийг өөрсдийн бололцоогоороо хийгээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Амгаланбаатар гишүүн нэмж тодруулъя.

О.Амгаланбаатар: Дахиад БХЯ-наас асууя. Ер нь энэ иргэдээ бүгдийг нь зэвсэгжүүлэх, энэ буудлагын төвүүдийг маш олноор байгуулах, энэ ард иргэдийгээ бас энэ болзошгүй аюулд яг бэлэн байлгах тал дээр болбол энэ хөтөлбөр дээр чинь ерөнхийд нь тусгаад та нар бол задлаад явчихна гэж ингэж л яриад байгаа юу? Ер нь энэ зайлиггүй хийх ёстой юу яг ийм зүйлийг яг өнөөдрийн цаг үед гэж би асууя.

Тэгээд бас өмнө нь болохоор Монголчуудын хувьд энэ буу зэвсэг дээр маш ийм хатуу, жишээлбэл иргэддээ буу байлгаж болохгүй ч гэдэг юм уу, энэ буудлагын төв Монгол Улсад энэ Улаанбаатарт ганц, хоёр газар л байх

шиг байна. Ийм уралдаан тэмцээн бол маш багаар явдаг. Гэтэл өнөөдөр энэ жинхэнэ та нарын яриад байгаагаар энэ геополитик, энэ том гүрнүүдийн асуудлаас болоод энэ бол зайлиггүй болж таарч байх шиг байна. Тэгэхээр үүн дээр болбол таны байр суурь болон танай яамны байр суурь яг ямархуу байгаа вэ?

Г.Тэмүүлэн: Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя.

Д.Ганхуяг: БХЯ-ны ТНБД Ганхуяг. Гишүүний асуултад хариулъя. Энэ үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотойгоор бид энэ Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг бол өмнө нь баталчихсан. Орон нутгийн хамгаалалтаар бол ард иргэдийг БХЯ-ны тусламж дэмжлэгтэйгээр орон нутагт бол буудаж тийм ээ тухайн зэвсэг техникийг нь хэрэглэж сургаж байгаа. Энэ бол бид ямар нэгэн асуудал болоход орон нутаг эхний ээлжид хамгаалалтын эхний эгнээнд явах энэ бодлого бол зайлиггүй шаардлагатай. Тэгж байж бид иргэн бүр эх орноо хамгаална гэдэг Үндсэн хуулийнхаа үүргийг бол биелүүлж байгаа.

Цаашид ер нь бол Швейцар Улс бол иргэд бүр буу эзэмших эрхтэй. Цаашид бол бололцоо нөхцөл нь байдаг бол энэ буу зардаг газрыг бол үнийн хяналтыг нь тогтоогоод чөлөөтэй оруулж ирэх, тэгээд ард иргэд яг хуулийнх нь дагуу буугаа эзэмшээд ямар нэгэн тохиолдол болоход хэрэглэхэд бэлэн байх ийм зүйлийг бид нар бас хийх гэж бас дотроо ярилцаж байгаа. Дууслаа.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Ажлын хэсгээс хэд хэдэн асуулт байгаа. Өмнө нь нөгөө 3 намын хамтарсан гэрээн дээр бас яригдаж байсан. Тэгээд хамтарсан гэрээнийх нь нарийвчилсан зохицуулалтууд байхгүй болчихсон. Ингээд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дотор байгаад байгаа хэд хэдэн асуулыг

асуумаар байгаа юм. Энэ 4.4.1.3 дотор Монгол Улсын үндэсний эв нэгдлийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс аливаа талцал хуваагдал Үндсэн хуульт ёсны эсрэг үзэл хандлага гэгчхээд ёс суртахууны доголдол гээд биччихсэн байгаа. Энийг яаж хэмжих юм бэ? Ёс суртахууны доголдолд орсон гэж иргэдээ тэгээд яах гэж байгаа юм бэ? Энийг хэмжих боломж байгаа юм уу? Эхний асуулт.

Ер нь ёс суртахуун чинь хувь хүний дотоод асуудал шүү дээ. Хуучин социализмын үе шиг социалист ёс суртахуун гэдэг хэмжүүрээ дахиад босгож ирэх гээд байгаа юм уу? Яг тэр 4.4.1.3 доод талын заалт дотор биш ээ, 4.4.1.4 доод талын заалт дотор эрүүл чийрэг, эх оронч, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлнэ гэж байна. Иргэний ёс зүй гэдэг код гарах юм уу? Энийгээ бас яаж хэмжих гэж байгаа юм бэ? Мэргэжлийн ёс зүй бол ойлгомжтой. Багшийн, сэтгүүлчийн, Улсын Их Хурлын гишүүний, хуульчийн. Иргэний ёс зүй гэдэг ойлголт хуульчлах гэж байгаа юм уу? Яаж хэмжих гэж байгаа юм бэ? Ямар агуулгууд энэ дотор чинь байх юм бэ?

Хариуцлагатай иргэн гэвэл ойлгож байна. Ёс зүйтэй иргэн гэдэг чинь хэмжихэд хэцүү. Ёс суртахууны доголдол гэдгийг чинь бас хэмжихэд хэцүү. Энэ 2 ойлголт чинь. Тэр 2 ч хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа бол соён гэгээрлийн болон эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээ авна гэдэг эхний 2 заалт дотор түүх ер нь байх уу? Газар нутаг, эх орон, газар нутаг гээд явж байна. Хамгийн гол нь бид нарыг сургамжтай бас бахархалтай Монгол хүн болгож байгаа чинь энэ түүхийн нугачаа доторх олон баримтууд шүү дээ. Энэ түүхийн үйл явц чинь энэ рүү чинь орох юм уу, үгүй юм уу гэдэг асуулт байгаа юм.

Энэ 4.4.1 дотор үндэсний эв нэгдэл гэсэн дотор хэл яваад байгаа нь ямар учиртай вэ? Үндэсний эв нэгдэл дотор энэ тодорхой гэмт хэрэг мөнгө угаах болон согтууруулах ундааны эргэлт гэдэг энэ 2

зүйл яагаад энэ дотор явж байгаа юм бэ? Энэ өөрөө гэмт хэрэгтэн болон хууль сахиулах үйл ажиллагаатай холбоотой тэр урд талын бүлэгт байх ёстой юм биш үү. Ийм асуултууд байна.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам хариулъя. Номер 1. ТНБД Батхүү, номер 2.

Ц.Эрдэнэбат: Эрдэнэбат Эдийн засгийн хөгжлийн яам. Гишүүний асуултад хариулъя. Тэр өмнөх бас асуулт дээр бас гарч ирсэн нэг энэ дээр нэг жоохон товч тайлбар өгөхөд үйл ажиллагааны хөтөлбөр маань ямар онцлогтой байгаа вэ гэхээр 3 намын хамтарсан гэрээний дагуу 3 намын сонгуульд орсон мөрийн хөтөлбөр дээрээс нэлээд тулгуурлаж бас хийгдсэн онцлогтой байгаа. Тийм учраас тэр гэрээний дагуу мөрийн хөтөлбөр дээрх тодорхой зарим заалтууд бол орсон байгаа.

Харин энэ дээр юу гэж орж ирж байгаа вэ гэхээрээ Эдийн засгийн хөгжлийн яам энэний дагалдах төлөвлөгөөг гаргана. Төлөвлөгөөг гаргахдаа зохих загварчлал тооцооллуудыг маш нарийвчлан хийнэ. Тухайлбал түрүүний ярьсан эрчим хүчний салбар дээр Ганзориг гишүүний Сайнзориг гишүүний асуусантай адилхан нөгөө energy mix-ээ бодоод энэ төслүүд энэ 149 төсөл арга хэмжээнүүд дээр шаардагдах эрчим хүчний тооцоолол гарах ёстой. Тэрнээсээ үүдэлтэйгээр дотоодод бид нарын ямар эрэлт хэрэгцээ болох вэ гээд мөн түүнтэй адилхан гадагшаагаа экспортбол ямар боломж байгаа вэ гэдгээс нь ингэж ангилж нарийвчилж тооцоолол гарах юм. Тэмүүжин гишүүний саяын асуулыг бол бид нар санал гэж хүлээж аваад, энэ дээр зохих засваруудыг нь хийгээд явчих боломжтой гэж бодож байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тэгээд Батхүү даргаа асуултад хариулъя. Тэмүүжин гишүүний асуусан асуултад Эдийн засгийн

хөгжлийн яамыг, Монгол Улсын ЗГ-ыг төлөөлөх үүрэг танд байгаа. Тэгэхээр та болбол албан ёсны байр сууриа илэрхийлнэ. Номер 2. Сайд нарыг дуудаарай, ЗГ-ын хуралдаан дуусаж байна уу?

И.Батхүү: Тэмүүжин гишүүний асуултад хариулъя. Саяын таны хэлсэн саналуудыг бид нар анхаарч ажиллая. Энэ холбогдох яамнуудаас бас албан ёсны саналууд ирж, ЗГХЭГ, Эдийн засаг, хөгжлийн яам, бусад яамдын төлөөлөлд оролцон ажлын хэсэг дээр боловсруулсан байгаа. Зарим бүлэг хооронд шилжүүлэх, редакцын засвар хийх асуудлууд дээр бид нар анхаарч ажиллая.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн асуулт асууя.

Э.Болормаа: Ажлын хэсгийнхэнд нь бүгддээрэнд нь энэ өдрийн мэнд хүргэе. Надад өнөөдөр хэлэлцэж байгаа тогтоолтой холбоотой 2 асуулт байна. Эхнийх нь болохоор энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээ. Одоо яг бид нарын ярилцаад байгаа энэ тогтоол дээр хэрхэн үүн дээрээ тайлагнах, цаашидаа хяналт шинжилгээ, үнэлгээний асуултыг би та бүхнээсээ асуумаар байна. ЗГХЭГ-аас төлөөлөл байгаа болов уу? Энэ Хэрэг эрхлэх газартай илүү холбоотой асуудал. Би энэ дээр яг юуг онцолж хэлмээр байна гэхээр бид нар энэ үйл ажиллагааны хөтөлбөрөө хийхдээ эвслийн ЗГ бол мөрийн хөтөлбөрүүдээс нэгтгээд ингээд тусгасан бол цаашидаа хэрхэн энийгээ хэрэгжүүлэх вэ? Ямар нэгэн гадна, дотнын байгууллагын амжилттай төсөл хөтөлбөрийн ард заавал төлөвлөгөөндөө хяналт шинжилгээ, үнэлгээг тусгасан байдаг. Яг ямар ямар түвшинд хүрэх гээд байгаа, үүнийгээ хэрхэн тайлагнах вэ?

Би өмнө нь чуулган дээр ч гэсэн хэлсэн юм. Хэрхэн энэ төрийн албан хаагчдынхаа цагийг бүтээмжтэй байлгаж, тайлан үйлдвэрлэхгүй болгодог болгох вэ? Зөвхөн нэг цаасан тайлан

үйлдвэрлэх зориулалтаар дийлэнх цагаа өнгөрөөгөөд байгаа энэ асуудлыг яаж халах вэ? Тэгэхээр ЗГХЭГ үүн дээр нэгдсэн цахимжилтын бодлого барьж байна уу? Орчин үеийн байгууллагууд, хувийн хэвшлийн байгууллагууд бүгд л дотоод ERP системтэй, энэ бүх зүйлүүдээ шийддэг энэ зүйлүүдийг хэрэгжүүлэх саналууд оруулсан байгаа юу гэдгийг асуумаар байна. Тэгэхээр энэ дээр хариулах хүн байгаа болов уу дарга энэ дээр онцгойлон анхаарал хандуулаад өгөөч.

2 дахь нь болохоор юу вэ гэхээр энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяа байгууллагууд хууль сахиулах байгууллагууд ордог. Энэ дээр боловсон хүчин илүү мэргэжлийн байх тал дээр та бүхэн хэрхэн яаж анхаарч байгаа вэ? Би энэ дээр бүүр онцгойлон ОБЕГ-ын даргаас асуумаар байгаа юм. Яг орон нутагт газар дээр ОБЕГ дээр бараг яривал онигоо болохоор шившиг болохоор тийм хэмжээний улс төржилт энэ албан хаагчид дунд явж байна. Яг ийм хууль сахиулах ийм мэргэжлийн аюулгүй байдлын чиглэлийн байгууллагууд дотор яагаад ийм сонин улс төржсөн байдалтай нөхцөл байдлууд байна вэ? Энэ томилгоонууд дээрээ хэрхэн танай байгууллагууд анхаарах вэ гэдэг дээр би мэдээлэл авмаар байна.

Яагаад гэвэл л бид нар ингээд л нэг их сүртэй юм болоод л үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлдэг, бөөн төсөв мөнгө баталдаг. Ялангуяа ОБЕГ дээр бол үйл ажиллагаа дээр нэмэлт төсвийн асуудлыг бол хэд хэдэн удаа ЗГ, Их Хурал хэлэлцэж байсан боловч яг газар дээрээ нэг хэдэн улс төржсөн нөхдүүдэд очоод л нэг хэн илүү лоббидсон тэр байгууллагынхаа ийм тоног төхөөрөмж авдаг иймэрхүү нөөцийн хуваарилалтын асуудлаас авхуулаад ийм доголдолтой асуудлыг цэгцлэх ямар бодлого баримталж байна вэ? Энийгээ үйл ажиллагааны хөтөлбөртөө хэрхэн тусгасан бэ гэдгийг асууя.

Г.Тэмүүлэн: Ариунбуян дарга эхлээд хариулъя 6 номер. Хэрэг эрхлэхээс дараа нь хүн бэлдэж байгаарай.

Г.Ариунбуян: Болормаа гишүүний асуултад асууя хариулъя. Онцгой байдлын байгууллага боо төрийн цэргийн байгууллага. Төрийн тусгай алба үүрэг гүйцэтгэдэг, тангараг өргөсөн албан хаагчид үүрэг гүйцэтгэдэг. Энэ дээр бол ямар нэгэн улс төржссөн үйл ажиллагаа бол байхгүй гэж ойлгож байгаа. Байхгүй. Хэрэв тийм улс төржссөн аль нэг улс төрийн нам, эвслийг дагаж намирдаг гүйдэг тийм албан тушаалтан, тийм хүн байвал та албан ёсоор надад мэдэгдээрэй. Би шалгаж үзье. Шалгаад нотлогдож байвал тэр хүнд нь хариуцлага тооцоход бэлэн байна.

Г.Тэмүүлэн: Хэрэг эрхлэхээс хариулах хүн байна уу, Хэрэг эрхлэхээс хүн байна уу, Цолмон дарга байна уу? Тэргүүн дэд дарга. 6 номер.

Б.Ганбат: Сайн байна уу? ЗГ-ын Хэрэг эрхлэх сайдын зөвлөх Ганбат байна. Болормаа гишүүний асуултад хариулъя. Төрийн үйлчилгээний цахимжилт бол ирэх 4 жилд бол идэвхтэй үргэлжлэн хэрэгжинэ. Имонгол системийг системээр дамжуулан төрийн бүх үйлчилгээг бүрэн цахимжуулах, дээрээс нь бүх төрд байгаа мэдээллийг dashboard системд холбож, бодит цагийн горимд мэдээллийг авах, солилцох бүх бололцоог хангах чиглэлээр ажиллаж байгаа.

ЗГ одоогоос эхлээд бүх үйл ажиллагаагаа ил тод болгох, цаасгүй болгох, тоон гарын үсгээр дамжуулж бичгээр би юу цаасаар биш цахимаар бичиг солилцооныхоо үйл ажиллагааг явуулах ERP системүүдээ нэгтгэх ажлуудыг бол эхлүүлээд явж байгаа. Энийг бол цаашид улам боловсронгуй болгоно. Энэ талаар ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн Засаглал төрийн албаны шинэчлэл гэсэн бүлэгт бол тодорхой зорилт, үйл ажиллагаанууд туссан байгаа.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн нэмж тодруулъя.

Э.Болормаа: Хариулт өгсөнд баярлалаа. Ариунбуян генерал би бол яг тодорхой жишээнүүд тантай яг нөгөө хувьчлан өмнө нь ярьж байсан учир энийг бас нэмж байгаа юм шүү. Тэгээд 1 хувь хүний асуудлыг би энэ дээр нэг их яриад байх нь зохимжгүй байх гэж бодож байна. Би харин онцолж юу хэлэх байна вэ гэхээр энэ системийн доголдол байгаа учир энэ байгаа байх. Өмнө нь би энэ асуудлыг хөндөөд байхад энэ асуудал дээр хариуцлага тооцохгүй, одоо бүр яривал онигоо мэт, би бараг яриад дэмий байх хэмжээний улс төржилт явагдаж байгаа шүү, тэнд вант улсын ямархуу байдлаар томилгоо явагддаг. Хөдөө орон нутагт магадгүй энд Улаанбаатар хотын хяналт байхгүй гэж бодоод нэг Онцгой байдлын дарга нь яаж хүн ажилд авч, тэнд зүгээр ажлуудыг би яривал үнэхээр онигоо болно.

Тийм болохоор би таныг ганц хүний асуудал би энд ярихаас илүүтэйгээр тогтолцооны асуудал яриад байгаа юм л даа. Яаж энэ улс төржихгүй байх хамгаалалтуудыг хийж байна вэ? Яаж, магадгүй эргээд улс төрчид Их Хурал бид яаж улс төрийн шахалт байгууллагууд дээр очихгүй байх дээр бид нар яаж дэмжлэг үзүүлж болох вэ гэдэг ийм асуудлыг тавьж байгаа юм шүү. Тэгэхээр энэ дээр хууль сахиулах байгууллагуудын энэ томилгоо улс төрөөс хараат бус байх тал дээр онцгойлон анхаарч бид энэ Байнгын хороо ч гэсэн энэ дээр дэмжлэг үзүүлэх тал дээр бас нэг нухацтайнхан шиг бодмоор байна. Тэгж байж энэ үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжинэ. Энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүмүүс дээрээ бас онцгой анхааръя гэсэн ийм санал байгаа юм шүү.

2 дахь болохоор энэ төрийн үйлчилгээний ИМонголиа нэг талдаа ингээд төрийн үйлчилгээ, иргэд ямар үйлчилгээ авдаг юм цахимжилт байгаа. Би юу яриад байна гэхээр төрийн албан

хаагчид буюу энэ 280 гаруй мянган төрөөс цалин авч ажиллаж байгаа албан хаагчдын ажлын бүтээмжийн асуудал яриад байгаа юм шүү. Тэгэхээр энэ арай тусдаа. Би яг таны хэлээд байгаа энэ бүх заалтуудыг унхсан юм. Даанч хэтэрхий ингээд бүдүүн баараг байгаад байгаа. Ямар ч ОУБ жишээлбэл би ажиллаж байсан Дэлхийн банкаа эргээд бодох ч юм уу, НҮБ-ын харьяа байгууллагаа бодоход ингээд 10, 20 жил.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Санал гэж ойлголоо тийм ээ. Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэдэг бол ганцхан гадаад асуудал биш дотоод асуудал бас байж байгаа. Бид нарын аюулгүй байдал Монгол Улсын аюулгүй байдал бол үндсэндээ иргэд нь ямар амьдралын чанартай байна вэ гэдгээс л хамаарна шүү дээ. Ядуурал өсөн нэмэгдээд, ажилгүйдэл өсөн нэмэгдээд эхэлбэл түүнийгээ дагаад нийгмийн нөгөө хар сүүдэр буюу хамгийн муу зүйлүүд бий болоод эхэлдэг.

Тэгээд Засгийн Улсын Их Хурлын чуулган дээр асууж байхдаа Эдийн засаг, хөгжлийн сайдыг энэ ер нь яах вэ ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн хэлэлцэж байх үед бол анхаараагүй нь бид нарын алдаа байна. Ер нь ядуурлын эсрэг гэдэг энэ хариуцах ажлыг нь Эдийн засгийн хөгжлийн сайд юм уу, хэн нэгэн сайдад нь өгөхгүй бол болохгүй юм байна лээ. ЗГ бүтнээрээ хариуцна гэдэг юм явж байдаг. Тэгэхээр энэ ядуурлынхаа тоо хэмжээг 2 дахин бууруулна гээд мөрийн хөтөлбөрт орчихсон. Энэ чинь 460 орчим мянган 22 оны статистикаар бол 460 орчим хүн мянган хүмүүсийг ядуурлаас гаргана гэсэн үг. Нэг жилд аль аймаг, сум, дүүрэг, ямар салбарын, ямар хүмүүсийн хэдэн тооны хүн ядуурлаас гарах юм бэ гэдэг энэ бодлогыг их сайн тавьж өгөхгүй бол болохгүй.

Дээрээс нь шатахуун, хүнс, эм хэрэглэдэггүй хүн гэж байхгүй. Дандаа хуурамч болчихсон. Шатахуун гэхэд чинь бараг Монгол даяараа хүн болгон л хэрэглэж байгаа шүү дээ. Машин техник эд хөрөнгөө эвдээд байдаг. Энэ нөгөө шатахууны нөөцийг барих тухай хаа байсан 10 гаруй жилийн өмнө ЗГ оруулсан, батлуулсан. Одоо хүртэл тэр шатахууны нөөцийн савууд баригддаггүй. Концессын ч гэлүү юуны ч гэлээ гэрээтэй гээд. Тэгээд шатахууны нөөцийн сав байхгүй болохоор хуурамч шатахуун, нөгөө хольдог шатахуун орж ирдэг. Тэгээд нөгөө нөөцийн сав нь байхгүй болохоор тэд хоногийн дараа шатахуун дууслаа гэдэг. Дагаад үнийн хөөргөдөл явдаг, хязгаарлалтад ордог. Энэ чиглэлээр ЗГ-ын мөрийн хөтөлбөрт бас юу байгаа вэ?

Тэр нэг зүйл нэмээд асуучихъя даа. Тэр нөгөө гадаадын цахим хар зах дээр Монгол Улсын бүх иргэдийн мэдээлэл байж байдаг юм байна лээ шүү дээ. Сүүлд нь нэг хэсэг алга болсон. 500 доллар, 400 доллар, 600 доллар гээд. Хаан банканд гэдэг юм уу, үгүй бол Монголбанкны юу төв серверийг хакердаад нэг хэсэг Монголбанкны сайт ажиллахгүй болсон шүү дээ. Тэгээд нөгөө Монгол Улсын 2 сая, 3 сая иргэний.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Гараа өргөөрэй, 2 номер уу. Батхүү дарга.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү. Батбаатар гишүүний асуултад хариулъя. Үндэсний статистикийн хорооноос гаргадаг айл өрхийн үндсэн хэрэгцээг хангах амьжиргааны хамгийн бага зардлаар илэрхийлэгддэг ядуурлын шугам гэж байдаг. Энэ 2022 оны хамгийн сүүлд хийгдсэн тооцооллоороо 418090 төгрөг байгаа. Энэ ядуурлын шугамаас доор орлоготой иргэдийн хэмжээ бол 27,1 хувьтай байх 2022 оны байдлаар. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд энэ үзүүлэлтийг дор хаяж 2 дахин

бууруулъя гэсэн зорилт тавьж байгаа. Өрхийн орлогын стандарт тархалтын муруйгаас яг ядуурлын шугамын доор байгаа иргэдийн тоог багасгая гэсэн үг.

Тэгэхээр энэ нь бол шууд тодорхой тухайн иргэн гэхээсээ илүү хамгийн бага орлоготой нийтлэг иргэдийн хэмжээнд олон арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсэн үг байгаа. ЗГ-ын мөрийн хөтөлбөрт тусгасан тодорхой арга хэмжээнүүдээс танд танилцуулъя. 2.1.3.8 дээр халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлын бууруулах бодлого баримтална. 2.1.3.11 дээр орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна. 3.2.1.4 дээр бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална гэж заасан байгаа.

Бас иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр 3.1.1 дээр бизнес хөрөнгө оруулалтын таатай орчны заалт нь бизнесийг дэмжих замаар шинээр ажлын байр бий болгоно. 2.1.2.3 дээр оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайны ажлын байрыг нэмэгдүүлэх бүтээмжийн хувьсгал санаачилгыг бүх түвшинд өрнүүлнэ. Ажилгүйдлийн түвшнийг тууштай бууруулах бодлого баримтална. 2.1.2.6 дээр Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлнэ. 2.1.2.7 дээр олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно. 2.1.2.9 дээр тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар эдийн засгийн бодлогоор дэмжинэ гэсэн заалтуудыг тусгаж оруулсан байгаа.

Бас шатахууны хангамжтай холбоотой бас 2 заалтыг танд танилцуулъя. Газрын тосны

бүтээгдэхүүний түүний 3-аас 6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулна гэсэн нэг заалт байгаа 3.3.1.10 дээр. Мөн 4.4.8 дээр шатахуунд, шатах тослох материалын бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулах барина гэсэн ийм заалтууд бас орсон байна. Дээр нь 3.3.1.6 дээр газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин түлшийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан байгаа.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: Үгүй ээ энэ саяын өгүүлбэрүүдийг уншаагүй биш, уншсан шүү дээ. Нөгөө аль ч цаг үед ингээд мөрийн хөтөлбөр энэ зүйлүүд ингээд яваад байдаг. Маш гоё өгүүлбэрүүд бичээстэй байж байдаг. Тэгээд наад саяын чинь уншсан өгүүлбэрүүд дотор яг наад өгүүлбэрийг чинь хэн хариуцаж, ямар хугацаанд, ямар зүйл хийх юм гэдэг энгийнээр бол өөрт чинь юу гэж хэлбэл ойлгох юм бол. Нягтлан бодох бүртгэл ингээд анхан шатны баримт бүрдүүлэхэд хийдэг шиг нэг тийм тодорхой байлгах тухай яриад байгаа байхгүй юу би. Түүнээс наад уриа лоозонгийн шинж чанартай гоё өгүүлбэрүүдийг бол улс төрчид, улс төрийнхөн ер нь хэдэн 10 жил л ярилаа шүү дээ. Өмнөх хөтөлбөр дээр ч байгаа, тэрний өмнө ч байгаа, 20 жилийн өмнө ч байсан. Дахиад хэвээрээ бас л байж л байгаа.

Тэгэхээр энийгээ их тодорхой нөгөө зорилго зорилт, тэгээд төсөв, хариуцах эзэн, гүйцэтгэл хяналт гээд яг ийм ажлын хэлбэрт нь оруулж ирмээр байна л гэж хэлээд байгаа юм. Тэгэхгүй ингээд манай мөрийн хөтөлбөрт ийм заалтууд байгаа, төдийн төд гээд уншлага хийгээд бол хэрэггүй байх. Энэ саналыг ЗГ талаасаа авах боломж байна

уу гэдэг зүйлийг л асуусан шүү дээ. Хариуцдаг эзэн байя.

Тэр иргэдийн нөгөө иргэдийн нууцын мэдээлэл, дансны үлдэгдэл, регистрийн дугаар энэ юу эд нар гээд энэ гадаадын хар зах тийм нөгөө цахим хар захууд байдаг шүү дээ. Та нар мэдэж л байгаа байлгүй. Манай Монгол иргэдийн бүх мэдээлэл гарчихсан шүү дээ. Тэрийг нь худалдаж аваад, зараад хоорондоо наана цаана гээд явуулж байдаг. Энэ дээр энэ цааш цаашдаа энэ.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Батхүү дарга номер 2, дараа нь Мягмар дарга Хууль зүйн яам хариулахад бэлдэж байгаарай.

И.Батхүү: Өнөөдөр хэлэлцэж байгаа юм бол ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж таны яг хэлсний дагуу хариуцах эзэнтэй, хэрэгжүүлэх цаг хугацаатай суурь үзүүлэлт, тухайн он бүрд хүрэх зорилтот түвшинүүдтэй тийм баримт бичиг боловсруулагдаж батлагддаг ЗГ-ын түвшинд. Энэ дээр бол энэ үйл ажиллагааны хөтөлбөр заалт бүрэн цаашаагаа задраад нарийн тусдаг байгаа.

Г.Тэмүүлэн: Мягмар дарга асуултад хариулъя, 6 номер дээр.

Н.Мягмар: ХЗДХЯ-ны ТНБД Мягмар. Батбаатар гишүүний асуултад хариулъя. Гадаадын зах зээл дээр хувь хүний мэдээллийг гарч зарж байгаа энэ асуудалтай холбоотой асуудал болбол гэмт хэргийн шинж чанартай байгаа болон үндэстэн дамнасан цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хүрээндээ болбол эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, гэмт хэргээс, гэмт хэрэгтэй тэмцэх энэ ажлын хүрээнд болбол энэ асуудалтай тэмцэх эрүүгийн бодлого хууль тогтоомж нь бол бэлэн байж байгаа.

Өнгөрсөн бүрэн эрхийн парламентын хүрээнд болбол Кибер аюулгүй байдлын тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай ийм хуулиудыг баталж, энэ хуулийн хүрээнд болбол хүний хувийн мэдээлэл бол хамгаалагдсан байж байгаа. Энэ удаагийн 24-өөс 28 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дээр болбол энэ цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал гэсэн дэд бүлэг болбол энэ цахим засаглалын бүлэгт орсон байж байгаа. Үүн дээр болбол кибер аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлж, төр, иргэний цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах цахим засаглалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

Мөн бүх салбарын цахим шилжилтийн үйл ажиллагааг интеграцилагдсан кибер аюулгүй байдлын тогтолцоогоороо хангана гэдэг ийм зорилтуудыг болбол тусгасан байж байгаа. Энэ хүрээндээ болбол Цахим хөгжил харилцаа холбооны яам болбол ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөндөө болбол энэ цахимаар аюулгүй байдлыг хангах энэ тогтолцоогоо болбол олон улсын жишигт хүргэж сайжруулна гэдэг ийм зорилтыг бол тусгасан байж байгаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн асуулт асууя. Сая төхөөрөмжид нэр нь ороогүй байсан.

Н.Батсүмбэрэл: Би ганц нэг асуулт, тэгээд үг хэлье. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж байгаа. Тэгээд хөтөлбөр батлагдана байх. Тэгээд хөтөлбөрийг дагаад төлөвлөгөө гарахтай холбоотойгоор хэд хэдэн зүйлийг анхаараасай гэж бодож байгаа. 1 дүгээрт нь ЭМЯ сая Сайнзориг гишүүний хөндөөд байгаа тэр эмийн

импорт дээр чөлөөлөх асуудлыг анхаармаар байна. Ингэхгүй бол Монголд худалдаалагдаж байгаа эмүүд бол чанарын асуудал маш хүндээр яригдаж байна. Монгол эмчийн чадвар муу биш, Монголд худалдаалагдаж байгаа эмийн чанар муу байна гэдэг үг, асуудал их яригдаж байна. Үүнийг ЭМЯ онцгой анхаарч, буцаж энэ Байнгын хороон дээр танилцуулахыг хэлж байна.

2-т нь энэ засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шинэчлэлийг зайлшгүй хийх ёстой. Энэ удаагийн сонгуулиар дамжуулаад Монгол Улсын аймгуудыг 6 бүсэд хуваачихлаа. Энэ 6 бүсийн бодлогоо давуулаад 20 дугаар зууны техник, хүчин чадал, эдийн засгийн байдалтай бий болсон энэ аймгуудыг нэгтгэх, бүсийн төв байгуулах, сумдыг шинэчлэн зохион байгуулах, энэ шинэчлэн зохион байгуулах гэдэг бол сууринуудыг байхгүй болгох гээд байгаа асуудал биш. Яг сум хэлбэрээрээ үлдэх нь ямар байх юм бэ? Түүнээсээ бага статустай хэрхэн зохион байгуулах юм, яаж, энэ дээр тийм Эдийн засгийн яам хийсэн судалгаа байна уу? Байвал тэрийгээ өгөөч. Тэгээд энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг дагалдуулаад хийх хөтөлбөр дээр энэ засаг, захиргааны нэгжийн шинэчлэлийг явуулах ажлын төлөвлөгөөндөө тусгамаар байна.

Нэгэнт эхлүүлчихсэн энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаас ухарч болохгүй байна. Үүнийг урагш нь дэмжиж, хөгжүүлж өгөх ёстой гэж үзэж байна. БХЯ-н дээр тэр иргэдийг эх оронч үзэл, хүмүүжилтэй болгох чиглэл дээр хийгдэж байгаа тийм нийт иргэд рүү чиглэсэн хөтөлбөр юм байна уу? Хуучин миний мэдэхийн биднийг оюутан байхад эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх хөтөлбөр гээд БХЯ хийгээд, сайд нь өөрөө оюутнуудтай уулзалт хийгээд яваад байсан Шаравдорж сайд байх үед. Тэрэн шиг энэ БХЯ-н дээр мэргэжлийн бус хүмүүст энэ нийт иргэдэд чиглэсэн ийм хөтөлбөр, буу худалдаалах, иргэдийг зэвсэгжүүлэхээс илүү энэ хөтөлбөрийг хийх нь юуны

түрүүнд чухал байна гэж би хувьдаа бодож байна.

Онцгой байдлын байгууллагыг бэхжүүлэх ажил дээр онцгой анхаарч ажилламаар байна. Энэ барилгын стандартууд алдагдаж байгаа байдал, шатамхай материалууд их нэмэгдсэн, хүн амын нягтрал ихтэй байгаагаас болж онцгой байдлын байгууллагын хүчин чадал хүрэлцэхгүй байдал руу орж байна. Тэгэхээр энэ онцгой байдлын байгууллагыг онцгойлон дэмжих, анги салбаруудыг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын асуудлыг онцгойлон анхаарах, техник хангамжийг нэмэгдүүлэх шаардлага байгаа. Энэ дээр тусгай хөтөлбөрт төлөвлөгөөндөө нэлээн сайн суулгаж өгмөөр байна. Энэ дээр анхаарч ажиллаарай гэдгийг үг болгож хэлье.

Эдийн засгийн яамнаас нэг зүйлийг тодруулж асууя. Энэ автомашины импорт дээр энэ буруу жолоотой автомашиныг он заагаад нөгөө худалдаалахыг хязгаарлах.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам номер 2 Батхүү дарга.

И.Батхүү: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам ТНБД Батхүү. Улаанбаатар хотын энэ авто замын түгжрэлийг бууруулахдаа ингээд нэлээн хэдэн нийтийн тээврийн асуудлуудыг шийдэх заалтууд орсон байгаа. Яг тэр буруу жолоотой машины талаар холбогдох яам, нийслэл энэ тэр бас бодлогын түвшинд хоорондоо уялдуулж, хариултаа өгөх нь зөв байх. Бид нарын хувьд бол энэ дээр дэд бүтцийн асуудлууд нэлээн тусгагдсан байгаа ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр.

Засаг, захиргааны нэгжийн хувьд бол энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд яг эдийн засгийн

агуулгаараа тооцоолсон тийм төвүүд гэж байгаа, 90 төвийн байршил байгаа. Энэ макро бүсчлэлээрээ таны хэлдэг нөгөө 6 том бүс, дээр нь нийслэл Улаанбаатар хот байгаа. Мезо бүс буюу дунд шатдаа бол 21 аймгийн хөгжлийн асуудалд дурдагддаг. 3 микро бүс буюу сум дундын 90 төв байгаа. Энэ нь болохоор 21 аймгийн төвийн сум, нэмэх нь 69 сум гээд ийм 3 шатлалтайгаар тооцоолсон байдаг. Энэ нь тухайн төвүүд нь өөрсдөө тухайн төвүүдэд хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаа нь бусад байршилтай харьцуулахад илүү татах, түлхэх нөлөөлөлтэй, илүү эдийн засгийн өгөөжтэй гэдэг агуулгаасаа гарсан байгаа. Яг энэтэй холбоотой засаг, захиргааны өөрчлөлтийн хувьд бол судалгаа хийгдсэн байдаг гэж ойлгож байгаа. Хүргүүлье, тийм танд хүргүүлье.

Г.Тэмүүлэн: БХЯ 6 номер Ганхуяг дарга.

Д.Ганхуяг: БХЯ-ны ТНБД, бригадын генерал Ганхуяг. Гишүүний асуултад хариулъя. Бид Боловсролын яаманд ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн программд иргэний цэрэгжилтийн бэлтгэл хичээлийг оруулж байх саналыг бол хүргүүлээд байгаа. Тэгээд энэ дээр бол ажлын хэсгүүд бол яригдаж байгаа.

Мөн Үндэсний батлан хамгаалах их сургуулийн элсэлтийн өмнө бол бүх аймаг, сумуудаар тойрч энэ батлан хамгаалах чиглэлээр ялангуяа ерөнхий боловсролын төгсөх ангийн оюутнуудад бол энэ сурталчлах ажлыг хийж байна. Мөн жил болгон Дөл цэрэгжилтийн сургуулилтыг аймаг, сум бүрд явуулж, шалгарсан багуудыг энэ Улаанбаатар хотод авчирч, Тавантолгой сургалтын бэлтгэлийн бүсэд сургалтад хамруулж, тэргүүлэх сайн зохион байгуулалтад орсон аймгуудыг аймаг, дүүргүүдээс ирсэн багуудыг шалгаруулах ажлыг ингэж зохион байгуулж байгаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр Батлан хамгаалахын яам бол энэ дээр хөтөлбөр гаргах юм байна гэж ойлголоо. Ер нь энэ Ерөнхийлөгчийн санаачилсан энэ Хүнсний хувьсгал шиг наанаа харахад нэг иргэний юм шиг мөртөө цаагуураа энэ аюулгүй байдлыг хангах гэж байгаа чиглэлийн энэ хөтөлбөрүүдийг яамнууд хиймээр харагдаад байгаа юм. Онцгой байдлын байгууллагын чиглэлээрээ, Батлан хамгаалахын яаман дээр бол бүр тэр иргэдийн эх оронч үзэл, хүмүүжлийг дэмжих чиглэл рүү юмнууд хийвэл яасан юм бэ гэсэн ийм, анхаарч ажиллаач гэсэн ийм чиглэл санаа байна.

Тэр буруу жолоотой автомашин дээр яг тодорхой хариулт Эдийн засгийн яам хэлмээр байх юм. Өөрөөр хэлэх юм бол энэ ялангуяа энэ орон нутгийн замд буруу жолоотой тээврийн хэрэгсэл жолоодож байгаагаас болж авто осол гарч байгаа тоон үзүүлэлтүүд замын цагдаагийн байгууллагад байдаг юм байна лээ. Тэгэхээр энийг импорт дээр нь эхний ээлжид хэдэн оноос ч байдаг юм хязгаарлах, цаашидаа Монгол Улсад автомашины хүрдийг солих үйлдвэр оруулж ирэх, энэ замын хөдөлгөөний дүрэмтэйгээ уялдаж байгаа шүү дээ. Эсхүл замын хөдөлгөөний дүрмээ өөрчлөх. Энэ дээр Эдийн засгийн яам нэг дорвитойхон ажиллахгүй бол шаардлага байна. Энэ бол хүний амь настай холбоотой, хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой.

Жилдээ 500 хүн тээврийн хэрэгслээс болж амь насаа алдаж байна. Зөвхөн тээврийн хэрэгслээс болж байна. Усанд үйж нас барж байгаа хүний тоо дахиад 100-гаар яригдана, галд амь насаа алдаж байгаа хүмүүсийн тоо яригдана. Ингээд л энэ бүхэн чинь өөрөө бид нар дайнгүй мөртөө энхийн цагт ийм л байдалтай байгаа учраас энэ эдийн засгийн аргаар энийг шийдэх бололцоо

байгаа гэж үзэж байгаа. Энэ дээр Эдийн засгийн яам ажиллаач гэж санал хэлье.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Би 2 дугаар энэ заалттай холбогдуулаад ганц, хоёр саналуудыг бас 1 дүгээрт хэлэх гэсэн юм. 1 дүгээр асуудал зүгээр зарчмын асуудал. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар нийтлэг журмаараа болбол ЗГ-аас өргөн баригдсан хууль тогтоомжийн асуудлаар ЗГ-ын гишүүн ЗГ-ын байр суурийг илэрхийлэх болбол үүрэгтэй байгаа. Тэгэхээр дараа дараагийн хуралдаанууд дээр сайд нартаа анхааруулж хэлээрэй. Зайлшгүй сайд нар оролцоно.

Өнөөдөр зөвхөн ЗГ-аас яаралтай горимоор орж ирсэн төсвийн тодотголтой холбогдуулж, Төсвийн байнгын хороо хуралдахтай холбогдуулж хүндэтгэх шалтгааны улмаас болбол бас харгалзаж үзэж өнөөдрийг яаж байгаа шүү. Сайд нарыг дараагийн хуралдаан дээрээ заавал ч үгүй оролцуулна. Сайд нарыг эзгүйд ТНБД нар ч гэсэн бас өөрсдөө хариуцлагатай байх хэрэгтэй байна. Асуултаас бултаад байх шаардлагагүй. Яамныхаа байр суурийг илэрхийлэх үүрэгтэй хүмүүс болбол бүрэн төлөөлөх, сайдыг эзгүйд төлөөлөх үүрэгтэй хүмүүс бол ТНБД нар байгаа.

2 дугаарт би сая хэд хэдэн гишүүдийн бас нэг асуулт байна. Гадаад яамны ТНБД бас анхаарч үзээрэй. Хэд хэдэн гишүүдийн санал дээр гарсан. Гадаад харилцааг хэрхэн эдийн засагжуулах вэ гэдэг асуудлыг ярьж байна. Танайтай холбоотой бүтэц, чиг үүрэг, засаглалтай холбоотой асуудлууд дээр жишээ нь гишүүд асуусан. Бид нар ямар дэмжлэг үзүүлэх ёстой юм бэ гэдэг асуудал. Энэ дээр та хэд бас өөрсдөө тооцоо судалгаагаа хийх ёстой. Тэрнээс юу гэдэг юм социализмынхаа үеэр бүтцээр бид нар яваад байна гэсэн ийм хайхрамжгүй хариулт хэлж болохгүй шүү. Та ажлаа аваад удаагүй байж болно. Гэхдээ танай яамны залгамж бодлого явж байгаа, жил болгоныхоо төсөв,

бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлтөө та бүхэн өөрсдөө оруулж ирж байгаа юм.

Гол анхаарах асуудал бол бид нар ер нь яаж гадаад харилцааг эдийн засагжуулах юм бэ гэдэг асуудлууд байгаад байна. Хүн хүчээ хаанаа төлөвлөх ёстой юм бэ тийм ээ. Хэрэгцээтэй, хэрэгцээгүй газар юу гэдэг нь консулын газар ч гэдэг юм уу, Элчин сайд тийм байгуулах юм уу эсвэл улсынхаа эдийн засаг нь 80, 90 хувь нь хамааралтай байгаа улс орон дээрээ илүү төсөл хөтөлбөр хариуцсан project management гэдэг юм уу төслийн менежмент хариуцсан хүмүүс томилох ёстой юм уу, үгүй юм уу энэ дээрээ ч гэсэн та нар бол анхаарах ёстой байгаа шүү. Энэ дээр бас нэг манай Байнгын хорооны бүрэлдэхүүн Гадаад яаман дээр очиж бас танай үйл ажиллагаатай танилцана. Тэр үед тодорхой танилцуулга, мэдээллүүд бас хийгээрэй гэж болбол бас хэлэх байна.

3 дахь нь яг саяын асуудалтай холбоотойгоор ер нь зүгээр энэ нэг гадаад бодлогыг хэрхэн эдийн засагжуулах вэ гэдэг асуудалтай уялдуулж энэ ер нь Эдийн засгийн яам болоод ГХЯ хоорондоо ажлынхаа чиг үүрэг уялдаагаа бас хангаж чадаж байна уу үгүй юү? Гол бид нарын асуудал ер нь зүгээр энэ нэг яаж энэ ирээдүйнхээ бодлогын төлөвлөлтийг гаргах юм бэ? Гадаад харилцааныхаа бодлоготой уялдуулж эдийн засагжуулах харилцаа дээрээ яаж мэдээллээ чөлөөтэй судалдаг байх юм бэ? Стратеги судалгаагаа хэрхэн хийдэг байх юм бэ? Эсвэл стратегийнхаа бодлого төлөвлөлтийг хэрхэн хийдэг байх юм бэ? Та хэд л энийг гаргаж ирэх ёстой шүү.

4 дэх нь сая зүгээр би зүгээр төсвийн хэлэлцүүлгийн үеэр ч гэсэн хараад байхад энэ ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг бол угаасаа эдийн засгийн ирэх 4 жилийн хугацаанд ЗГ-аас хэрэгжүүлэх эдийн засгийн бодлого байгаад байгаа юм. Энэ хөгжлийн бодлогыг төлөвлөх, тодорхойлох үндсэн чиг үүрэг Эдийн

засаг, хөгжлийн яаман дээр байгаа байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг болбол нэг талдаа төсөв, санхүү, эдийн засгийн бас бодлого. Энэ асуудлыг бас бүрэн хариуцах үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр асуултуудад хариулж байгаа хүмүүс бол Сангийн яам хуучин хуулийнхаа тогтолцоогоор хариулаад яваад байна. Та нар бүрэн үүрэг хариуцлага хүлээх ёстой. Төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын хөгжлийн бодлоготой нийцүүлэх, төсөв, санхүүгийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор нийцүүлэх үүргийг Эдийн засгийн хөгжлийн яам шинэ хуулиараа хүлээж байгаа. Өөр бүр төсвийн хүрээний мэдэгдлийг та нар оруулж ирэхээс өмнө, төсвийн тодотголыг оруулж ирэхээс өмнө оруулах уу, үгүй юү гэдгийг шийддэг эрх мэдлийг та нарт өгсөн байгаа шүү. Сангийн яам танай яамнаас зөвшөөрөл авдаг болсон. Энэ эрх мэдэл, эрх зүйн орчныхоо өөрчлөлтөд та нар нийцүүлж бас ажиллах ёстой, хариуцлагатай ажиллах ёстой. Энэ дээр анхаарч ажиллаарай гэсэн энэ саналыг болбол хэлж байгаа.

Дөрөвдүгээрх нь саяын тэр энэ заалттай холбоотойгоор бас нэг анхаарах ёстой асуудлууд байна. Энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зардлыг тооцоод, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх гэдэг асуудлууд байна. Бид нарын гол анхаарах ёстой асуудал бол ерөөсөө энэ өрийн менежмент, өрийн удирдлагын асуудлууд байгаад байна. Олонх гишүүд энэ дээр саналаа хэлж байна. Гадаад өрөөр чөдөрлөгдсөн эдийн засагтай улс болох вий дээ гэсэн болгоомжлол байгаад байна. Энэ дээр та хэд болбол байнгын энэ өр эргэн төлөлтийн хуваарь дээр анхааралтай мониторинг хийж чадаж байна уу, үгүй юү? Эргээд энэ зээлийн түвшин, гадаад өр, зээл өндөр байгаад байдаг, эргэн төлөлтийн асуудлууд болбол хамгийн том санаа зовох асуудлууд байгаад байгаа юм. Энэ дээр

анхаарч ажиллаарай гэдгийг би бас хэлэх байна. 2 дугаар заалттай холбоотой гишүүд санал, асуулт асууж дууслаа.

Тогтоолын төслийн 3 дугаар заалттай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Эрдэнэболд гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ганбат гишүүн 2 ч удаа асуулаа. Энэ шатахууны талаар дорвитой хариулт авсангүй. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хүн байна уу? Ер нь болбол энэ Украйны дайнтай холбоотой шатахууны асуудал бас асуудалтай, ОХУ байсхийгээд шатахууны хориг тавьдаг, тавьчхаад байгаа. 2024 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 1074 тоот тогтоолоор экспортын бензин зөвхөн бензиний түр экспортын хориг тавьчихсан байгаа. 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд.

Гэхдээ хамтын нөхөрлөлийн орнууд болон манай Монгол оронд бол энэ тогтоол нь бол үйлчлэхгүй. ОХУ яагаад энэ экспортын хоригийг ингээд тавиад байдаг, энэ дээр ер нь дүн шинжлэлт хийгээд байгаа юм уу? ОХУ өөрөө энэ төсвөө болбол нефть, газ, энэ газрын тосны бүтээгдэхүүнээр бүрдүүлдэг. Тэгсэн мөртөө газрын тосны бүтээгдэхүүн дээр хориг тавиад байдаг. Яагаад тэгдэг юм бол доо? Бодвол газрын тосны бүтээгдэхүүнээ экспортлоод нефть, газаа экспортлоод энэ дайны хүнд үед эдийн засгаа төсвөө бүрдүүлэх тийм чиглэлээр ажиллах ёстой. Тэгсэн мөртөө экспортоо хаагаад байдаг. Тэгэхээр энэ бензин шатахуун нь яг 2025, 2026 онд яах юм бэ?

Сая хэлээд байна. 3-аас 6 сарын нөөц бүрдүүлэх барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна гээд. Энэ бол миний бодож байгаагаар бол урт хугацаанд энэ 4 жилд хэрэгжих үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан

заалт гэж бодоод байгаа юм. Тэгэхээр Ашигт малтмал, газрын тосны газар энэ ямар бодлого барьж байгаа юм бэ? 25 онд яах юм, 26 онд яах юм бэ? Энэ яалт ч үгүй бензиний энэ газрын тосны бүтээгдэхүүний асуудлыг нарийн зохион байгуулахгүй бол бас аюулгүй байдалд нөлөөлнө шүү. Нөөц бүрдүүлэх 45 хоногийн компаниуд гэрээтэй. Гэхдээ энэ гэрээний дагуу бүрдүүлж байна уу, үгүй юу? Өнгөрсөн жил.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас газрын дарга байна уу, Мэндбаяр уу, хүн байна уу? Хэн төлөөлж хариулчих уу ЗГ-аас? Батхүү дарга 2 номер.

И.Батхүү: Гишүүний асуултад хариулъя. ОХУ-аас манай оруулж ирдэг нефть, шатахууны төрлийн бүтээгдэхүүн хамааралтай нь үнэн. Одоо үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой ялангуяа бас 2, 3 шалтгаанаар ОХУ-ын нефть боловсруулах үйлдвэрүүд бас халдлагад өртөж байгаа шалтгаан байна. Бас дотоодын зах зээлдээ нийлүүлэхдээ ЗГ-аасаа татаастайгаар хямд үнээр нийлүүлдэг байгаа. Дотоодын зах зээлдээ. Энийг нь бол гадагш экспортлох гэсэн сонирхолтой жижиг ААН-үүд бас дотоодын худалдан авалтыг бас тасалдуулах нөхцөл байдал үүсдэг учраас экспортын хориг тавьсан байдаг.

Монгол Улстай холбоотой бол томоохон ААН-үүдээрээ дамжуулаад экспортлоход таны хэлсэн тэр хоригт орохгүй гэдэг нөхцөл байдалтай байгаа. Яг энэ шатахуунд түлшний хангалт тогтвортой нийлүүлэх талаар ЗГ хоорондын хэлэлцээрийг бас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань бас хариуцаад хийж байгаа. Энэ ирэх жилүүдэд бас энэ талаар бас баталгаат тогтвортой нийлүүлэх байх гэж бодож байна. Өмнө нь гарч байсан зарим шатахуун түлшний тасалдал болбол тухайн хэрэглээний тооцооллоо бас алдаатай төлөвлөсөн, захиалгаа бас алдаатай хийсэн тиймэрхүү асуудлууд гарч байсан юм

байна лээ. Энэтэй холбоотой асуудлууд нь цаашир цаашидаа засварлагдаад явж байгаа гэж ойлгож байгаа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: Тэгэхээр бид газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх ёстой л доо. Нөөц бол хангалттай бүрдүүлэх хэрэгтэй. Тэгэхээр энэ онцгой байдлын газруудад нөөцийн савнууд байдаг. Тухайлбал Баян-Өлгий аймгийн Цагааннуурын боомт дээр нөөцийн сав байж байдаг, ашигладаггүй. Миний мэдэж байгаагаар бол. Бодвол өөр газруудад бас байгаа. Энэ нөөц бололцоогоо ашиглаад нөөцөө бүрдүүлэх юм шүү. Тэгж зөвлөмөөр байна.

Энэ экспорт сигнал өгөөд байна шүү дээ. Экспортоо байсхийгээд хаана гэдэг чинь. Өөрсдийнхөө дотоодын хэрэгцээгээ хангахгүй нөхцөл байдал хүндрээд хаагаад байгаа шүү дээ. Тэгэхээс биш гаргаад байхгүй тийм ээ. Нефть байгаад байдаг, газрын тосны бүтээгдэхүүн хомсдолд ороод байна шүү дээ бүтээгдэхүүн нь. Тэгэхээр манай улс болбол энэ нөөцөө 3, 6 сараар бүрдүүлээд одоогоос эхлээд тэгж явах юм биш үү гэсэн санал байна.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа би нэг түрүүн асууя гэж байсан 2 асуулт дутуу үлдсэн юм. Худалдааны хууль хийнэ гээд бас ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр байгаа. Энэ бол дэмжиж байгаа. Энэ бол нөгөө гадаад худалдаа. Тэгэхээр энэ хуулийг боловсруулах ажлыг бас шуурхайлах, эргээд энэ дээрээсээ бусад улс орнуудтай байгуулж байгаа ЕРА буюу эдийн засгийн түншлэлийн энэ хэлэлцээрүүдийг бас анхаарах, энэний загвар гэдэг юм уу Монгол Улсын эрх ашгаа хамгаалах тэр нөхцөл байдлууд дээр илүү их бодолцож бас үзмээр байна.

Бид хэд ерөөсөө гэрээний бэлэн draft-гүй учраас нөгөө айлын гаргаж тавьсан draft дээр ажилладаг. Түүн дээрээ маш олон зүйлүүдийг өөрчлүүлж, эрх ашигтаа нийцүүлж чаддаггүй. Одоо ингээд цаашидаа бас Солонгос улстай ч гэдэг юм уу бусад улс орнууддаа бас энэ ЕРА байгуулах асуудал яригдаж байгаа энэ үе дээр нэн тэргүүнд эхлээд энэ бас Гадаад худалдааны хуулиа бас хийгээд, энэ төрийн чиг үүргийн үед бас жоохон ойлгомжтой болгомоор байна. Яг ГХЯ, Эдийн засгийн хөгжлийн яам хоёрын дунд нэг ийм ойлгомжгүй хавсарга байдалтай ингээд яваад байгаа юм шиг санагддаг. Тэгээд энэ чинь өөрөө эргээд Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээр ямархуу нөлөө үзүүлж байгаа билээ? Энэ зүйлүүдийг бодоход бид нар анхаармаар байна.

Энэний цаана ерөнхийдөө нөгөө Монгол Улсад дэмпинг хийх ч гэдэг юм уу, янз бүрийн юмнууд яригдана. Эргээд энэ secondhand буюу энэ батарей. Ялангуяа энэ цахилгаан автомашинуудаас үүсэж, дараа нь хаягдлуудыг яах вэ гэдэг асуудал дунд хугацаандаа нэлээн анхаарал татаж эхэлнэ. Тэгэхээр бусад улс орнууд чинь энэ үйлдвэрлэлийг, үйлдвэрлэгч энэ дээр тухайн улс орон дээрээ сан бүрдүүлээд тавьчихсан байдаг юм байна лээ. Бид хэд энэ secondhand машиныг импортоор оруулж ирж байгаа хэмжээгээр нь тэр сангаас авч энэ аюултай хог хаягдлыг дахин боловсруулах гэдэг юм уу, устгах энэ үйлдвэрийг барих гэдэг юм уу, энэний асуудлуудыг судалж үзээч гэдэг зүйлийг би хэлмээр байна. Энэ бол манай улсын хувьд бол хүнд болж байгаа шүү. Тэгэхээр энийг хэдүүлээ бас нэг бодолцоод явчихмаар байна.

2 дугаарт яах вэ ОБЕГ-ынхыг би бас нийслэл дээр 8 сар ажиллахдаа хамтарч ажиллаж үзсэн. Ер нь зүгээр яах вэ тогтолцооны шинэчлэлийг та хэд маань бас нэг бодож үзээч. Яг босоо удирдлагатай учраас нийслэл дээр хамаг юу гэдэг юм асуудлууд үүсээд ирэхээр нийслэлийн дарга, удирдлагууд иргэдийн

аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж чадсангүй гэдэг. Яах вэ бид хэд бол хамтраад л ажиллаж байгаа юм. Тэгэхээр энийг ер нь орон нутаг руу нь өгөөд, мэргэжил арга зүйгээр хангадаг, боловсон хүчний бодлогод нь анхаардаг байдлаар зохион байгуулалт хийгээд, орон нутгууд нь тэр тоног төхөөрөмж, эрсдэлээ гэдэг юм уу энэний хариуцлагыг хүлээвэл яадаг юм бэ?

Нэг галын эрсдэл, үерийн эрсдэл болохоор л ЗГ дээрээ нөгөө босоо агентлаг учраас удирдлагаа дагаад ЗГ дээр энэ хариуцлага нь ч гэдэг юм уу, хэл ам нь оччих гээд байдаг ийм зүйл байх юм. Тэгэхээр зүгээр бодолцоорой гэж үзэж байгаа юм. Бусад улс орнуудыг ямар байдалтай байдаг юм бэ? Тэгээд бас зарим хэсгээ төрийн цэргийн байгууллагын хэмжээгээр авч явахад зарим хэсгүүдээ бас энгийн гэдэг юм уу бусад хүмүүс ажиллах бололцоог бас бүрдүүлэх нь зөв байх. Магадгүй бид нар гадаад улсын иргэнишилтэй ч гэсэн нэг сайн гал сөнөөгчийг бас авчраад ажиллахад болох байхгүй юу. Заавал.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя, номер 2 Батхүү дарга.

И.Батхүү: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. ЗГ-ын тухай хууль дээр энэ эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны бодлогын асуудал нь бол Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа. Энэ хүрээндээ яг өнгөрсөн хугацаанд бид нар бас Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу уул уурхайн бус экспортыг дэмжих хуулийн асуудлыг судалж, ажиллаж ирсэн байгаа. Үүнтэй холбоотой өмнө нь янз янзын түвшинд боловсруулагдаж байсан тэр Худалдааны хуулийн төслүүдтэй танилцсан. Төслийн агуулгыг нь харахад бол бүлэг, бичилт текстүүд нь бол их нөгөө хөндөж байгаа түвшин нь өөр өөр эрвээр хураавар тиймэрхүү асуудлууд байсан. Шаардлага

хангахааргүй юм байна гэж бодоод шинээр ингээд Уул уурхайн бус экспортыг дэмжих хуулийн төсөл дээр ажиллаж байсан. Тэрнийг бас тантай танилцуулж ажиллахад бэлэн байна.

Энэ эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдтэй холбоотой ажлын хэсгүүд байгуулагдаад ажиллаж байгаа. Евро Азийн эдийн засгийн холбоотой байгуулах түр чөлөөт худалдаа худалдааны хэлэлцээр байгуулагдаад, албан ёсны 2 дахь уулзалтаа бол удахгүй хийгдэнэ. Солонгосын талтай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн албан ёсны 2 удаагийн хэлэлцээрийг хийсэн байгаа. Энэ хэлэлцээрийн баг нь бол бүх холбогдох яамнуудын төлөөллүүд оролцоод, дэд бүлгүүд дээр ажиллаж байгаа. Таны бас өгч байгаа зөвлөмж юунуудыг анхаарч ажиллахад бэлэн байна.

Яг стандарт гэрээ гэдэг асуудал маань өөрөө энэ эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээрүүд үндсэн холбогдох асуудлууд нь Дэлхийн худалдааны байгууллагын гаргасан хэлэлцээрүүд дээр маш олон хэлэлцээр байгаа. Түүн дээр хөндөгддөг асуудлуудыг нь мэргэжлийн нэр томъёо заалтуудыг бас бид нар их зөрчихгүйгээр чухам манай улсад ашигтай байдлаар яаж тусгах вэ гэдэг талын гол нь анхаарч байгаа. Яг стандарт гэрээ гээд яачихаар бас сайн тал байгаа. Сул тал ч бас үүсдэг. Жишээ нь хөрөнгө оруулалт харилцан хөхүүлэх тэр гэрээг Монголын тал өөрсдөө боловсруулсан нэг загвар нь бол бас бусад улс орнуудтай хийж хэлэлцэхэд нэлээн бас сул талуудыг бий болгоод байгаа асуудлууд байгаа. Энэ тал дээр бас танд тусгайлан танилцуулж ажиллахад бэлэн байна.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн асуулт асууя. Хариулт байгаа юу, хаанаас, Ариунбуян дарга уу? 5 номер,

Ариунбуян дарга 5 номер. Таны хажуудах байна уу? Нөгөө талд.

Г.Ариунбуян: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Монгол Улс орчин цагийн онцгой байдлын удирдлага буюу гамшигаас хамгаалах удирдлагын тогтолцоо, гамшигаас хамгаалах менежментийн тогтолцоог бүрдүүлээд ажиллаж байгаа. Гамшигаас хамгаалах тухай хууль болбол өнөөдөр улсын хэмжээнд бол УОК, эрсдэлийг бууруулах чиглэлээрээ бол Гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл удирдлага зохицуулалт, салбар дундын үйл ажиллагааг уялдуулж зохицуулж ажилладаг.

Орон нутгийн түвшинд, ялангуяа нийслэлд бол мөн иргэдийн хурлын Төлөөлөгчдийн хурлын даргаар ахлуулсан Орон нутгийн гамшигийн эрсдэлийг бууруулах зөвлөл, нийслэлийн онцгой комиссыг нь бол Засаг дарга хуулийнхаа дагуу чиглүүлж ажилладаг юм. Тэгээд ер нь болбол яах вэ цаашид энэ 2 түвшний энэ дундын зохицуулалтыг хийдэг үйл ажиллагааг зохицуулдаг энэ комиссын болон зөвлөлдүүдийн үйл ажиллагааг илүү оновчтой хуваарилж, зохицуулах тал дээр бол цаашидаа анхаарч ажиллах бол хэрэгцээ шаардлага бий. Энэ тал дээр анхааръя.

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Сайнзориг: Генералд баярлалаа. Тэгэхдээ та хэд маань анхаараарай. Үер ус, гамшигийн асуудал болоод яаралтай хөрөнгө гарах гээд тэгэхээр иргэдийн хурлын даргыг хуралдуулахыг хүлээгээд байж байдаг байхгүй юу. Наад хуулийн тогтолцоо чинь зохицуулалт чинь ерөөсөө болдоггүй. Бид хэд гүйцэтгэх гэдэг юм уу, өдөр тутмын үйл ажиллагаа явж байгаа Засаг даргад л өгөх асуудлуудыг өгөх ёстой болохоос биш хамтын удирдлагын байгууллага тэргүүлдэг, одоо өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын дарга гэсэн үг шүү дээ.

Ерөөсөө энэ ингээд юмнууд чинь болдоггүй юм. Тэгэхээр бид хэд нэг ийм хууль хийхдээ нэг юу гэдэг билээ нөгөө эхийг нь яахгүй, тугалыг нь дурайхгүй гээд нэг ийм хувааж өгдөг ийм. Тэгээд хариуцлага нь хаанаа үүрэх нь мэдэгддэггүй байхгүй юу. Энийгээ засах нь зүйтэй.

2 дугаарт түрүүн Тэмүүлэн дарга бол тодорхой хэлсэн. Би энэ дээр дэмжиж хэлж байгаа юм. Бид хэд энэ гадаад худалдааны тэнцлийг ашигтай байлгах энэ чиглэлдээ анхаарах үүднээс Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн оюуны өмчийн байгууллага дээр суурин төлөөлөгчийн газар дээр боловсон хүчнээ орон тоогоо нэммээр байна. Энэ дээр яг чадвартай залуучуудыг томилмоор байна. Түүн дээр Дэлхийн худалдааны байгууллага дээр улс орнуудын хооронд ямар маргаанууд гараад байна, ямар зохицуулалтууд хийгдээд байна, ямар патентууд бүртгэгдээд, ямар аж үйлдвэрүүд яваад байна гэдэг зүйлүүдийг бид хэд мэдэж байж өнөөдөр Монгол Улсад аж үйлдвэр юу гэдэг юм уул уурхайн бус эдийн засаг хөгжинө. Энэ дээр анхаараач.

2 дугаарт энэ Элчин сайдуудын ажлуудыг дүгнэхдээ түрүүн Тэмүүлэн сайд тодорхой хэлж байна эдийн засагжуулах. Тэгэхээр Монголын гадаад паспортыг яаж хүчин чадлыг нь нэмэгдүүлсэн бэ гэдгээр 1 дүгээрт ажлыг нь дүгнэмээр байна. 2 дугаарт энэ хөрөнгө оруулалтыг яаж татсан бэ буюу энэ тухайн улс оронтой сууж байгаа улс оронтойгоо гадаад худалдааны тэнцэл ямар ашигтай байсан бэ гэдгээр нь дүгнэж бас энэ үйл ажиллагааг нь анхаардаг энэ юм руу оруулж, энэ Элчин сайдуудыг дандаа нэг ийм амралтад явуулчихлаа. Шагналын гэдэг энэ албан тушаалын энэ имижийг өөрчлөхөд бас анхаараач. Энэ чиглэлд нь бас нэг Гадаад хэргийн яам маань бас нэг удирдамж чиглэл энэ нөхцөл байдлуудаа бас бодолцож бас цаашидаа анхаараач гэдэг зүйлийг би хэлмээр байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Санал хэллээ гэж ойлголоо. Ганбат гишүүн асуулт асууя. Шижир гишүүн, уучлаарай, сая нэр нь алга болсон байна.

Ө.Шижир: Эдийн засаг, хөгжлийн яамнаас нэг асуулт байгаа юм. Өнгөрсөн улсын төсвүүдтэй холбоотойгоор ингээд 2018 оноос 2024 оны улсын төсөв хүртэл нийтдээ би зүгээр ганцхан жишээ аваад хэлэхэд Боловсролын сайдын багц төсөв дээр ингээд 2018 оноос 15 оноос 2024 оныг хүртэл дуусаагүй буюу хамгийн сүүлд 2020, 22 онд төсөв нь тавигдаад өнөөдрийг хүртэл дуусаагүй ингээд 249 барилга байгууламж байгаа юм. Тэгээд эд нарыг ингээд харахаар жишээ нь 2018 онд спорт заалны барилга гээд л 800 сая төгрөг суусан. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Рашаант багт 205 хүний суудалтай хүүхдийн 10 жилийн сургуулийг ЕБС-ийг 2018 онд 1 тэрбум төгрөгөөр суулгаад, одоо төсөвт өртөг нь 4 тэрбум болчихсон. Хөвсгөлд жишээ нь 320 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилга 18 онд 3,6 тэрбумаар суугаад одоо 6,8 тэрбум болчихсон гэдэг ч юм уу иймэрхүү ингээд 249 барилга байгууламж байгаа юм.

Тэгээд бүхэл бүтэн улс байж 1 тэрбум төгрөгийн спорт заалны барилга байгууламжийг, 320 хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг нэг жилд барьж чадахгүй байна гэдэг бол нэг талаас бас аягүй эмгэнэлтэй л дээ. Тэгээд үүн дээр бас Их Хурлын гишүүд маань 2025 оны улсын төсөв дээр нэг өөрсөд өөрсдийнхөө тойрог дээрээ нэг, нэг юм суулгаад, тэрийгээ 5 жил увуулж цувуулж тавиулах тухай биш бас тухайн жилд нь дуусгах тал дээр ингээд анхаарахгүй бол энэний чинь алдагдсан боломжийн өртөг гэдэг чинь өөрөө айхтар юм болчихоод байгаа юм. 3,6 тэрбумаар анх улсын зөв суугаад барьж дуусгах боломжтой байсан барилга байгууламж өнөөдөр 6,7 тэрбум буюу ингээд 2 дахин өсөөд зөвхөн нэг сургууль, цэцэрлэгийн барилга дээр л өнгөрсөн 4 жилийн хугацаанд 1 сая доллар

ингээд цэвэр алдагдал хүлээчхэж байгаа юм.

Тэгэхээр үүн дээр Эдийн засаг, хөгжлийн яам алдагдсан боломжийн өртгийг бодож үзсэн юм байдаг юм уу? Энэ чинь нийлбэр дүнгээр хэдэн 100 тэрбум төгрөг болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ өөрөө Сангийн яам бас энэ тал дээр төсөв боохдоо ийм хэмжээний зарлагыг тухайн жилд нь дуусах байдлаар хийхгүй бол энэ чинь одоо бид нарын улсын төсвийн тэлэлт чинь энэнээс бас аягүй их хамаараад байгаа. Ингээд л 3 тэрбумаар ингээд л 249 барилга байгууламж нэмэгдэж байна гэдэг чинь өөрөө бараг хэдэн 100 тэрбум тоо руу орчхоод ирэхээр энэ тоо чинь өөрөө улсын төсвийн тэлэлтийг өсгөөд байгаа юм. Үүнтэй зэрэгцээд ажиллах хүчний зардлыг чинь өсгөчхөж байгаа, үйл ажиллагааны зардал ч өсчхөж байгаа юм. Ингээд бид нар энийгээ ерөөсөө тооцохгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр яг Эдийн засаг, хөгжлийн яамнаас тодорхой асуух нь зөвхөн энэ бол зөвхөн нэг салбарынх шүү. Ингээд бүх салбар дээр байна. Тэгэхээр зөвхөн нэг салбар дээр байгаа ийм юмнууд дээр та нар улсын төсвийн хэмжээнд нийтэд нь алдагдсан боломжийн өртгөө тооцож үздэг юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхгүй бол бүхэл бүтэн улс байж байж 800 сая төгрөгийн спорт заал, 1 тэрбум төгрөгийн цэцэрлэгийн барилгыг нэг жил барьж чадахгүй байна гэдэг бол бид нар ингээд өөрөө өөрсдөөсөө ичих асуудал шүү. Тэгэхээр энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам маань яг алдагдсан боломжийн өртгөө бодсон тооцоолсон боломж байдаг юм уу гэдэг дээр хариулт өгөөч. Энэ улсын төсвийн төсөл чинь өөрөө буцаад инфляцад нөлөөлөөд байгаа шүү дээ.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам асууя, асуултад хариулъя. Саяын тэр хөтөлбөрүүдийн чинь үр дүн, төсвийн үр дүнгүүд чинь уялдаагүй байна

уу л гэсэн асуулт ерөнхийдөө байна шүү дээ.

И.Батхүү: Шижир гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам ТНБД Батхүү. Таны хөндсөн асуудал бол энэ төсвийн төлөвлөлт, худалдан авалтыг эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой уялдуулж явдаггүйтэй холбоотой гарч байдаг асуудлууд байгаа. Монгол Улс бол нөгөө барилгын сезон их богинохон. Гэхдээ яг тэнд тодорхой гэрээ дээр ажиллах боловсрол, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, энэ инженерүүдийн тоо хэмжээ гэх мэтчилэн асуудал нь бол авч байгаа ажилтайгаа уялдаагүй, хийсвэр тоонууд яваад байдаг. Бид нар энэ дээр судалгаа, дүгнэлт хийгээд, яг энэ удаагийн ЗГ-ын үйл ажлын хөтөлбөр дээр бас нэг ийм санаа оруулсан байгаа. 3.1.2.2 дээр эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ хязгаарыг хуулиар тогтоож, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгож, хиймэл оюун ухааныг ашиглана гэсэн заалт орчихсон байгаа.

Таны түрүүн дурдсан тиймэрхүү төсөвт өртөг нэмэгдсэн, хугацаа хэтэрсэн төслүүдийн хувьд Барилгын хөгжлийн төв, Үндэсний Аудитын газар зэрэг байгууллагуудаар төсөвт өртгийн нэмэгдлийг нь тухай бүр Сангийн яам тооцоолол хийлгээд нэг удаа ЗГ-т оруулж танилцуулаад бас арга хэмжээ авч байсан гэж мэдээлэлтэй байгаа. Нийт дүнг нь бас тодорхой гаргаж танд танилцуулж болох байх.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Яах вэ би асуугаад байгаа юм, тэгээд хариулт бол хангалтгүй л байна л даа. Гэхдээ ерөнхийдөө өнөөгийн засаг төрийн нөхцөл байдал ер нь ямар байгааг бол бас ард

түмэн ингээд хараад сууж байгаа байх. Харах нь ч зүйтэй л дээ. Хамгийн наад зах нь бензин шатахуун чинь хэзээ тасрах юм бэ? Нефтийн үйлдвэр, тос, газрын тосны үйлдвэр чинь хэзээ ашиглалтад орох юм бэ гэхэд хэн ч хариулахгүй юм. Энэ чинь амин чухал л асуудал шүү дээ. Хэрвээ хэлчихвэл энэ ард түмэн чинь ажил төрлөө зохицуулна шүү дээ. Тэгээд ЗГ бас боломжоороо л ажил төрөл хийх гээд байх шиг байна. Гэхдээ энэ мөрийн хөтөлбөр нь тэгээд биелэгдэнэ гэсэн тийм нэг их итгэл төрөхгүй байна л даа. Тийм ч болохоор сайд нар нь орж ирэхгүй байгаа байх гэж бодож байна. Тэгээд энэ хэдэн залуучууд тэгээд өөртөө хэр хэмжээндээ таарсан юмаа л яриад сууж л байна.

Үгүй ээ тэгээд энэ юм чинь хэрэгжихэд хэчнээн хэмжээний хөрөнгө, санхүү хэрэгтэй юм бэ? Энд ажиллах хүч нь хаана байгаа юм бэ? 200, 300 мянган хүн гараад явчихсан ийм л байгаа шүү дээ. Тэгээд ийм хэмжээний цалин мөнгөтэй тэгээд энэ улсууд чинь ажиллаад цаашаа амьдрал ахуй нь болох юм уу?

Хэд хэдэн аюулгүй байдал байна. Улс орны эдийн засгийн, эрчим хүчний, бензин тосны энэ юмнууд чинь яаж хангагдах юм бэ? Тэр худалдааны алдагдал байна, ОХУ-тай хэчнээн жил худалдааны алдагдалтай явж ирэв тэрийгээ яаж хангах юм бэ? Маш өндөр тарифтай явж байна шүү дээ. Тэрийгээ зохицуулж чадах юм уу, Эгийн голын усан цахилгаан станц орох юм уу, орохгүй юм уу? Энэ юмаа хийж чадахгүй байж, хийхгүй байж тэгээд дараа дараагийнхаа юмыг ярина гэдэгт хэн итгэх юм. Ийм л болчихоод байна л даа. Энийг л та нар маань ярьж хэлээд ингэмээр байх юм.

Одоо боловсролын салбар бол бүрэн дамтуурсан. Хүүхдүүдийн өдрийн хоол гэхэд ямар байна 1400 ч билүү, 2000, 3000 ч билүү. Тийм хоол унд идээд яг өсөх тэр насан дээрээ тийм шим тэжээлтэй энэ хүүхдүүд чинь яаж явах юм бэ? Тэгээд хар даа унших, бичих чадвар нь ямар

байлаа. Тэгээд энэ 10 мянган долларт хүргэнэ гээд байгаа. Үгүй ээ тэгээд энэ олон улсын байгууллагууд чинь гаднаас нь ирээд хэлээд байна шүү дээ. Дандаа ийм сайхан нартай өдрүүд байхгүй, одоо дуусаж байна. Эдийн засаг чинь жилдээ 5, 6 хувь өсвөл их юм.

Энэ дэлхийн эдийн засгийн 1, 2-т орчих гээд байгаа энэ урд талынхаа эдийн засагтай бид нар яаж холбогдоод байгаа юм бэ? Өнөөдөр баахан мухар төмөр замуудтай ингээд байж л байгаа шүү дээ. Хамгийн наад зах нь гэхэд 5, 6 мянган чингэлэг Тяньжин дээр гацчихсан байж байна.

Нөгөө талаар тэр цэргийн албаны талаар ярихад нэг оюутан цэрэг нь 3 сар хаагаад, нөгөө хүүхдүүд нь хэдэн сар нэг жил хаадаг юм уу? Энэ чинь нөгөө Үндсэн хуулиар хүндэт үүргээ биелүүлэхэд чинь тэр хүмүүсийн цаг хугацаа нэг жил байж болдог. Эд нарынх 3 сар байж байх ёстой юм уу?

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Шатахуунтай холбоотой, үнэтэй холбоотой, газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орохтой холбоотой асуудлууд дээр хариулт тайлбар өгье. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр уу? 6 номер дээр суучих уу.

Б.Анхбаяр: Сайн байцаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр. Энэ Байнгын хороон дээр харин манай яамны бас нэг өөр газрын дарга нэр нь байж байгаад тэгээд нөгөө Ронагийн ажлын хэсэгтэй холбоотой тэнд хуралтай учраас ирж амжсангүй гээд уучлалт хүсээд ярьж байгаа юм.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилтай холбоотой мэдээлэл өгье. Одоогийн байдлаар EPC1 ажил ерөнхийдөө хийгдээд дууссан. EPC1 буюу

иргэний барилга байгууламж үүнд бол оффис, гал команд, лаборатори гэсэн ийм ажлууд, агуулахын байр гэсэн ажлууд явагдсан. Энэ ажлыг бол Бүгд Найрамдах Энэтхэг улсын компани гүйцэтгэж хийсэн байгаа. Одоогийн байдлаар ЕРС2 буюу яг барилгын үйлдвэрийн үндсэн барилгын ажлын гэрээ нь бол хийгдчихсэн, барилгын ажил бол хийгдээд явж байгаа. Энэ дээр бол БНЭУ-ын Мега инженеринг гэдэг компани гэрээг байгуулсан. Мөн ялгаагүй ЕРС3 буюу цахилгаан станцын ажил дээр бас Мега инженеринг компани сонгон шалгаруулалтад бол ялсан. Тэгээд ЕРС 2, 3 ажлууд бол одоогийн байдлаар бол хийгдээд явж байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн ЕРС 4-ийн гэрээг бол одоогийн байдлаар эхний ээлжийн гэрээг бол хийгдсэн. Цаашидаа БНЭУ-ын талаас зээлийн нэмэлт санхүүжилтийн асуудлыг бол шийдвэрлэснээр ЕРС 4-ийн ажил бол 100 хувь болоод ер нь хийгдээд, ажлууд нь бол хийгдээд явахаар ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Үүнээс гадна ЕРС газрын тос боловсруулах үйлдвэрийн яг өөрийнх нь ажилчдын хотхоны ажил 2 дугаар ээлжийн ажил бол хийгдээд ерөнхийдөө дууссан байгаа. 1 дүгээр ээлжийн ажлыг бол БХЯ-ныхантай бол хамтраад хэрэгжүүлээд ингээд явж байна. Өөр асуулт нь юу байсан бол?

Г.Тэмүүлэн: Анхбаяр дарга нэмж хариулт өгье б номер.

Б.Анхбаяр: Бензин шатахуунтай холбоотой асуудлаар бол Монгол Улсын хэмжээнд бол нийт сарын хэрэглээ А92 болон дизель түлшний хэрэглээ бол нийт ойролцоогоор 200 орчим мянган тонн байна. 2024 оны байдлаар бол бид нийт 2,4 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн бол хэрэглэсэн байгаа. Өнөөдрийн байдлаар бол Монгол Улсад нийт 1,8 орчим сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлож орж ирсэн. Өнөөдрийн байдлаар А92 төрлийн авто бензиний Монгол Улсын нөөц бол 26

хоногтой, дизель түлшнийх бол 35 хоногийн нөөцтэй ингээд явж байгаа.

Саяхан гарсан энэ ОХУ-ын ЗГ-ын 1074 дугаартай экспортод бензин гаргахыг хориглосон шийдвэр гарсан. Энэ талаар бол манай яам болон ЗГ-ын зүгээс бол тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлээд явж байна. ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны ОХУ-ын талын дарга Козлов бол энэ хоригт Монгол Улс бол орохгүй гэдэг талаар бол мэдээлэл өгсөн байгаа. Бид нар Москва дахь Монгол Улсын ЭСЯ-аар дамжуулаад энэ мэдээллийг бол яг албан ёсны байдлаар бид нар авмаар байна гэдэг хүсэлтийг бол гаргачихсан байгаа. Оросын талаас бол ямарваа нэгэн байдлаар бол Монгол Улс энэ хоригт нь бол орохгүй, бид нар хэвийн үргэлжилж бүтээгдэхүүнүүдээ бол хангана гэдэг талаар бол аман байдлаар бол мэдэгдсэн байгаа. Тийм.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг бол бид нар мэдээж та бүхэн мэдээж байгаа 2019-өөс 21 оны хооронд бол ковидын цар тахлын үед бол бид нар маш их хугацаа алдсан. Энэ хугацаагаа бид нар бол Энэтхэгийн талтай нөхөхөөр төлөвлөгөө гаргачихсан ажиллаж байгаа. Төлөвлөгөөгөөр бол бид нар 2028 он гэхэд бол газрын тос боловсруулах.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд хариултыг дуусгачихъя б номер.

Б.Анхбаяр: 28 он гэхэд бид нар газрын тос боловсруулах үйлдвэрээ бол ашиглалтад оруулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Үйлдвэр ашиглалтад орсноор бид нар 1,5 сая тонн газрын тосыг боловсруулаад, 1,3 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Өнөөдрийн өсөж байгаа хэрэглээгээр бол бид нар 2028 он гэхэд бол 2,8 орчим сая тонн газрын тосны бүтээгдэхүүн Монгол Улсад хэрэглэх болов уу гэсэн тооцоо байгаа. Тэгэхээр үйлдвэр ашиглалтад орсноор бид

нар нэг ойролцоогоор 50 орчим хувийг бол хангана гэсэн, дотоодоосоо хангана гэсэн ийм дүр зураг харагдаж байгаа.

Үйлдвэр маань өөрөө гэхдээ цаашидаа дахиж өргөтгөл хийх боломжтойгоор, нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтойгоор үйлдвэрийг барьж байгаа учраас цаашидаа бид нар үйлдвэрээ ашиглалтад орсны дараагаар бол нэмж өргөжүүлж болно. Энэтхэгийн санхүүжилт бол яг ингэж байгаа Ганбат гишүүнээ ЕРС, 4 ЕРС-дээ хуваачихсан байгаа. ЕРС1-ийн мөнгө бол ерөнхийдөө ингээд гараад дуусчихсан. ЕРС 2, 3 ажлууд бол хэрэгжээд явж байгаа. Нийт 1 тэрбум 236 сая долларын зээлийн санхүүжилтийг бол бид нар авсан. Эндээс бол бид нар одоогийн байдлаар бол нэг ойролцоогоор 20 орчим хувийг бол хэрэглэчихсэн явж байгаа. Мэдээлэл өгч дууслаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу Ганбат гишүүн? Асуултад хариулъя. Ганхуяг дарга 6 номер.

Д.Ганхуяг: БХЯ-ны ТНБД, бригадын генерал Ганхуяг. Гишүүний асуултад хариулъя. Хуулиар 18 нас хүрсэн эрчүүд болгон цэргийн алба хаах үүрэгтэй. Бид бол цэргийн алба хаах тоог жил болгон нууцаар батлуулдаг. Тэрэндээ яг 100 хувь бол хүрч чаддаггүй. Яагаад гэхээр цэргийн байрны хангалт төсвөөс шалтгаалаад бид төсвийн төсөөллийг бол жил болгон явуулдаг.

Гэсэн хэдий ч бид зүгээр байгаагүй оюутан цэрэг гэдгийг бол гаргаж ирсэн. Оюутан цэрэг бол жилд 8 мянган шаардлага хангасан оюутан залуус байдаг. Бид өөрсдийнхөө бололцоогоор жил болгон мянган оюутан залуусыг аваад цэрэг, эх оронч үзлийг төлөвшүүлээд ингээд ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: 6 номер.

Д.Ганхуяг: Хуульд бол цэргийн албыг бол биеэр буюу дүйцүүлэн хаана

гэж заасан байгаа. Оюутан цэргийг бол бид бол тухайн үед хуульд нийцүүлэн гаргаж ирээд ерөөсөө бидний бололцоо л тэр. Бүгдийг нь жил хаана гэхээр үнэхээр бидэнд орон байр бусад хангамж бол хүрэлцэхгүй учраас л ийм аргыг сонгоод л явж байгаа. Хууль дээр байгаа. Оюутан цэрэг, зөвхөн оюутан цэрэгтэй холбоотой заалт дээр. Тэгээд ялгааны хувьд бол оюутан цэрэг маань бол шахсан программаар, тэгээд оюутан залуусыг амралтынх нь үед тааруулаад программыг бол ингэж шахаж явуулж байгаа. Тийм учраас ингээд 4 сар, 4 сарын хугацаанд хааж дуусаж байгаа оюутан цэрэг.

Г.Тэмүүлэн: Тавинбэх сайд хариулах уу? Эрчим хүчний эх үүсвэртэй холбоотой.

Н.Тавинбэх: Салбарын өнөөгийн нөхцөл байдал амаргүй байгаа. Ганбат гишүүн мэдээлэлтэй. ЭХЯ Тавинбэх. Бид өнөөдөр чадлын дутагдалд орсон. Чадлын дутагдалд орсон гэдэг үг болбол үйлдвэрлэдгээсээ хэрэглээ авсан гэсэн үг. Бид энэ чадлын дутагдлаас гарахын тулд ажиллаж байна. Энэ жилийн хувьд бид нар Дорнодын ДЦС-ыг 50мвт-аар өргөтгөх ажлыг дуусгаж, ашиглалтад хүлээж авсан байгаа. Энэ станцаас бид нар Хэнтий хүртэл хэрэглээг хангана. Ингэвэл төвийн эрчим хүчний нэгдсэн систем дээр нэг 20-оод мегаваттын нөөц бий болно. Энэ нөөцийг бас хязгаарлалтад орж байсан эх үүсвэрүүд хэрэглэгчдийг хангах ийм боломжтой болно гэсэн үг.

Дээр нь хувийн хөрөнгө оруулалтаар манай үндэсний компани хийж байгаа. Баян сумд 150мвт-ын Бөөрөлжүүтийн ДЦС-ын барилга, эхний барилга угсралтын ажлын эхний блок 10 сарын 15-нд ашиглалтад орно. Ингэвэл энэ жил бид нар 70-аас 80мвт-ын хязгаарлалттай байхаар хэрэглээний өсөлтийг тооцоход өвлийнхөө ачааллыг давахаар төлөв гарч байгаа.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт нүүрсээр ажилладаг 2 гегаваттын ДЦС-ыг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Энэ ажлуудаа шуурхай хэрэгжүүлж дуусгах юм бол бид 28 он гэхэд өсөх хэрэглээний таазаас одоо байгаа болоод ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эх үүсвэрүүдийг нэмбэл 20 хувийн нөөцтэй байхаар, би сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг огт оруулахгүйгээр хэлэхэд нөөцтэй байхаар эх үүсвэртэй болохоор тийм тооцоо судалгаа гарч байгаа юм. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эх үүсвэр орох хүртэл бол тодорхой хэмжээнд чадлын хязгаарлалт, чадлын дутагдалд орж явахаар байгаа. Миний саяын хэлдэг 50-70мвт.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд хариултаа өгье.

Н.Тавинбэх: Урьдчилж тооцсон хэмжээгээр хэрэглээний өсөлт гарвал хязгаарлалт хийж явна. Хязгаарлалт хийнэ гэдэг бол тасарна гэсэн үг биш.

Г.Тэмүүлэн: 2 номер Батхүү дарга худалдааны алдагдал, ажиллах хүчин.

И.Батхүү: Ганбат гишүүний асуултад хариулъя. Саяын таны асуусан ОХУ-тай гадаад худалдаа дээр манайх нийт худалдааны эргэлт 2,5 тэрбум орчим, 2,6 тэрбум орчим ам.долларын эргэлттэй байгаа. Энэ нь Монгол Улсын нийт худалдааны 10 хувь орчим. Худалдааны харилцаа нь бол 95 гэсэн харьцаатай. Монгол Улсын хувьд бол алдагдалтай байгаа. Гол импортлодог бүтээгдэхүүн нь бол шатахууны түли, тэгээд бас бордоо, бусад хэрэгцээтэй тэсрэх бодис зэрэг юунууд орж ирдэг.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас Европын, Евро Азийн эдийн засгийн холбоотой түр чөлөөт худалдааны хэлэлцээр хийж байгаа. Энэ хэлэлцээрийн хүрээнд бараа тодорхойлох кодчиллын уялдуулсан системээр 6 оронтой 375 нэр төрлийн бараан дээр ОХУ руу экспортод

гаргахад ямар нэгэн импортын болон бусад татвар тавихгүй, квот заахгүйгээр харилцан тохирсон байгаа. Энэ барааны сонголтыг хийхдээ бол үндсэн мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур гээд манай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боломжтой бүх төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаргахаар тооцсон байгаа. Энд Хөдөө аж ахуйн яам, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, бизнес эрхлэгчдийн саналыг тусгасан байгаа. Иймэрхүү хэлцэл хийж явж байгаа.

Энэ хэлцэл хүчин төгөлдөр болох үед бол Улсын Их Хурлаар оруулж танилцуулж, батлуулна. Энэ хэрэгжээд эхэлсний дараа бол экспортын боломж нэмэгдэнэ. Энэ дээр бол худалдааны алдагдал тодорхой хэмжээгээр буурна. Яг шууд одоогийн Оросын холбооноос оруулж ирж байгаа импортын бүтээгдэхүүнийг орлох тийм нефть шатахууны талаар бас том арга хэмжээнүүд дунд хугацаанд хийгдэж байж энэ худалдааны баланс бол сайжирна. Түрүүн танилцуулсан эдийн засгийн тооцоолол бол нэрлэсэн үнээр, бодит үнээр гэж эдийн засгийн өсөлтийг тооцдог. Олон улсын ярьдаг статистикаар яагаад гэх юм бол бодит үнийг авч ярьдаг. Үүгээрээ бол бид нар сая дурдсан.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батхүү дарга тодорхой.

И.Батхүү: Энэ одоогийн ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд нийт 149 төслийг яг оруулж зааж өгсөн байгаа. Энд бас хэрэгцээтэй эх үүсвэр нь 130, ойролцоогоор 133 их наяд одоогийн байдлаар тооцоолно. Үүнээсээ 9 хувийг нь улсын төсвөөр энэ 4 жилийн хугацаанд санхүүжүүлэх боломжтой гэж харж байгаа. 11 хувийг нь бол гаднын нэн хөнгөлөлттэй зээл, тусламжаар, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх боломжтой гэж харж байна. Улсын төсөвт ачаалал өгөхгүйгээр 31 хувийг нь шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ

гэж үзэж байгаа. Мөн шинээр батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хүрээнд 29 буюу бараг 30 орчим хувийнх нь төслийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа.

Энэ төслүүдийг бол заавал улсын төсөв, орон нутгийн төсөв гэхгүйгээр бусад боломжтой эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ. Энэ төслүүд хэрэгжихэд мэдээж энэ төсөл хэрэгжүүлэх хувийн хэвшлийн өөрсдийнх нь ажиллах хүчний бололцоо мөн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа тохиолдолд гаднаас орж ирж байгаа ажиллах хүчин, техник технологи, бусад төрлийн нөөцүүд ашиглагдана. Энэ түрүүн бас Шижир гишүүний асуултад хариулж байсан. Бид нар энэ төсвийн төлөвлөлт, худалдан авалтын тогтолцоог сайжруулах талаар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой заалт оруулсан байгаа. Энэ заалтыг хэрэгжүүлэх юм бол ер нь бодит эдийн засгийн нөөц бололцоонд уялдуулсан төсвийн төлөвлөлтүүд ирэх жилүүдэд хийгдэнэ. Тэгэх юм бол үйл ажиллагаа нь арай бодитой хэрэгжинэ гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Ганбат гишүүн.

Д.Ганбат: Яах вэ би та нар яах вэ ямар хэмжээний хариулт өгөхийг чинь мэдэж л байгаа юм л даа. Гэхдээ энэ ажил амьдралаа хүмүүс ингээд зохицуулаг. Энэ асуулт, хариулт энэ юмнаас хараад. Энэ мөрийн хөтөлбөр ямар биелэх боломжтойг бас хараг л гэж асуулт асуугаад байгаа шүү дээ. Энийгээ яг биелэх боломжтой гэдгээ батлаад нотлоод байгаа юм ерөөсөө алга л байна л даа. Ажиллах хүчний чинь 200, 300 мянга нь гадагшаа гараад явчихсан байна. Ийм хүнд нөхцөлд байна. Манай хүүхдүүд гэхэд боловсролын салбарт ямар байгаа билээ, хоол ундных нь шим тэжээл нь ямар байгаа билээ, бараг шоронгийн хүнээс долоон дор л юмаар хооллож байгаа шүү дээ гэх мэтчилний.

Тэгээд гадагшаа гараад урд талын дэлхийн 2 дахь эдийн засагтай холбогдох энэ дэд бүтэц чинь байхгүй. Одоо уурхайн бүтээгдэхүүний хувьд улам унаж эхэлнэ. Тэгэхээр энэ юмнууд чинь ингээд хүндэрчхэж байна. Эрчим хүч бол ингээд хязгаарлана гэдэг нэрийн дор байнга таслаад байх юм байна та нар. Нөгөө талаар бол бензин шатахуунаар бас албан ёсны тийм хариугаа авч чадаагүй юм байна таслахгүй гэдэг. Зүгээр л амаар л ярьсан юм байгаа юм байна. Тэгээд ийм юмнуудаа тодорхой хэлээд чадахгүй бол чадахгүй гэдэг юмаа хэлчихвэл энэ ард түмэн чинь өөрийнхөө амьдрал ахуйг зохицуулна шүү дээ. Тэгээд хийж чаддаг хүмүүсийг нь солиод явна шүү дээ. Хэн нь хариуцлага хүлээх юм бэ, хариуцлага хүлээх юм алга байна.

Монгол Улсын эдийн засгийн ДНБ-ий 30, 40 хувийг нь улсын төсөв дээр аваачаад тавьчихаж байна. Дээр нь байнга сайд болдог хэдэн нөхдүүдийн бизнесийг нэмчихвэл бараг 70, 80 хувь байх. Тэгээд энэ хувийн хэвшил чинь хаана нь ажиллаж, амьдрах юм бэ? Бүгд л эх орноосоо гарахаас аргагүй байдалд ийм түлхэж байна шүү дээ. Тэгээд одоо улс орныг тэр В... гэж ямар сайхан улс орон байлаа, нэг автобусны жолооч яаж дампуурууллаа. Үгүй ээ энэ төрийн чинь оролцоо, үгүй ээ ардчиллын бүх институт нь байгаад байдаг. Дүр эсгэсэн ардчилал болчихоод байна шүү дээ энэ чинь. Бүгд ажиллахгүй болгочихсон энэ юмнуудыг. Ингэж явмааргүй байгаа юм. Энэ алдаа, энэ юмны чинь хажуугаар дуугүй яваад байх тусам.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батхүү дарга хариулъя. Гол асуугаад байгаа асуулт, гол асуугаад байгаа асуулт энэ макро эдийн засаг чинь дийлэх юм уу? Та бас сая бас л их хариуцлагагүй л зүйл хэлэх юм. Бид нар шууд хөрөнгө оруулалтаар улсын төсөвт ачаалал учруулахгүйгээр шийднэ гэж яриад байдаг. Улсын төсөвт ачаалал учруулахгүй гэдэг чинь тэртээ тэргүй бонд байна уу, энэ чинь эсвэл ялгаагүй зээл

байна уу эргээгээд л ачаалал үүсгэнэ шүү дээ.

Тэгээд гол яриад байгаа асуудал энэ улс төрийн зардлыг чинь төсөв, эдийн засаг дийлэх юм уу л гэдэг асуудлыг яриад байна шүү дээ. Бонд гаргадаг, зээл авдаг, концепцоор хийсэн ч ялгаа байхгүй өрийн дарамт үүсгэдэг. Эргээд төлбөрийн тэнцэл нь дийлэхгүй сөргөөр нөлөөлдөг. Валютын ханшид дарамт учруулбал яах вэ, ханш унавал яах вэ гэдэг асуудлууд яриад байна. Тэгэхээр ийм баталгаа байна уу? Гол нь бол тэгээд нэг талдаа зориглоод хийж байгаа болбол энэ уг нь бүх эрсдэлүүдээ л бид нар тооцох ёстой болчихоод байгаа юм. Гадаад валютын нөөцдөө нөлөөлбөл яах вэ, эдийн засгийн өсөлт саарвал яах вэ гэдэг асуудлууд байна шүү дээ. Энэ болгон дээр бол макро эдийн засгийн тооцооллыг хийх үндсэн үүрэг бол Эдийн засгийн хөгжлийн яаман дээр байгаа. Та бүхэн маань бол үүндээ нийцүүлж, төсвийн тодотголыг оруулж ирэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг нийцүүлж оруулж ирэх үндсэн үүрэг байгаа. Энийг л асуугаад байна. 2 номер.

И.Батхүү: Ганбат гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамнаас гаргасан тооцоолол тухайлбал нөгөө эдийн засгийн өсөлтийг 6-аас дээш хувьд 10 жил хадгалах, гадаад валютын нөөцийг 10 тэрбум долларт хүргэх, инфляцыг 5 хувиас доош барих гэх мэтчилэн эдийн засгийн зорилтууд маань цаад агуулгаараа яг энэ ЗГ-ын үйл ажлын хөтөлбөртөө тусгасан бусад нийгэм, эдийн засгийн зорилтуудыг хүрэх түвшинүүдийг хангахад чиглэсэн макро эдийн засгийн зорилтууд гэж ойлгож байгаа.

Мэдээж үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бас мөнгөний бодлого, төсвийн бодлого уялдуулах зэрэг олон талаасаа бас анхаарах зүйлс бий. Таны тодорхой асуулт дээр жишээ нь урд БНХАУ-тай холболтуудыг яаж хийх вэ, эдийн засагт яаж нөлөөлөх вэ гэдэг дээр бол энэ Гацуунсухайт, Шивээхүрэн,

Ханги боомтуудын холболтыг бас ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр хамгийн нэн тэргүүнд авч үзэж, тусгасан байгаа. Хятадын хойд мужуудын өсөлт бол 5 хувиас байнга дээш байхаар дүр төрхтэй харагдаж байгаа. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр нь өөрөө ЗГ-ын тавьж байгаа зорилго, зорилтуудын хэлбэртэй баримт бичиг учраас энийг биелүүлэх талаар ЗГ-ын бүтцийн бүх байгууллага, яамнууд ажиллах ёстой. Энэ хариуцах эзэн, санхүүжилтийн дүн, хугацаа, суурь түвшин, хүрэх зорилтыг энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нарийвчлан тусгаад, ЗГ-аас баталж хэрэгжүүлж ажиллана. Энэ хэрэгжилт дээр нь бас тухай бүр холбогдох журмын дагуу хяналт мониторинг хийгдэж явагдана.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Одоо яг энэ бид нар Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо, дээрээс нь яг энэ тогтоолын төслийн 3 дугаар хэсэг байгаа энийг хэлэлцэж байгаа. 3 дугаар хэсэг дээр болбол бүсийн хөгжлийн зорилгыг тодорхой биччихсэн байгаа юм л даа. Бүсийн хөгжлийн, би жишээ дурдахад бол бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд Монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс болно гээд ингээд бүс болгон дээрээ ингээд нэг ийм газар зүйн байрлал, тухайн эдийн засгийнх нь байр байдал модельд нь тулгуурлаад нэг ийм нэртэй бүс байна гээд ийм 6 төрлийн нэр өгчихсөн байгаад байгаа шүү дээ тийм ээ нэг.

Тэгэхээр нөгөө иргэн баян бол улс баян гэдэг шиг иргэн өрсөлдөх чадвартай бол улс өрсөлдөх чадвартай байна. Дээрээс нь энэ 6 бүс чинь хоорондоо

өрсөлдөх биш, нийлээд дундаасаа Монголын өрсөлдөх чадварыг л ахиулах зорилготой гэж харагдаад байгаа. Тэгэхээр энэ дээр бол асуулт нь болохоороо энд ер нь энэ competitiveness буюу нөгөө өрсөлдөх чадвараа яаж оруулж байгаа юм бэ? Энэ үгийг үгээр орох зайлшгүй л надад шаардлагатай юм шиг санагдаад байгаа байхгүй юу. Ер нь болбол би бас энэний дараагаар зарчмын зөрүүтэй 1 саналыг Байнгын хороонд оруулах гэж байгаа. Тэрийг тухайн, Тэмүүлэн даргаа тэр зарчмын зөрүүтэй саналыг дараа нь тайлбарлаад санал хураалт явна шүү дээ тийм ээ. Тэгээд тэрийг бол дараа нь ярья.

Тэгэхээр ер нь болбол энэ 2020-оос 24 оны ЗГ-ын мөрийн хөтөлбөр дээр жишээлбэл говийн бүсэд шинжлэх ухааны чиглэлтэй зүйлүүд байсан энэ дээр жишээлбэл хасагдчихсан, байхгүй байгаад байгаа. Тэгэхээр нөгөө төрийн бодлогын залгамж холбоо гэдэг утгаараа тэрийгээ бас авмаар байна. Тэрийг би зарчмын зөрүүтэй санал болгож томъёолж оруулах гээд байгаа юм.

Тэгээд тэрний өмнө нь хэлэхэд болбол энэ бүсүүдийн зорилго нэг тийм өнгөрсөн түүх Монголын одоо байгаагаас хойших руугаа илүү их текст нь бичсэн байгаад байгаа. Эцсийн эцэст энэ бүх бүсүүдийн зорилго чинь тэнд байгаа хүмүүсийн амьдрал ахуйг сайжруулах, эдийн засгийг ахиулах, хүртээмжтэй болгох, улмаар тэнд хүмүүс заавал хот руу шаваад байхгүй, тухайн бүс болгондоо ингээд үйлдвэрлэл нь хөгждөг, технологи нь хөгждөг, амьдрал нь сайжирдаг байх тэр модель гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр болбол Эрдэнэбат даргаа ингэж болох уу? Өрсөлдөх чадварыг яг бүс бүсэд нь тааруулсан байдлаар энэ дээр жишээлбэл оруулах боломж хэр байдаг юм бэ, энийг ер нь яаж хангаж байгаа юм гээд энэ 1 дүгээр асуулт нь байгаад байгаа.

2-т нь болбол мэдээж бид нар ингээд гадаад бодлого, аюулгүй байдал

гэж байна. Гадаад бодлого гэнгүүт сая Байнгын хорооны дарга гадаад бодлогыг худалдаатай холбох гэсэн зүйл яриад байгаа учраас энэ бүсүүдийн чинь зорилго тэнд байгаа үйлдвэрлэл, ажлын байрууд чинь эргээд л нөгөө Монголын худалдаатай чинь холбогдоно. Цаашилаад Монголын олон улсад өрсөлдөх чадвартай чинь холбогдоно. Тэгэхээр энийгээ жоохон жоохон тодотгож болох уу? Жишээлбэл өрсөлдөх чадварыг энэ энүүгээр өрсөлдөнө гээд. Өөрөөр хэлбэл бүсүүд хоорондоо өрсөлдөх тухай биш, Монголын өрсөлдөх чадварын үнэ цэнийг хэрхэн нэмэх талаар та яг яаж төсөөлж байгаа вэ? Энэ талаар жоохон тайлбарлаж өгөөч?

Г.Тэмүүлэн: 1 номер, 6 номер дараа нь. Эхлээд 6 номер асуултад хариулчих. Дараа нь 1 номер.

Д.Эрдэнэбаяр: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 23 жилийн дараа энэ жил бол Улсын Их Хурлаар шинэчлэн баталсан. Энэ хүрээндээ болбол олон улсад явж байгаа концепцын өөрчлөлттэй уялдуулж илүү бүс нутагт байгаа үйлдвэр, үйлчилгээ, худалдааны байгууллагуудыг төр болбол зах зээлийг нь нээж өгөх буюу борлуулалтаар нь дэмжих ийм нэлээн хувийн хэвшлийг дэмжих концепцыг болбол оруулж бүсчилсэн хөгжлийн бодлогоо бол шинэчлэн баталсан. Тэгэхээр үзэл баримтлал маань болбол зөвхөн энэ бүсчилсэн хөгжлийн бодлогын нэг алсын хараа болж байгаа зүйл.

Үүний дараа бид нар болбол бүсчилсэн хөгжлийн бүсүүдийн зорилтот хөтөлбөрийг бүс тус бүрээр хийх ийм ажил болбол хүлээгдэж байгаа. Одоо болбол 6 бүсээр ингээд техник, эдийн засгийн урьдчилсан судалгаанууд хийгдээд явна. Тэгэхээр энэ зорилтот хөтөлбөр маань Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулиар бол 10 жилийн хугацаатай байхаар төлөвлөгдөж байгаа. Тэгэхээр таны ярьсан санал болбол үзэл баримтлалд бол

туссан. Үүнийг хэрэгжүүлэхдээ бүсийн зорилтот хөтөлбөрт нь тусгаад явах ийм боломж бололцоо болбол байгаа. Одоо болбол бол энэ орж байгаа өөрчлөлт бол зөвхөн бүсүүдийн тэргүүлэх чиглэлийг 1, 2 гэдгээр зааж өгөх ийм өөрчлөлт явж байгаа учраас энэ дээр болбол бас оруулах ийм асуудал нь болбол зорилтот хөтөлбөр лүүгээ оруулсан нь илүү зүйтэй болов уу гэж ингэж бодож байна.

Бүс болгоны онцлогт тохирсон талбайн төлөвлөлт буюу тухайн бүсийн нөхцөл, нөөц, байгалийн байришлын давуу талд түшиглэсэн талбайн төлөвлөлтүүдийг хийхээр болбол Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгасан. Өөрөөр хэлбэл чөлөөт бүс, тусгай бүс, үйлдвэр технологийн парк, таны ярьж байгаа энэ судалгааны төвүүдийг шинжлэх ухааны технологийн парк хэлбэрээр зохион байгуулах тусгайлсан байршлуудыг болбол 69, 21 аймгийн төв дээр нэмэх нь 69 байрилаар тодотгож өгсний нэг нь бол таны ярьж байгаа энэ төслийн талбайн төлөвлөлтийн байришил орсон байгаа гэдгийг бас танд хэлье.

Г.Тэмүүлэн: Албан тушаал, нэрээ протоколд хэлээрэй.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр.

Г.Тэмүүлэн: Номер, 1 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам зөвлөх Эрдэнэбат. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. 2 асуулт гэж ойлголоо. Нэг нь сансар суудалтай холбоотой заалтууд нэлээд орсон байгаа. Энэ дээр ач холбогдол нь гээд 4.3.2-ын дэд бүлгийг нь бүр нэрлээд явчихсан байгаа. Гадаад бодлого дээр ч гэсэн бас хэд хэдэн заалтууд ингээд ороод явж байгаа.

2 дахь асуудал бол тэр индекс дээр өрсөлдөх чадварын индекс Дэлхийн эдийн засгийн форумас анх гараад Монголд нутагшаад 21 аймгийн индексүүд сайн хийгдээд явж байгаа. Шинжлэх ухааны үндэслэлтэй, хүлээн зөвшөөрөгдсөн нэг индекс байгаа. Тэр маань энд хараахан тусгаагүй. Та зарчмын зөрүүтэй саналаараа оруулчихвал бидний зүгээс хүлээж авч дэмжихэд бэлэн байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу Эрдэнэболд гишүүн, нэмж тодруулах юм уу? Нэмж тодруулъя Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэр нөгөө чуулган дээр Эдийн засаг, хөгжлийн сайд бол ондоо багтаад энэ хөтөлбөрөө гаргачихна гэсэн. Ер нь миний ойлгож байгаагаар таны ярьж байгаа энэ дэд хөтөлбөрүүд ингээд детальчилж байгаа шүү дээ тийм ээ. Энэ судалгаа энэ ондоо багтаад явчих уу? Ирэх жилийн 1 сарын 1 гэхэд ер нь ингээд жигдрээд хаанаа ямар хөгжлийн загвараа төлөвлөөд байгаа, давуу, сул тал ингээд бүх юмаа ойлгоод явчхаж болно гэж ойлгож болох уу?

Г.Тэмүүлэн: 6 номер.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр. Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн байгуулах тухай ЗГ-ын тогтоол гарсан. Одоо төсвийн тодотгол болон ирэх жилийн төсөв дээр болбол энэ судалгаа шинжилгээнд шаардлагатай бүсүүдийн нарийвчилсан төлөвлөгөөг хийхэд нийтдээ 60 тэрбум төгрөгийн төсвийг төлөвлөөд, хэлэлцүүлээд явж байгаа.

Ерөнхий сайдаас өгч байгаа үүргийн дагуу болбол ирэх оны 1 дүгээр улиралд багтааж бүсүүдэд хэрэгжүүлэх томоохон төслүүд, ажлын зураг, ТЭЗҮ-үүдийг бол хийж дуусгах ийм үүрэг өгсөн байгаа. Мэдээж энэ бол Худалдан авах ажиллагааны хуулийн дагуу явах учраас бас тодорхой хугацаа энэ

шалгаруулалтад шаардагдана. Мөн ТЭЗҮ-д холбогддог зураг, тооцоог бол дор хаяж 3-аас дээш сар хийх ёстой байдаг.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд 3 дугаар заалттай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Тогтоолын төслийн 4 дүгээр заалттай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Хугацаатай холбоотой л зүйл байгаа. Байхгүй байна гэж ойлголоо. Ингээд гишүүд зүйл бүрээр асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол бичгүүд, бичгээр гаргах ёстой байгаа. Гишүүд гаргасан томъёолол байвал санал хураалтыг болбол явуулна. 2 зарчмын зөрүүтэй саналын томъёолол байна гэж ойлголоо. Тэмүүжин гишүүн 1 саналын томъёолол гаргасан байна. Эрдэнэболд гишүүн 1 саналын томъёолол гаргасан байна. Уншиж танилцуулья.

Саналын томъёолол, саналын утга нь 4 дүгээр зүйлийн 4.3.7-г өөрчлөх үү? 4 дүгээр зүйл 4.4.3.7-г өөрчлөх Эх орны дуудлага, эр цэргийн албаны хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар зэвсэгт хүчин албан хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ гэсэн. Дээшлүүлнэ гэж өөрчилж байгаа юм байна. Тайлбар хэлж болно гаргасан саналын томъёолол дээрээ. Энэтэй бас холбогдуулж гишүүд асуулт асууж болно. Томъёолол гаргасан хүнээс. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Нэлээн зөв зүйтэй санал гаргаж байна гэж ойлгож байна. Ер нь бол дэмжинэ. Би түрүүн асуулт асуулаа л даа. Нөгөө Үндсэн хуулиараа ерөөсөө цэргийн алба чинь өөрөө тэгээд иргэний хүндэт үүрэг л дээ. Бүгдээрээ л биелүүлэх ёстой. Тэгээд сая ярьж байна. Тэр 4 сар оюутан цэрэг алба хаагаад

бусад нь яадаг ч юм 12 сарын сар алба хаагаад, үнэхээр цэргийн албаны сургалтыг 3, 4 сард явуулж чадаж л байгаа бол бүгдээрээ л тэгж хаах хэрэгтэй л дээ. Тэгээд ийм ялгаатай байдлууд чинь хүмүүст бас ойлгомжгүй болчихоод байна л даа.

Тэр чинь 18 нас хүрсэн Монгол Улсын иргэд бүгдээрээ л адилхан шүү дээ. Тэр нь тэр, энэ нь энэ гээгүй. Тэгээд оюутан болчихоороо л 4 сар алба хаагаад болчихдог бусад нь болохоороо нэг жил алба хаадаг. Энийг та юу гэж үзэж байна вэ? Энэ дотор наад цэргийн албаны нэр хүнд энэ тэр гээд энэ сурталчилгаа гээд энэ юмнууд чинь орно шүү дээ. Энэ чинь тэгээд л бүгд л иргэд нэг ялгаатай байх юм шиг ийм ойлголт хүмүүсийн толгойд суучхаад байна л даа.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа 4.4.3.7 маань хуучин бол ямар байсан гэхээр эх орны дуудлага, эр цэргийн албаны хүрээнд иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, цэргийн цэргийн албан хаагчийн нийгэмчлэх байр суурийг нэмэгдүүлэх гэж байсан юм. Зарчмын зөрүүтэй санал дээр гол агуулга нь юу орж байгаа вэ гэхээр батлан хамгаалах, ингээж байгаа, батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар зэвсэгт хүчний хүчин, албан хаагч, хаагчийн олон нийтийн дэмжлэг нэр хүндийг дээшлүүлнэ гээд.

Тэгээд энэ дээр хамгийн гол акцент өгч байгаа зүйл бол ер нь бол ингээд цэргийн байгууллагад батлан хамгаалахын чиглэлийн сургалт сурталчилгааг нэлээн идэвхжүүлж тэгж байж нөгөө эх оронч үзлийг иргэдэд төлөвшүүлэхгүй бол энэ нөгөө цагийн нөхцөл байдал, Украин, Оросын дайн гэх мэтчилэн олон асуудал дээр чинь ер нь бол

иргэдээс тулгуурласан, иргэдийнхээ оролцоо дээр түшиглэсэн, орон нутгийн хамгаалалт дээр түшиглэж л энэ сөрөн тэсвэрлэх чадвараа дээшлүүлж байна шүү дээ.

Тийм учраас манайд байнга гардаг цэрэгт татсан хүмүүст ямар сургалт явуулдаг юм, юу заадаг юм, зарим олон нийтийн санаа бодол бол юу ч заахгүй дэглээд л байж байдаг шүү дээ гэдэг тийм нэг ойлголт суучихлаа. Тэгээд энийг бол өөрчлөөд, энэ сургалтынхан нь зохион байгуулалт агуулга дээр бол томоохон өөрчлөлт хийх ёстой юм байна. Ядаж цэргийн алба хаагаад гараад ирж байгаа хүн хажуудаа осол эндэгдэл гарч байгаа нөхцөлд бол анхан шатын эмнэлгийн тусламж үзүүлэх чадвартай байх хэрэгтэй юм байна. Эрсдэлийг үнэлэх чадвартай байх хэрэгтэй юм байна. Иргэдийг аюулгүй нөхцөл байдлаа үнэлээд, дагуулаад, аюулгүй аюултай нөхцөл байдлаас аюулгүй нөхцөл байдал руу шилжээд хөдөлгөөн хийх чадвартай байх ёстой юм байна. Зохион байгуулалт хийх чадвартай байх ёстой юм байна. Галт зэвсэг эзэмших болон өөр шинэ технологийнхоо дэвшилд суралцах ёстой юм байна. Ядаж төрөл нь сайжраад энэ дронеор байлдаад эхэллээ шүү дээ ер нь бол бодит байдал дээр биечилсэн тулгаралт байхгүй. Тэгээд энэ чиглэлийн шинэ төрлүүдийгээ хөгжүүлэх ёстой юм байна гэх мэтчилэн ингээд нэлээн олон асуудлыг нь шийдэх ёстой болж эхэлж байгаа юм.

Ганбат гишүүний асуусан асуулт дээр дахиад хэлэхэд урд байгаа цагдаагийн байгууллагаас дотоодын цэргийг салгаад бараг Үндэсний гварди маягийн хэлбэрт оруулаад, орон нутгийн хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, байгалийн гамшиг энэ гамшигийн үед дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хэв журам сахиулах эмх замбараагүй байдал үүсгэх үед бас дэмжлэг үзүүлэх гэх мэтчилэнгээр тэнд бас дэмжлэгийн бүтэц байгаа. Тэнд бас энэ чиглэлийн сургалтын тогтолцоо байгаа. Тэгэхээр

орон нутгийн иргэд цэргийн албанд татагдаад батлан хамгаалах чиглэлийн сургалт явахаасаа гадна, орон нутагтаа хамгаалалт хийх чадвартай болохын тулд тэр орон нутгийнхаа бүтэц дээр бас сургалт хийх шаардлага гарч ирж байгаа байхгүй юу. Энэ батлан хамгаалах цэргийн бодлого дотор ч гэсэн байна лээ. Томилгоот бүлгээс гадна нөгөө орон нутгийн иргэдийг хамгаалалтад сургах тухай.

Арми бол довтолгооны чадвараа илүү сайн нэмэгдүүлэх байх, олон улсад нэр хүндтэй энхийг сахиулах үйл ажиллагаанд явуулах тэр тогтолцоогоо илүү сайжруулах байх. Гэхдээ орон нутгийг иргэдийг татан оруулах замаар яаж цэвэр ус, яаж цахилгаан, эрчим хүч, яаж хүнсний нөөц гэх мэтчилэн хамгийн тулгуур суурь дэд бүтцүүдээ хамтын хүчээр хамгаалдаг болох юм бэ гэдэг чинь бас энэ хүрээнд яригдана. Энэний чинь сургалтын агуулга энэ хүрээнд бас хийгдэнэ.

Нэг болгоомжлох зүйл байсан юм тэр нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлнэ гэхээр ардчилсан бүгд найрамдах төртэй улс орон чинь өөрөө цэргийн дэглэм болон шашны дэглэмээс ангид байх ёстой. Харин үгүйлэгдэж байгаа гол юм бол ерөөсөө арми болон батлан хамгаалах энэ цэргийн тогтолцоог олон нийтэд яаж ингээд дэмжүүлэх юм, хүлээн зөвшөөрүүлэх юм, нэр хүндийг нь яаж өсгөх юм гэдэг л зорилго энэ агуулга дотор байна гээд энэ нийгэмд эзлэх байр суурийг дээшлүүлэх гэдэг үгийг нь сольж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Хурууны хээ уншихгүй байна? Батбаатар гишүүнийх хурууны хээ уншаагүй юу тийм ээ? Тэгвэл дахиж хурааа даа сая техник ажиллаагүй. Та горимын санал гаргачих.

Батбаатар гишүүн дахиж хураах техник ажиллаагүй байна тийм. Батбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Батбаатар: Төхөөрөмж сая хурууны хээ уншаагүй учраас санал хураалтад оролцож чадсангүй. Дахин санал хураалгах санал оруулж байна горимын санал.

Г.Тэмүүлэн: Горимын саналаар санал хураалт явуулъя дахин санал хураах. Санал хураалт. Төхөөрөмж ажиллахгүй байгаад байна, 2 ч гишүүнийх сая орсонгүй гэсэн. Хэн хэнийх ороогүй вэ? Батбаатар гишүүн, Сайнзориг гишүүнийх бас ороогүй байна. Туршилтын дахиад нэг санал хураалт нэг явуулчих уу? Тэгье туршилтын санал хураалт явуулаадахъя техник ажиллахгүй, хуруу орохгүй байна гэсэн санал байна. Туршилтынх нэг үзээдэхье, дэмжье гэдгээр. Бас яг Батбаатар гишүүн, Сайнзориг гишүүдийнх орохгүй байгаад байна. Та 2 маань төхөөрөмжөө солиод үзэх үү? Хуруу нь уншихгүй байгаад байгаа бол.

Энэ сайд нарыг орж ир гэж хэлээрэй, ЗГ-ын хуралдаан дууссан байх ёстой. 4 сайд байгаа, 2 сайд, 1 сайд орж ирсэн байна. Төхөөрөмж орчихсон уу? Сайнзориг гишүүн. Тэгвэл одоо туршилтынх дахиад нэг хийгээдэхье шинэ төхөөрөмж дээр. Туршилтын санал хураалт дэмжье гэдгээр зөвшөөрснөө дарна шүү, хүлээж байгаарай болоогүй юу? Болсон уу? 1 санал хураалт явуулчих уу туршилтынхаар. Болсон уу Сайнзориг гишүүн? Туршилтын тест санал хураалт. Болж байна.

Тест болж байгаа учраас горимынхоо саналаар дахиад санал хураалтыг явуулъя. Батбаатар гишүүн гаргасан байгаа. Горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт. Ганбат гишүүнийх болохгүй байна. Зүүн талын жигүүр ер нь Сайнзориг, Батбаатар, тийм үү? Тийм байна минийх бас эсрэг гарсан байна 2

байна. Дахиад нэг үзчихье тэгэх үү тестээр? Уг нь алдаг оног орж гараад л байна даа шинэ төхөөрөмж. Ганбат гишүүнийх л болохгүй байгаа даа. Протоколоор явчихъя даа Ганбат гишүүнийх. Та өөрөө бас юунд хэлчхээрэй.

Горимын саналаар 2 санал хураалт яваад болно. Ганбат гишүүнийхийг болохгүй бол протоколоор Ганбат гишүүнийхийг оруулъя. Санал хураалт. Ганбат гишүүнийх орохгүй байна. Протоколд тусгаад явчихъя. Ганбат гишүүн та бас протокол хэлчих. Дэмжсэнээр авч байна. 19-өөс 11 Эрдэнэболд гишүүн, Ганбат гишүүд төхөөрөмж нь ажиллахгүй байна, дэмжсэнээр бас протоколд бас тусгаж оруулж байна. Ингээд 19-өөс 11 гээд горимын санал дэмжигдсэн байна.

Горимын санал дэмжигдсэн учир саяын Тэмүүжин гишүүний гаргасан санал, саналын томъёолоор дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. 52,6 хувиар дэмжигдлээ. Ганбат гишүүнийх нэмж орсон уу? Дэмжиж байгаа юу? Ганбат гишүүн бас дэмжиж байгаа гэж байна. 19-өөс 11 дэмжигдлээ.

2 дахь зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа. Эрдэнэболд гишүүн гаргахаар байгаа. Эрдэнэболд гишүүнд саналынхаа томъёоллыг тайлбарлахыг хүсье. Микрофон өгье.

С.Эрдэнэболд: Зарчмын зөрүүтэй санал дээр нэмэх зүйл байгаа. Энэ 3.б дээр бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг хөгжүүлж, уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс болно гэж тус тус өөрчилсүгэй гэсэн ийм текст байгаа юм.

Энэ дээр 2 үг нэмэх санаатай байгаа. 2 үг гэдэг нь цаанаа бас 2 агуулга гэсэн үг. Энийг уул уурхай, говийн унаган

байгаль, түүх, соёлын өв, шинжлэх ухаан гэж үгийг нэмж оруулмаар байгаа. Тэгээд шинжлэх ухааны, палеонтологийн нөөцөд түшиглэн тэгээд үндсэн нөгөө аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс болно гэдэг дээр технологи, аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс болно гэдэг саналыг оруулж байгаа юм.

Шалтгаан нь шинжлэх ухаан гэхээр бид нар бол ингэж хэж байгаа юм л даа. Ер нь болбол нөгөө 2020 оны ЗГ-ын мөрийн хөтөлбөрт чинь говийн бүсэд шинжлэх ухааныг хөгжүүлнэ, тэр дотроо бас нөгөө сансрын шинжлэх ухааныг хөгжүүлнэ гээд ингээд заалтууд яваад байгаа. Тэгэхдээ Эрдэнэбат даргын хэлж байгаагаар болбол нөгөө дэд хөтөлбөрүүдэд нь орчихсон байгаа авч, яг энэ тодорхой гарчиг болж байгаа толгой өгүүлбэр дээрээ ингээд заавал сансар эд нар гэхгүйгээр шинжлэх ухаан гэдэг ерөнхий нэрээр нь оруулчихъя гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байгаа. Ингээд аж үйлдвэрийн төрөлжсөн гэдэг дээр болбол технологи, аж үйлдвэрийн гээд ерөнхий нэрээр нь оруулчихъя гэж байгаа юм. Тэгэх юм болбол бас ингээд дараа дараагийн бодлогын бичиг баримтууд детальчлаад ингээд нарийвчлаад явахад болбол энийгээ ингээд юу гэдэг юм эшлэл үндэслэл болгоод явчихвал бас зохимжтой юм болов уу.

Тэгэхгүй болохоор нөгөө хайж олох гээд байна л даа. Ийм л саналыг дэвшүүлж байгаа. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүд бас энэ саналыг дэмжиж өгөөч гэж хүсэж байгаа. Нэгэнт доороо байгаа ингээд деталь зүйлийг дээр нь томъёолол дээрээ оруулчихъя л гэсэн санаа.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Шинжлэх ухаан гэдэг л үг нэмж байгаа юм байна шүү дээ. Тэрийгээ та дахиад хэлчих. Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Энэ бид нар ингээд тогтоолын төслийн 3 гэдэг хэсэг байгаа биз тэрний хамгийн доод талын бүлэг өгүүлбэрийн яг нөгөө одоо байсныг нь яаж өөрчлөх вэ гэдэг нь 3.6 дахь заалт гээд биччихсэн байгаа юм. Энэ 3.6 дахь заалт дотор дахиад хэлье. Бүсийн хөгжлийн зорилго нь БНХАУ болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж гэхчээд уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн гэж байгаа дотор түүх соёлын өвийн ар талд, палеонтологи гэдгийн урд талд нь шинжлэх ухаан гэдэг үгийг нэмчхээч л гэдэг зүйл байгаа юм.

2 дугаарт аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс болно гэдгийг технологи, аж үйлдвэрийн төрөлжсөн гэдэг байдлаар явбал зүгээр байгаад байгаа юм. Бид нар ер нь аж үйлдвэр гэхээр ер нь илүү нөгөө нэг тийм хүнд үйлдвэрлэл гэдэг ерөнхий түгээмэл ойлголт байгаа шүү дээ. Тэрнийхээ урд талд технологи гээд оруулчихаач л гэсэн санаа аваад байгаа юм.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам дэмжиж байгаа гэж ойлгож байна тийм ээ? Саналгүй байна, толгой дохиж байна. Эрдэнэбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явъя, дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулна. 57,9 хувиар дэмжигдлээ.

Ингээд Их хурлын тогтоолын төслийг, дахиад санал байна уу танд? Тийм. Та томъёолоо тэгвэл хэлэх үү? Тэмүүжин гишүүн. Бас 3 дахь зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа гэж байна.

Х.Тэмүүжин: Тийм. Би энэ редакцын маягийн энэ саналыг гаргачихъя. 4.4.1.3 3 дотроос ёс суртахууны доголдол гэдэг үгийг хасъя.

4.4.1.4-д байгаа ёс зүйтэй гэдгийг хариуцлагатай гэж өөрчилъе.

Г.Тэмүүлэн: Тэмүүжин гишүүний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёололтой Эдийн засгийн хөгжлийн яам тодорхой байр суурь зүгээр үү? Дэмжиж байна гэж ойлголоо. Тэгвэл санал хураалт явуулах уу? Саяын зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. 52,6 хувиар дэмжигдлээ. Жангабыл гишүүн бас зарчмын зөрүүтэй саналын томъёолол байгаа юм байна. Микрофон дээр та саналаа тайлбарлая.

Х.Жангабыл: Энэ зарчмын зөрүүтэй саналуудаа энэ урьдчилж өгч болдоггүй юм уу? Бид бол хаана юу байгааг нь будилаад байна шүү дээ. Анх орж ирээд тэгээд байгаа юм уу энэ чинь одоо. Урьдчилж өгчихвөл.

Г.Тэмүүлэн: Их Хурлын тогтоолын төслийг заалт тус бүрээр хэлэлцэж дууслаа. Өөр саналтай гишүүд алга байна. Ингээд Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд гишүүн ТББХ-ны хуралдаанд танилцуулъя. Ингээд Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

13.33 цаг

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. 2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийе.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Болдын Жавхлан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ганболдын Гийхнараран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Дангаасүрэнгийн Отгонжаргал Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Бүдрагчаагийн Дэнсмаа Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Жаргалсайханы Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Батсуурь Энхжин Сангийн

яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн.

Үндэсний аудитын газраас Дэлэгийн Загджав Монгол Улсын ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Лувсандагвын Мөнхцацрал аудитын менежер, Юрагийн Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер.

ГХЯ-наас Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД, БХЯ-наас Бямбацогт сайд байна уу? Дуудаарай. Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД, бригадын генерал, Бадраагийн Оюунгэрэл мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, дэд хурандаа, ЗХЖШ Балжиннямын Бүрэнтөгс Зэвсэгт хүчин Жанжин штабын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа, ОБЕГ-аас Гомбожавын Ариунбуян дарга, ОБЕГ-ын дарга, хошууч генерал, Төрмандахын Мөнх-Эрдэнэ мөн газрын Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий нягтлан, хошууч, Цөмийн хэргийн энергийн комиссоос Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албан дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль

тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, өнөөдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж байна.

Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 2024 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа. Энэхүү тодотголоор улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг шийдэх, эдийн засгийн өсөлтийг 5-аас 6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлэх хурдтай, зоригтой эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх хөгжлийн төслүүдийг бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна.

Үүнд I дүгээрт бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, өөдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийд төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог, авто замын төсөл, Шинэ Хархорум төсөл, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг ЗГ-ын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжиж буй бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний шалгалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгалаа.

3 дугаарт 30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах хувийн хэвшлийн тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, салбарын санхүү эдийн засгийн тогтвортой суурийг тавихад дэмжлэг үзүүлэх шилжилтийн үеийн зардлыг мөн тусгалаа.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар ЗГ-ын бүтцийн тухай, ЗГ-ын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон, мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийлээ.

5 дугаарт эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрөх орлогыг одоо ба ирээдүйн иргэдэд тэгш хүртээх, хуваарилах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас энэ оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн 3 төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоог бий болгосон. Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2024 оны төсвийн жилд эх үүсвэр төвлөрүүлэх, хуримтлал үүсгэх болон эдгээртэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Үндэсний баялгийн сангийн

2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав дарга танилцуулна. 3 номерын микрофоныг өгье.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Улсын ЗГ шинэчлэн зохион байгуулагдаж, ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шинэ зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн 3 намаас Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4-д заасан төсөвт тодотгол хийх шаардлагыг бий болгосон байна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын ЗГХЭГ-аас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын

тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

ЗГ-аас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зардалд 71 тэрбум төгрөгийн өөрчлөлт орсон байна. Танилцуулж дууслаа. Анхаарал хандуулсан хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Загджав даргад баярлалаа. Манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг бас гишүүдэд тараасан байгаа. Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэсэн мэдээллийг бас тараасан байгаа. Ингээд хууль санаачлагчаас болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батбаатар гишүүнээр тасалъя. Анар гишүүн асуултаа асууя. Микрофон Анар гишүүн, Анар гишүүний микрофоныг өгье, техник.

Ч.Анар: Сайн байцаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр Сангийн сангийн яамнаас асууж байгаа нэг төсвийн ажлын хэсэг дээр асуусан асуулт байгаа. Хиймэл дагуулын өртөг үндэсний аюулгүй байдалд онц чухал ач холбогдолтой гэдгийг ойлгож дэмжиж байгаа. Гэхдээ өртөг өндөр байна. Түүн дээр яг бүрэн гүйцэт хариулт авч чадаагүй. Энэ зардал дотор хөөргөлтийн өртөг орсон юм уу? Яагаад вэ гэхээр энэ өөрөө нэлээн ач холбогдол бүхий том хиймэл дагуул байгаа. Тэгэхээр хөөргөлтийн өртөг гэдэг маань бас нэлээн томоохон зардал байгаа. Тэгэхээр энэ өртөг дараад нь дахиад төсөв дээр одоо хөөргөх боллоо гээд дахиад зардал болж орж ирэх үү 1 дүгээр асуулт.

2 дугаар асуудал аюулгүй байдлын зүгээс энэ хиймэл дагуул маань өөрөө төрийн тэргүүнүүд болон онцгой байдал,

батлан хамгаалахын чиглэлээр илүү түлхүү, гамшигийн болон онцгой байдлын үед хэрэглэгдэнэ. Нууцлалын техник технологийн хяналт шалгалт, кибер аюулгүй байдлын хяналтыг нь тооцож энийг хийх процесс нь Монголд байгаа юм уу гэдэг асуулт байна. Энэ дээр бол нэлээн бас санаа зовж байгаа.

3 дугаарт нь энэ Монгол Улсын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Төсвийн тодотголд дээр маш их олон зүйл хиймэл оюун ухаан, технологи, цахимжилт гэдэг шинэчлэлүүд бол орж ирсэн. Тэр угаасаа байх ёстой зүй зохистой зүйл. Гэхдээ энэ төсөв, төсвийн тодотголууд дээр кибер аюулгүй байдлын талаар энэ өөрөө бүх мэдээлэл маань нээлттэй болоод байгаа. Энэ хаалттай хүрээнд бас хэлэлцэгдэх асуудал байгаа. Яг энэ чиглэлээр маш ноцтой асуудал үүссэн байгаа. Тэгэхээр яг энэ кибер аюулгүй байдлын төсөв маань ерөөсөө хаана суугдсан нь тодорхойгүй байгаад байгаа. Энэ чинь өөрөө бас бид нар хэрвээ цахимжихынхаа хэрээр аюулгүй байдлаа хангах асуудал маань тусгагдахгүй байна гэж хараад байна. Энэ 3 асуултыг харьяалах хүмүүсээс нь тодруулъя.

Г.Тэмүүлэн: Ананд гишүүний асуултад хариулъя. Номер 4, нэр, албан тушаалаа протоколд хэлээрэй.

Л.Сонор: Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сонор. Анар гишүүний асуултад хариулъя. Францын ЗГ-тай хийж байгаа зээлийн хэлэлцээрийн хүрээнд болбол үндэсний хиймэл дагуул угсрах болон г... станцуудыг байгуулах ажил нь болбол тусгагдсан байгаа. Үүний дараагаар болбол хиймэл дагуулыг хөөргөх ажил бас давхар хийгдэнэ. Энэний зардал болбол энэ зээлийн хэлэлцээрт болбол багтаагүй. Одоогийн байдлаар болбол Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай яамнаас АНУ болон Японтой аль нэгийг нь ашиглаад энэ хиймэл дагуулыг хөөргөх асуудлыг болбол ярилцаж байгаа юм байна лээ. Тэгэхээр

одоогийн төсөвт болбол хөөргөх асуудал бол тусаагүй.

Г.Тэмүүлэн: Нэмж тайлбар өгөх хүн байна уу? 3 асуулт асуусан. Техникийн хяналт, аюулгүй байдлын хяналт. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Анар гишүүнээ хар даа би Баатархүү сайдад хэлчихлээ. Орж ирж бас танд мэдээлэл өгөх болов уу гэж бодож байна. Тэр үнэ өртгийн тал дээр болбол бид төсөв талаас нь бол яг хэлж мэдэхгүй байна шүү. Тэр яам гэрээнд, гэрээнд оролцож байгаа яам энийг аягүй сайн мэдэж хариулах хэрэгтэй. Энэ дээр онцгой анхаарал тавих хэрэгтэй. Таны хэлж байгаатай би бол бас ижилхэн байна гэсэн үг байхгүй юу. Ер нь энэ өртөг дээрээ та нар сайн ажиллах ёстой шүү гээд.

Гэрээ амжилттай хийгдээд, тэр нь Их Хурлаар орно, нэн хөнгөлөлттэй зээл авч байгаа учраас Их Хурлаараа ороод тэгээд эцэслэж шийдэгдэнэ гэсэн үг. Тэр үед бас үнэ өртгийн асуудал бас дахиад маш нарийн яригдах болов уу гэж ингэж бодож байна. Ямар ч байсан гэрээ нь хийгдээд, Их Хурлаас соёрхон баталчихвал ЗГ нэн яаралтай Монголын талынхаа төлбөрийг хийх үүрэгтэй юм байна лээ. Тийм учраас одоо ямар ч байсан ингээд хэдүүлээ ингээд төсвийн тодотголоороо энэ мөнгийг нь тавиад халааслаад оръё л гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Тэр зардал дээр болбол бас Их Хурлын гишүүд хөөргөлтийн зардал бол багтсан гэж ойлгоод байгаа. Энэ нь дахиад орж ирэх юм бол тодруулга хийж, тайлбарлахгүй болбол асуудал дараа нь үүсэх магадлалтай юм байна лээ шүү. Тэр хяналтын асуудлыг бол хариулах байх. Харьяалах яам нь байхгүй байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр тэрний тодруулгыг би бичгээр дараа нь тодруулъя. Сангийн сайдаас тэр нөгөө

Кибер аюулгүй байдлын төсөв ер нь төсөвт сууж байгаа юу 25-аас 28 оны төсөвт суух уу? Тэрийгээ тодруулахгүй бол.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төв, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба гэсэн 2 байгууллага Цахим хөгжлийн сайдын харьяанд байгуулагдсан. Ингээд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. 2024 оны батлагдсан төсөв нь 4,3 тэрбум төгрөг. Дээрх бүтцүүд нь нэгэнтээ ЗГ-ын шийдвэр нь гараад байгуулагдсан тул цаашид 2025 оных дээрээ үргэлжлээд төсөв нь тавигдаад ингээд явна. Тодотгол дээр бол оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Г.Тэмүүлэн: Болсон уу? Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид нар төсвийн тодотголоор 450 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах тодотгол хийж байгаа. Үүн дотроо манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 60 тэрбум төгрөгөөр бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулна гэж байгаа. Тэгэхээр төсвийн жил маань 4 сарын дараа дуусах гэж байдаг. Тэгэхээр энэ 4 үлдсэн 4 сарын хугацаанд энэ мөнгөнүүд яг эзэндээ хүрч, тэр гэрээнүүд нь байгуулагдаж, гүйцэтгэл нь амжих уу? Хэрвээ амжихгүй тохиолдолд дараагийн жил рүү шилжүүлэх ч гэдэг юм уу ийм янз бүрийн зохицуулалт байгаа юу? Энэ талаар товч, тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ энэ жил төсвийн боломж гарч байгаа жил дээр бид төсвөө тавиад авчхаж байгаа юм. Тэгээд аль болох энэ сайд нар маань төсвөө гүйцэд гүйцэтгэлийг нь сайн гаргах хэрэгтэй, чармайж ажиллана. Бүсчилсэн хөгжлийн хувьд болбол бид бүгдэд нь л шинэ асуудлууд байгаа. Энэ дээр бүс бүсээрээ гишүүд энэ дээр их сайн хамтарч их сайн ажиллах хэрэгтэй. Хэрвээ амжихгүй болбол бид зохицуулалт хийж, дараагийн жил рүү үргэлжлүүлэх энийг нь болбол ЗГ дээрээс бие даагаад хийгээд явчихна.

Өөрөөр хэлбэл энэ жилдээ ингээд 60 тэрбум тавигдчихаж байгаа учраас хойтонгийнх дээр бас энэ хэмжээгээр бас бид нар ачааллаа авчхаж байгаа юм. Хойтон бас тусдаа шаардлагатай гэвэл мөнгө бас тавигдаад л ингээд үргэлжлээд явна гэсэн үг. Тийм.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн болсон уу? Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Энэ төсвийн хүрээний төсвийн тодотгол хийгдээд явж байна. Тэгээд их олон 100 тэрбум төгрөг нөгөө улс төрийн шийдвэрээс болоод урьд нь ЗГ өөрөө төсөөлөөгүй байсан шинэ төсөл хөтөлбөрүүдийг гаргаж оруулахаас өөр замгүй болчихлоо л доо. 3 нам нийлээд засаг барихаар бусад намууддаа нөгөө санхүү, эрх мэдэл, төсөл хөтөлбөрийг нь санхүүжүүлэх асуудлууд үүсгээд. Тэр нь тэгээд одоогийн байдлаар тийм анзаараад байхад нэг гарчгийн шинж чанартай, тодорхой төсөөлөл багатай зүйлүүд дээр ТЭЗҮ болон бусад зүйл дээр нэлээн олон тооны мөнгө тавьчихлаа. Энэ нь тэгээд хэр зөв юм бэ гээд. Буруутгаад байх хэцүү, зөвтгөх арга байхгүй ийм л төсвийн тодотгол болоод байна. Энэ тухай асууя.

2-т нь нөгөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэж байгаа учраас яах вэ манай намын мөрийн хөтөлбөрт байсан. Энэ тодотгол дээр

бол орж ирээгүй юм байна лээ. Бодвол 25 оны төсөв дээр одоо бараг боогдоод 9 сарын 1-нд Их Хуралд өргөн барих байх тийм ээ. Тэгэхээр тагнуул, үндэсний аюулгүй байдал энэ чиглэлийн байгууллагуудыг чадавхжуулах хөрөнгө санхүүжилт, тэр зүйлд нь одоо байгаа түвшнийг нь сайжруулах, хамаарал багатай ажиллах эрх зүйн хувьд ийм зүйлийг оруулна гээд бид нарын мөрийн хөтөлбөрт бол байсан юм. Тэгэхээр энэ удаа тодотголд орж ирээгүй учраас асуух зүйл байхгүй болчихоод байна. Бодвол өөрсдөө саналгүй байсан юм байлгүй. Ийм зүйл байгаа юу? Цаашид төсөвтөө л орж таарах байлгүй эд.

Ажилгүйдэл, ядуурлын асуудлаар нэг ядуурлын эсрэг л нэг тийм цаг хугацаа, төлөвлөлт, орон зай, гүйцэтгэл, төсөв, хариуцах эзэнтэй л байхгүй бол Эдийн засаг, хөгжлийн сайдын хариулж байгаагаар бол юу л байгаад байна лээ л дээ. ЗГ кабинетаараа хариуцна, би ганцаараа хариуцахгүй, битгий хоч өгөөд бай л гээд байна лээ л дээ. Уг нь бол хоч биш ажил хийх эрх мэдэл, тэр ажил, энэ төсөв, мөрийн хөтөлбөр, одоо үйл ажиллагааны хөтөлбөр бид нарын баталж байгаа бүх юм бол ерөөсөө л Монголчууд улс орондоо ядууралгүй, аз жаргалтай, сайхан амьдруулах тухай л юм байгаа шүү дээ. Туурга тусгаар улс орондоо. Бид нарын баталж байгаа бүх бичиг баримт бүгд тэр лүү л явж байгаа. Тэгэхээр нөгөө тэрийгээ нэг жоохон Засаг дээрээ сайдынхаа тэр яг хариуцлагын юу эд нар дээр нь тавиад тэр чиглэл рүү ажиллах, анхаарах боломж байна уу?

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь нэг санал л хэлчих шиг боллоо доо Батбаатар гишүүнээ. 2025 оны төсвийн яг бол төсөвтэй холбоотой асуудлыг бол төсөв өргөн барихаар ярих нь зөв байх. Энэ удаагийн тодотгол болбол хамтарсан ЗГ

гэрээ байгуулагдсан, мөрийн хөтөлбөрөө өргөн барьсантай холбогдуулж энэ жил эхлэх гол тодорхой бүтээн байгуулалтын ажлуудад зориулсан л ийм тодотгол байгаа. Бусад таны асуугдсан суурь том асуудлуудыг 25 оны бүтэн жилийн төсөв өргөн барих үед ярилцъя. Салбар салбараараа тодорхой бодлогууд орж ирэлгүй яах вэ.

Хөтөлбөр нэгэнт өргөн баригдсан, гэрээ хийгдсэн. Хөтөлбөр дээр тусгагдсан энэ бүтээн байгуулалтын ажлууд зөв, чухал ийм зүйлүүд учраас тодотголоо хийж эхлүүлэе гээд ер нь зөв гэж үзээд л оруулж ирсэн юм байгаа юм. Та зөв үү гэж асуусан, тэгээд зөв л гэхээс.

Г.Тэмүүлэн: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ төсвийн тодотгол дээр бол энэ ЗГ-ын тэргүүлэх энэ төслүүдийг урагшлуулах энэ чиглэлийн зорилтууд тусаж байгаа нь болбол дандаа цаанаа ажлын байрыг л нэмэгдүүлэхэд гол зорилтоо чиглүүлж байгаа. Жишээ нь энэ төслүүд урагшилснаар болбол дандаа ажлын байрыг нэмэгдүүлэх ийм хэмжүүрүүдийг болбол тавьж өгсөн.

Жишээ нь түрүүн Анар гишүүний асуулт бас асуугдсан байна. Энэ үндэсний хиймэл дагуултай холбоотой асуулт. Үндэсний хиймэл дагуулыг 36 мянган км-т хөөргөснөөр болбол үүний цаана болбол ажлын байрыг бас нэмэгдүүлэх зорилгыг мөн л агуулж байгаа. Мөн түрүүн нөгөө зардал өндөр байна гэдэг дээр болбол тодорхой хариулт хэлэхэд нам орбитын хиймэл дагуул болбол 500-аас 1500км-т л хөөргөдөг. Тэгээд технологи болбол өөрөө 6, 7 сард ч юм уу шинэчлэгдээд байдаг. Зүгээр гео орбитод болбол.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд минутыг нэмж өгье. Биш ээ Учрал сайд.

Н.Учрал: Үндэсний энэ хиймэл дагуулыг хөөргөж байгаа энэ гео орбитод болбол технологи нь байнга шинэчлэгдээд байхаасаа илүүтэйгээр энэ чинь нөгөө дэлхийн бараг талыг бүрхэж байгаа, дээрээс нь 15 жил тэнд байрших ийм зорилготой учраас бараг 1,5 тонн хэмжээтэй ийм даац өндөртэй хиймэл дагуул учраас бол зардлын хувьд бол мэдээж өндөр байдаг. Үүнээсээ улбаалаад бол мэдээж энэ чинь газрын станцууд байгуулагдана гэхээр аюулгүй байдлаа хамгаалах, харилцаа холбооны салбарт бие даасан байдлаа бий болгох, үүний цаана өөрөө энэ сансрын шинжлэх ухаан хөгжих маш өндөр олон ач холбогдолтой. Тэгэхээр мэдээж би Анар гишүүнд онол ярина гэж юу байх вэ. Гэхдээ энэ үндэсний хиймэл дагуул болбол өөрөө яг эдийн засгийн хувьд ч гэсэн үр ашигтай төсөл. 15 жилийн хугацаанд болбол зардлаа болбол нөхнө гэж тооцоо гарсан.

Г.Тэмүүлэн: Яах вэ түрүүн сайд байгаагүй учраас тэгээд Анар гишүүн бас нэмээд тодруулчихъя. Сайд сая хоцорч орж ирлээ. Мэргэжлийн сайд нь бас энэ дээр тодорхой тайлбар хариулт өгөөгүй байгаа. Батбаатар гишүүн бол нэмж асуух асуулт байхгүй тийм ээ? Анар гишүүн.

Ч.Анар: Учрал сайд яг энэ асуудлаа хариуцаж байсан сайд нь орж ирсэнд баяртай байна. Тэгэхээр та ач холбогдлын талаар ярьж байна. Түүн дээр бол би бүр мянган хувь санал нэг байгаа. Ялангуяа өнөөгийн цаг үеийн нөхцөл байдал онцгой байдал. Энэ дээр бол Монгол Улсад илүү арилжааны гэхээсээ илүү үндэсний аюулгүй байдал зайлиггүй шаардлагатай. Тэр бол үнэхээр санал нийлж байгаа.

Миний асуусан асуулт нь онолын хувьд болбол би бас маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр асуусан асуулт нь ийм байсан юм. Энэ өөрөө үндэсний аюулгүй байдал, төрийн тэргүүн, хил хамгаалах, батлан хамгаалах, тусгай чиг үүргийн байгууллагуудын харилцаа холбоог шийдэх

үүрэгтэй. Гэхдээ энэний хяналтыг нь хаана, ямар байгууллага хийж байгаа юм бэ? Энэ дээрээ анхаараасай. Эргээгээд энэ маань өөрөө аюулгүй байдлынхаа асуудлыг шийдэх биш эсрэгээрээ энэ мэдээллээ алдах асуудал болох вий гэдэг энийг яаж шийдэж байгаа юм бэ гэдэг асуулт байсан юм.

Хоёрдугаарх нь Сангийн яамнаас хариулчихлаа л даа. Хөөргөлтийн зардал орсон юм уу гээд. Энэ өөрөө маш том хиймэл дагуул учраас хөөргөлтийн зардал маань бас овоо том төсөв болно. Тэгэхээр яах вэ Сангийн яамнаас хариултаа авчихлаа.

Г.Тэмүүлэн: Учрал сайд.

Н.Учрал: Мэдээж энэ болбол нөгөө нам орбитод биш гео орбитод гаргах гэж байгаа хиймэл дагуул учраас заавал газрын станц байгуулагдаж байж л бид нар үүнийгээ хяналтаа тавина. Тэгэхээр 4 байршлыг тодорхойлсон. Өмнө нь болбол 8, 9 жилийн өмнө байна уу ТЭЗҮ-ийг нь боловсруулж байсан юм байна лээ. Тэгэхээр яах вэ ТЭЗҮ-ийг нь боловсруулсан байсныг болбол бид нар болбол сая шинэчилсэн. Зүгээр тэр Thales Alenia групп дээр болбол би бас өөрөө очиж болбол танилцаж, хэд хэдэн удаагийн болбол уулзалтуудыг болбол хийсэн. Тэгээд дараа нь Аюулгүйн Зөвлөл дээр энэ асуудлаар болбол танилцуулга оруулаад, ингээд бол Аюулгүйн Зөвлөлийн зөвлөмж болбол гарсан.

Тэгэхээр яг Анар гишүүний хэлж байгаа шиг энэ болбол зөвхөн нэг салбарын гэхээсээ илүү олон салбарт хамааралтай асуудал. Тэгээд яах вэ газрын станц байгуулагдах учраас болбол хяналтаа тавиад явна л гэсэн ийм л тооцоололтой байгаа.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж дууслаа. Миний хувьд бас нэг хэд хэдэн асуулт асуухаар байгаа. Асуултаа асууя. Тэгэхээр төсөв санхүүгийн аюулгүй байдал бол өөрөө амин чухал асуудал

байгаа. Энэ удаагийн төсвийн тодотголоор бас төсвийн тэлэлт бол нэлээн нэмэгдэхээр байна. Төсвийн зардал нэмэгдэхээр байгаад байгаа. Гишүүд ч бас энэ асуудлыг хөндөж ярьж байна. Төсвийн зарлага нэмэгдэх хэмжээгээр эдийн засаг дахь төрийн оролцоо ч нэмэгдээд, хувийн хэвшлийн ч орон зай хумигдаад, эргээд макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдана гэсэн асуудлыг бол ярьж байгаа.

Тэгэхээр бид нар төсөв санхүүгийн аюулгүй байдлын асуудал бол өөрөө хамгийн чухал нэг асуудал байна. Болгоомжилж байгаа зүйл байна. Бид нарт бас өмнөх алдаа оноонууд байна. 2012-оос 16 оны хувьд тэр үед байгуулсан ЗГ-ын хувьд та бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа. ЗГ-ын баталгаатай бондууд гаргасан. Эргээд бондын хугацаа дууссан, төсвийн алдагдал нэмэгдсэн, гадаад валютын нөөц шавхагдсан. 17 онд ЗГ-ын бондыг төлж чадахгүй хэмжээнд болбол очсон байгаа. Бид нар бүсээ чангалсан. 16 онд, 17 онд 2 жилийн хугацаанд.

Тэгэхээр ЗГ-ын өр нэмэгдсэн ч гэдэг юм уу, эргээд юу гэдэг юм хүндэрсэн нөхцөлд л бид нар ОУВС дээр очиж л Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт орж, бага хүүтэй санхүүжилтийн эх үүсвэр авч, эдийн засаг санхүүгийн хүндрэлтэй байдлыг бол давж гарч байсан. Би тэгэхээр ийм байдал нүүрлэх вий дээ гэдэг болгоомжлол бол байгаа 1 дүгээрт.

2 дугаарт энэ оны төсвийн тодотголоор төсвийн зарлага, орлого батлагдсанаасаа хэдэн их наядаар нэмэгдэхээр тооцогдож байгаа юм бэ 2 дугаарт.

3-д төсвийн зарлага ирэх 3 жилийн хугацаанд хэдэн их наядаар өсөх юм бэ? Хэдэн их наядаар ирэх 3 жилийн хугацаанд 25, 26, 27. Тэгэхээр гол анхаарч юу гэдэг юм бид нар санаа зовж байгаа зүйл л энэ төсөв санхүүгийн аюулгүй байдал талаасаа бид нар төсөвт нүүрлэх

аливаа эрсдэлийг болбол бас дутуу тооцож болохгүй, алдаатай шийдвэр гаргаж болохгүй. Үүнээс болбол сэргийлэх ёстой. Анхнаасаа болбол ийм байдалд орохгүй байх болбол энэ шийдвэрийг болбол гаргах ёстой байгаад байгаа юм. Удаа дараа л бид нарын ярьдаг гол зүйл бол энэ өрийн эзлэх хувийг шат дараатай бууруулах, төсвийн сахилга батыг хангах, төсвийн засаглалын институтийн реформыг хийх ёстой л гэдэг асуудал. Төсвийн хамгийн том эрсдэлийн асуудал бол номер нэг нь гадаад зээлийн асуудлууд байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь та хэд ирэх энэ он жилүүдэд хийгдэх хөрөнгө оруулалтуудынхаа санхүүжилтүүдийг яг ямар хэлбэрээр хийе гэж бодож байгаа юм бэ? Улсын төсөвт ачаалал өгөхгүйгээр шийдэх боломж болоцоо байгаа юм уу? Яг энэ байдлаараа төсөв дээр оруулж ирсэн юм уу?

Улсын Их Хурлаас бол ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөөтэй холбогдуулж, өрийн удирдлагатай холбоотойгоор байнгын мониторинг хийх асуудлыг бол бас гаргаж ирж тавьж байгаа. Гадаад өрийн түвшин өөрөө өндөр байгаа. Эргэн төлөлтийн асуудал бол хамгийн их санаа зовж байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар энэ өр эргэн төлөлтийн хуваарьт анхааралтай мониторинг хийж чадаж байна уу? Бодлогын хүрээндээ болбол бид нар нийт гадаад өрнийхөө удирдлагын стратегийг боловсруулж бас ажиллах ёстой байгаа. Энэ дээр ер нь яг ямар байр суурьтай байгаа юм бэ? Аудит бас энэ дээр бас тодорхой дүгнэлт хийсэн үү, санал, дүгнэлт гаргасан уу? Өрийн асуудлууд дээр та хэд ямар байр суурьтай байгаа юм бэ? Төсөв дээр ирэх ачааллыг нь бас юу гэж тооцож байгаа юм? Асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Байнгын хороон даргын асуултад хариулъя. Тодотголоор төсөв хэдээр нэмэгдэх вэ гэж байна. Та бүхэнд хүргүүлсэн төсвийн тодотгол, хавсаргасан материалууд дотор энэ талаар маш тодорхой байгаа. Өөрөөр

хэлбэл 3,1 их наяд төгрөгийн орлого зарлага нь тэнцсэн ийм тодотголыг өргөн барьсан байгаа.

Товчхондоо бүлэглэж, задалж хэлэх юм болбол нийслэл Улаанбаатар хот дээр 1,2 их наяд, гадаад зээлийн ашиглалт 984, томоохон төслүүд дээр 484, бусад нь бол урсгал зардал байгаа 3,1 их наяд гэсэн үг. Ирэх 3 жилд зардал хэдээр нэмэгдэх вэ гэж байна. Тэгэхээр Монгол Улсын ДНБ тэлэхийн хэрээр төрөөс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ жил ирэх тусам тэлж байгаа, тэлж байгаа юм. Тийм учраас энийг санхүүжүүлэх нь төсвийн үндсэн үүрэг байдаг. Хүн ам нэмэгдэж байна. Мөн өөр чиглэл чиглэлийн салбар салбарын хуулиуд дээр маш олон өөрчлөлтүүд орсон байдаг. Энэ бол гэнэт сүүлийн жилүүдэд орж байгаа зүйл биш. Сүүлийн 34 жил ингээд байнга шинэчлэхэд ороод явж байдаг ийм л заалтууд байгаа.

Жишээ нь хүүхдийн мөнгө байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэл дээр өнгөрсөн жил гэхэд л 7 жил байсныг 5 жил болгочихсон. Энэтэй холбогдуулж зардал нэмэгдэж байна. ЭМД-ын сангийн зардал жил болгон нэмэгдэж байна. Боловсролын салбарын зардал жил болгон нэмэгдэж байна. Эрүүл мэндийн салбарын зардал жил болгон нэмэгдэж байна гээд гэх мэтчилэн шалтгаануудаар суурь төсөв маань бол жил ирэх тусам нэмэгдэж байгаа.

Тэгэхээр цаашидаа бидний хувьд 2 сонголт байгаа юм. Бүтээн байгуулалтын ажлуудыг ирэх 4 жил энэ ЗГ-ын өнгөн дээр нэлээн зоригтойнхон ирэх жилийн ирэх урт, дунд хугацааны хөгжлийн суурийг нь тавьж чадах, зах зээлийн горимд нь шилжүүлж чадах энэ өөрчлөлтүүдийг хийе гэж байгаа юм. Тэгэхийн тулд бид ялангуяа хөрөнгө оруулалтын чиглэл дээрээ нэлээн анхаарах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол одоо байгаа зардлын хязгаар дотроо энэ нэмэгдэх хязгаар дотор маань голцуу бараг 8-аас, юу 80-аас 90 хувь нь нийгмийн

суурь зардлуудын өсөлт болчихоод байгаа юм. Тэгэхээр ерөөсөө 10 хүрэхгүй хувьд нь л бид нар хөрөнгө оруулалтаа шингээх ийм маш хязгаарлагдмал ийм боломж байна.

Тийм учраас одоо оруулж ирж байгаа бидний санал болбол урсгал зардлаа буюу суурь тэнцлээ 30 хувь дээрээ бариад, гадаад зээлийн ашиглалтаа 6.1.3 буюу маш олон жил явж ирж бидэнд гол суурь хязгаар болсон тусгай шаардлага болсон өрийн хязгаараа 60 дээрээ бариад, ингээд нэрлэсэн үнээрээ тооцоод ингээд явъя гэдэг ийм санал оруулж ирж байгаа юм. Тийм учраас өр болбол энэ 60 хувиасаа хэтрэхгүй тусгай шаардлага маань цааш нь хэвээр нь үргэлжлүүлж гэсэн ийм саналтай байгаа юм.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдын микрофоныг өгье. Хариултыг дуусгая.

Б.Жавхлан: Томоохон хөрөнгө оруулалтуудыг бол аль болох бид төсөв дээрээс санхүүжилт хийхгүйгээр өөрөөр хэлбэл гадаад шууд хөрөнгө оруулалт эсвэл төр хувийн хэвшлийн түншилэл буюу гадаад эх үүсвэрээр өөрөөр хэлбэл мөнгөө барьж орж ирээд энэ бүтээн байгуулалтуудыг хийх энэ хэлбэр лүү нь л явуулна. Тэгэхгүй бол бид эдгээр төслүүдээс нэгийг нь ч төсвийн санхүүжилтээр дийлэхгүй бараг 100 жил барих байх. Тийм учраас ийм бодлоготой байгаа шүү тийм. Тийм учраас зүгээр төсөв дээрээс бэлтгэл ажлыг нь хангах энэ ажлуудаа л санхүүжүүлнэ. Бидний оруулж ирсэн төслүүд нь бол дандаа зураг төсөв, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээг санхүүжүүлэх ийм нөгөө суурь бэлтгэлээ хангах санхүүжилтүүд нь байгаа гэж.

Гадаад өрийн стратегийг бид 2018 оноос хойш хууль батлагдсанаас хойш 3, 3 жилээр стратегиа Улсын Их Хурлаар батлуулдаг. Өөрөөр хэлбэл гадаад өр дээр баримтлах гэрийн даалгаврыг Улсын Их Хурлаас чиглүүлдэг гэсэн үг. Энэ стратегиа бид 3, 3 жилээр маш

амжилттай сайн барьж ирсний үр дүнд өнөөдөр өрийн хязгаар.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдын микрофоныг өгье. Хариултыг дуусгая.

Б.Жавхлан: Баярлалаа сунгаж өгч байгаад. Энийгээ их сайтар биелүүлж ирсний үр дүнд өрийн хязгаар маань 60, гүйцэтгэл маань 39 хувьтай буюу одоо бид 20 хувийн сул орон зайтай ингээж явж ирлээ. Тийм учраас энэ стратегиа бид маш сайн бариад явж байгаа. Одоо баримталж байгаа стратеги маань хойтон 2025 онд дуусна, ингээд дараагийн 3 жилийнхээ стратегийг ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн барина. Баярлалаа.

Ер нь болбол Байнгын хороон дарга Тэмүүлэнгийн ярьж байгаа зарчмуудтай бол санал нийлж байна. Бид бол аль болох л бүх тусгай шаардлага болон төсвийн хэрэгслүүдийг маш чанга барьж баримталж ингээж явж ирсэн. Энийгээ бол цаашидаа ч бас үргэлжлүүлээд явна. Гэхдээ мөн ирэх 4 жил энэ ард түмний сонголт, хамтарсан ЗГ гэрээ хөтөлбөрүүдээ бас биелүүлэхийн төлөө бид энийг бас бид энэ удаа хойшлуулж, цаг алдаж болохгүй байгаа гэдгийг та бас ойлгоорой. Тийм.

Г.Тэмүүлэн: 1 зүйл дутуу орхисон сая. Энэ жилийнх бол 3,1 их наядоор өсөх юм байна. Ирэх 3 жилийн хугацаанд яг хэдэн их наядоор өсөх вэ? Дээрээс нь ирж байгаа энэ зардлуудыг би бол улс төрийн зардлууд гэж харах гээд байгаа юм. Гол анхаарч санаа зовоод байгаа зүйл нь эдийн засаг нь дийлэх юм уу? Тэгэхээр энэ дээр та жишээ нь одоо яг улсын төсөв дээр ачаалал өгөхгүйгээр бол бид нар шийднэ. Төр, хувийн хэвшлийн түншилэл болоод гадаадын хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалт шууд хөрөнгө оруулалт байдлаар бол шийднэ л гэдэг сая тайлбарыг хэлж байна л даа. Тэгэхээр яг энэ дээр бас баталгаа байна уу, баталгаа байна уу?

Мөн дээрээс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт байлаа ч гэсэн ЗГ бас нэг талдаа баталгаа гаргах асуудал үүснэ шүү дээ. 12-оос 16 онд бид нар бондын асуудлууд дээр ч гэсэн бонд гаргаж байхад ЗГ баталгаа гаргасан. Эргээд л нэг талдаа гадаадын хөрөнгө оруулалт орж ирнэ гэвэл баталгаагүй хөрөнгө оруулалт их наядаар нь орж ирнэ гэсэн зүйл байхгүй. Эргээд ЗГ тэрийг төлөх үүрэг хүлээнэ. Төлбөрийн тэнцэл дийлэх үү? Болгоомжилж байгаа зүйл л ерөөсөө эцсийн дүндээ л бид нар хэт их юу гэдэг юм хөрөнгө оруулалт гээд байдаг, маргааш нь эргээгээд үр өгөөжөө өгөхгүй хөрөнгө оруулалтууд дээр, томоохон юу гэдэг юм бүтээн байгуулалтууд дээр хийдэг. 10, 20 жилийн дараа нөгөөдөх нь үр өгөөж нь орж ирдэг. 5 жилийн дараа нөгөө өрнийх нь дарамт нь төсөв дээр ороод ирдэг ийм асуудлууд үүсэх вий л гэдэг болгоомжлол байгаад байгаа юм. Ингэх юм болбол төлбөрийн тэнцэл дийлэхгүй. Валютын хани дээр дарамт үзүүлнэ, хани суларвал яах вэ л гэдэг асуудал байгаад байгаа юм. Ингэвэл энэ болбол цэвэр шууд ард иргэдийн амьдрал дээр л буух л асуудал байгаа. Бид нар энэнээс л болгоомжлох ёстой. Төсөв санхүүгийн аюулгүй байдал гэдэг асуудал. Энэ дээр та нэг тайлбар байр сууриа хэлээч л гэх гэсэн юм. Саяын нийт 3 жилээр.

Б.Жавхлан: Ойлголоо. Тэр 3 жилээр одоо бид тооцож байгаа шүү дээ. Одоо бид нар 25 оны төсвөө өргөн барихдаа ирэх жилийн хүрээний мэдэгдэл, дараагийн 2 жилийнх нь төсөөллүүдийг танилцуулна. Яг одоо ингээд тоо хэлэхэд болбол арай эрт байна. Би бол зарчмаа болбол хязгаараа бол түрүүн хэлсэн. Тийм 30 хувь дээр ингээд бариад явах ёстой гэдгээ. Тийм санал оруулж ирж байна.

Төсвөөс хийхгүй байх баталгаа нь өөрөө энэ төсвийн маань хүчин чадал юм. Нэг төсөл нь л гэхэд хамгийн багадаа 2,8 их наяд жишээ нь. Тэгэхэд бид 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтын, төсвийн өөрийн маань боломж нь 700 тэрбум байх

жишээтэй. Одоо бүх сургууль, цэцэрлэг төсвөөс бид нар хийж чаддаг бүх хөрөнгө оруулалтууд маань шинээр шүү нийлээд 700 их наядын л бид нар орон зай байгаа юм. Тэгэхээр бүх сургууль, цэцэрлэг бүх юмаа хойшлуулж байгаад энэ чинь бараг 5 жил зөвхөн нэг төслийг нь барьж авна гэхээр төсөв дээр үндсэндээ энийг бид нар авах ямар ч боломж байхгүй. Зөвхөн бэлтгэл ажлыг нь хангаад, тэгээд бусдыг нь болбол гадаад шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвилийн түншилэл.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдын микрофоныг өгье. Бүтэн 3 минутаар өгчхөөч.

Б.Жавхлан: Баталгаа гаргах уу, зээл авах уу гэж байна. Одоо ч гэсэн баталгаа гаргах, зээл авах асуудал нь бол 60 хувийнхаа хязгаар дотор нээлттэй, энэ орон зайг нь бид нар бүр ингээд сахилга баттай явж ирээд, тэлээд тавьчихсан байгаа. Бүр 20 хувь гээд. 20 хувь маань одоогийн ДНБ-ээр бол 15 их наяд орчим. Гэхдээ энийг Их Хурал шийднэ. Баталгаа ч бай, зээл нэмж авах байсан ч гэсэн нэг долларын зээл ч байсан, нэг долларын баталгаа ч байсан Их Хурал дээр энийг шийдээд явдаг ийм зарчимтай байгаа. Тэгэхээр одоогоор болбол бид нар шинээр баталгаа гаргах, шинээр өр нэмэх, ойрын жилд энэ жилийн хагаст бол Эрдэнэбүрэнгээс өөр тийм нэмж зээл авах гадаад өрийн асуудал бол байхгүй байгаа.

Төлбөрийн тэнцлийн хувьд болбол аль ч бүтээн байгуулалтын үед, аль ч эдийн засгийн өсөлтийн үед төлбөрийн тэнцэл дээр сөрөг дарамт ирдэг. Яагаад гэвэл манай улс маань өөрөө импортлогч орон биш. Ялангуяа бүтээн байгуулалтад хэрэглэгддэг барилгын материалын үндсэндээ бараг 60, 70 хувийг нь гаднаас авдаг учраас бас мөн худалдан авалтын чадвар өндөр болж ирдэг эдийн засгийн өсөлтийн үед. Ийм үед хэрэглээгээ ер нь гаднаас авдаг учраас төлбөрийн тэнцэл дээр байнга сөрөг дарамт ирдэг. Энийг

зөөлрүүлэх дээр бол Төв банктэй бид нар хамтарч ажиллах ёстой. Энэ дээр бол бас мөнгөний бодлого, валютын бодлого, тэгээд инфляц гээд бас мөнгөний бодлогын цэвэр асуудал байдаг учраас тэнд бас ажил хийгдэнэ. Тэрийгээ 2025 оны удахгүй орж ирэх мөнгөний бодлогынхоо төсөл дээр бас хамтарч яригдах байх гэж ингэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Төсвийн зарлага би зүгээр ирэх жилийн хугацаанд гээд энэ та бүхнээс гаргасан танилцуулсан танилцуулга материал дээр байгаа байх. Ирэх жил, ирэх 3 жилийн хугацаанд энэ жилийнх бол 3,1, ирэх 3 жилийн хугацаанд бол нийтдээ 11,6 их наядын зарлага болбол өсөх ийм тооцоолол байна гэсэн дүнг харсан. Тэгэхээр болбол би энэ хэмжээгээр л өсөх гээд байгаа юм байна л гэдэг асуудлыг л бас та хэдээр бас хэлүүлэх гээд байсан юм. Тэгэхээр та энэ дээр бас нэг тодорхой тоо бас нэг хэлээч гэх гээд байгаа юм. Бид нар явж эцсийн дүндээ л улсын төсөв эргээгээд нэг энэ үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж л гаргах л, батлах л энэ үндсэн онцгой эрх бол Улсын Их Хурал дээр л байгаад байгаа юм. Энэтэй холбогдуулж нэг асууж байгаа асуудал байгаа юм нэгдүгээрх нь.

Яах вэ болгоомжлол бол эргээд төсвийн орлого, зарлага бол нэмэгдэж болно. Эдийн засгийн нөхцөл байдал өөрөө хүндэрвэл яах бол гэдэг болгоомжлол байгаа. Хамгийн муу хувилбараар бид нар тооцож л ерөнхийдөө тооцоолол болбол хийх л ёстой байгаа. Тэгээд энэ дээр та хэд бол тооцсон, баталгаажуулсан зүйлүүд байна уу? Зах зээл муудвал яах вэ, нүүрсний үнэ унавал яах вэ гэдэг энэ болгоомжлолууд байна. Энэ дээр нэг хариулаач. Дараа нь Загджав дарга түрүүний аудит ер нь юу гэж үзэж байгаа юм бэ өртэй холбоотой, өрийн дарамттай холбоотой асуудлууд дээр, эргэн төлөлт хуваарь дээр. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Нэлээн задалж ярих шаардлагатай болж байх шиг байна. Бид

одоо судалгааны түвшинд хийгдэж байгаа зүйлүүдийг тоонуудыг бас одоо ингэж ил зарлах нь болбол бас нэг тийм сайн зүйл биш. 25 оны би дахиад хэлье 25 оны төсөв ерөөсөө удахгүй 9 сарын 1-нд би шинэ цаглаврын дагуу бид нар өргөн барина. Тэр үед энэ тоонуудыг илүү их нарийн ярих боломжтой болж ирнэ. Тэгэхдээ 10 их наяд болбол бүүр наад зах нь шүү, 12 их наядаас ч илүү нэмэгдэнэ 1 дүгээрт.

2 дугаарт бид нарын оруулж ирж байгаа энэ шинэчилсэн горим дэглэм маань яг өөрийн чинь ярьж байгаа тэр эрсдэлийг 100 хувь хааж байгаа байхгүй юу. Уг нь ингээд нэг сайн ингээд тухтай суугаад харах юм болбол. Өөрөөр хэлбэл тогтмол зардлуудаа бид тогтмол байнгын шинжтэй орлогоороо бүрэн нөхөөд, бүр 2 хувийн ашигтай байхаар ингэж бүр хуульчилж оруулж ирж байгаа. Тэр 2 хувиараа ингэж тухайн жилдээ хөндөхгүйгээр хадгалж байгаад тусад нь шууд тухайн жилдээ гадаад өрнийхөө үндсэн өрнүүдийг төлөөд явах ийм маш том шинэ зохицуулалт орж ирж байгаа.

2 хувь гэдэг бол бага тоо биш ДНБ-ий. Жишээ нь ирэх жил ДНБ бараг 95 их наяд хүрнэ. Үүний 2 хувь гэдэг чинь 1,9 их наяд, ойтон жилийн гадаад өр төлбөр маань 800-гаад тэрбум байгаа буюу энийгээ бүр 2 давсан ийм дүнгээр гадаад өрнийхөө төлбөрүүдийг урьдчилж төлөөд явах ийм боломжууд гарна. ДНБ нэмэгдэх тутам энэ дүн нэмэгдээд явна. Тэр дүнгүүд маань ямар ч байсан бид нарын тооцоогоор 30 он хүртэлх жил бүрийн гадаад өрийн төлбөрийг бол хангалттай төлөөд, дээрээс нь бүр урьдчилж төлөх ийм боломжууд нэмэгдэж байгаа юм.

Тийм учраас өөрөөр хэлбэл таны санаа зовж байгаа, миний ч санаа зовж байгаа манай гол түүхий эдүүдийн савлагаанаас шууд хамааралтай төсвийн орлогоосоо бид бага 2 хувийн бага ийм байнгын зардалтай явна шүү гэдгийг

хуульчилчхаж байгаа учраас энэ дээр бол ямар ч эрсдэл гарахгүй гэсэн үг.

Дээрээс нь гадаад зээлийн ашиглалт нэмэгдэх хэрээр энэ өр маань өөрөө нөгөө эх үүсвэртэй зардал байхгүй юу, эх үүсвэртэй зардал. Энийгээ бид жил болгон ингээд 2 хувиар төлөөд явахад бид 30 он хүртэл болбол гадаад өр талдаа бид ямар ч эрсдэл гарахгүй. Харин ч бид энэ дүн бол багасаад явна. Харин өрийн хязгаар бол 60 гэдэг дотроо бол хангалттай бариад явна. Ер нь 45-аас 50-ийн хооронд бол хангалттай бариад явах ийм бид нар тооцоо судалгааны үндсэн дээр өөрчлөлтийг өргөн барьж байгаа юм.

Г.Тэмүүлэн: 3 номер Загджав дарга.

Д.Загджав: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэмүүлэн даргын асуултад хариулъя. ЗГ-ын санхүү төсвийн хүрээнд хийж буй томоохон өөрчлөлтийн нэг нь суурь тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, түүнээс дээш хувиар ашигтай байлгаж, түүнээсээ гадаад зээлийн өрийг төлдөг байхаар зохицуулж байгаа нь гадаад өрийн дарамтыг тодорхой түвшинд хязгаарлах арга хэмжээ гэж харж байгаа юм.

ЗГ-ын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны хагас жилийн байдлаар 30 их наяд 359,6 тэрбум төгрөг, 24 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 35 их наяд 392,7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 44,7 хувьд хүрэх ийм төлөвтэй байгаа юм. Цаашид бол энэ дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, төсвийн тусгай шаардлагыг дунд, урт хугацааны хугацаанд тогтвортой байдлыг хадгалж, дагаж мөрдөх, төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөлийг анхаарах, шинэчилсэн төсвийн тусгай шаардлагын нөлөөгөөр хөрөнгийн зардал дунд хугацаанд нэмэгдсээр байгаа нь эдгээр хөрөнгө оруулалтуудтай холбоотой урсгал зардлыг өсгөх нөлөөтэй байна. Иймд

нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангах үүднээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөн, хэрэгжилтэд нь тухайлан хяналт тавьж ажиллах шаардлагатай байгаа.

Хөгжлийн төслүүдийг нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол судалгаанд үндэслэн сонгон шалгаруулж, Улсын Их Хурлын батлуулах. Эдгээр хөгжлийн төслүүдийг эдийн засагт хэт ачаалал үүсгэх, импортыг эрс нэмэгдүүлэх эрсдэлийг тооцож, төсөл санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх замаар өндөр инфляц, өрхийн бодит орлого, амьжиргаанд үзүүлэх эерэг нөлөөллийг сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай байгаа юм.

Тэгээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасан төсвийн төсөл нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7-д заасны дагуу Монгол Улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн гэж дүгнэж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Загджав даргад баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 2024 онд Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 онд төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх болон зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Нэрсийг авъя. Энхбаяр гишүүнээр, Батбаатар гишүүнээр тасалъя. Ганбат гишүүн асуулт, үг хэлье.

Д.Ганбат: Уг нь нэлээн олон зүйл асууж тодруулмаар байсан юм. Тэгээд бас үг хэлчихье гэж бодож байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлтээ гаргасан байсан. Тэр дүгнэлтээр бол их л хариуцлагагүй л төсөв болж байна гээд ийм дүгнэлт гарч гэж ойлгосон. Тэгээд миний баримталдаг үзэл

баримтлал манай АН-ын баримталдаг үзэл баримтлалаараа бол энэ төрийн оролцоо, энэ орон тоо энэ юм бол аль болохоор л бага л байх ёстой л доо. Ер нь 2 нам хоёулаа л тийм хөтөлбөр гаргаад л энэ сонгуульд оролцсон гэж ойлгож байгаа. Гэтэл тийм юм нь харагдахгүй байна.

Энэ нартай сайхан өдрүүд, нартай сайхан өдрүүд гэдгийг би бол уул уурхайн бүтээгдэхүүний үнэ боломжийн байх гэдгийг хэлж байгаа юм. Энэ байдал удаан үргэлжлэхгүй. Ер нь төсвийн тодотгол болгоноор л бараг л 10 хувийн нэмэгдэлт хийгээд байх юм. Тэгээд энэ дотоодын нийт бүтээгдэхүүний 30, 40 хувьд нь ингээд төсөв оролцоод яг л Венесуэлийн замаар яваад байх юм. Ийм маягаар цаашаа явж чадахгүй, энийгээ өөрчлөөч гэсэн зүйлийг би бас хэлмээр байна.

Яг өөрөө хүч чадлаа зарцуулаад ажил хийдэг ТҮК-ийн ажилчид маань Улаанбаатар хотод 1 мянга орчим долларын цалин авч эхэлж байх шиг байна. Энэ бол маш сайн, зөв. Тэгэхгүй бол тэнд ажиллах хүмүүс олдохгүй. Манай өнөөдрийн Аюулгүй байдлын байнгын хорооны харьяалалд байдаг энэ яамнуудын ажилчид, төрийн албан хаагчид маань амьдрал ахуйд нь хүрэлцэх хэмжээний цалин авч байгаа юу, хэвийн амьдарчих боломжтой юу?

Тэгээд сүүлийн 10-аад жил маш сайхан үе байлаа таатай. Ажиллах хүчний хувьд ч гэсэн боломжтой ийм үе байсан. Гэтэл 200, 300 мянган хүн гадагшаа гараад явчихсан. Энэ төрийн албанд чинь ажиллах хүн олдохгүй болчихсон гэсэн ийм мэдээлэл надад өгөөд байна л даа. Тэр ХЗБХ-н дээр бол мянгаад цагдаа дутагдалтай байна л гэж байна. Боловсролын салбарт гэхэд 4 мянган багш байхгүй байна гэх жишээтэй. Тэгээд ийм нөхцөл байдалтай байна. Тэгээд энэ дээрээ бол анхаарч байгаа, энэ талыг амьдралтай нь нийцүүлж ярьж байгаа ийм юм алга.

Нөгөө талаар бензин шатахуун чинь тасарч магадгүй байна. Албан ёсны хариу авч чадаагүй юм байна. Эрчим хүчээ бол таслах нь гэж, таслах нь шиг байна, хязгаарлана гэж байна. Тэгээд нөгөө нефтийн үйлдвэр нь хэзээ орох юм бэ? Баахан мөнгө авчихсан байна. Өр ихсээд байдаг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн 3 минут.

Б.Энхбаяр: Миний хувьд бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр анх удаа орж ажиллаж байгаа. Энэ удаа төсвийн тодотгол хэлэлцэж байгаатай холбоотойгоор өнгөрсөн 4 жилийн бүрэн эрхийн хугацаанд нэг анзаарсан, ер нь шийдвэл зохих нэг асуудал бол байна гэж харсан. Тэр нь бол энэ өрийн менежменттэй холбоотой асуудал байгаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор зээлийн хэлэлцээрүүд орж, соёрхон батлах, зөвшөөрөх асуудлууд явагддаг. Энэ дотор улсын зээлийн гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх ийм төсөл хөтөлбөрүүдийн зээлийн хэлэлцээрүүд орж ирдэг. Энэ хүрээнд бол би өнгөрсөн бүрэн эрхийн хугацаанд нэг мэдэгдэл хийж байсан. Энэ төсөв дагасан их том хулгай байна. Гадаадын зээл, тусламжийн хөтөлбөрүүдийг нэг сайд тохирчихдог агуулгыг нь. Тэгээд том ерөнхий дүнгээр зээлийн хэлэлцээр нь батлагдаад, улсын төсөв дээр орж ирэхээрээ гадаадын зээл, тусламжийн хүүгийн төлбөр гэсэн ганц дүнгээр ингээд яваад байдаг. Тэгээд энэ зээлүүдийн зориулалт, зарцуулалт, хүү, үр ашиглалттай холбоотой асуудлыг сая Тэмүүлэн даргын манлайлж хавар хийсэн төсвийн бодлогын шинэчлэлтэй хамт энэ гадаадын зээл, тусламжийн асуудлыг нэлээн процессжуулж авч үздэг байвал ёстой юм байна гэсэн бодолтой байгаа.

Тэгээд Тэмүүлэн дарга бас энэ яг Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хороон дарга хийж байгаа. Энэ бол бас их том боломж байгаа. Яг энэ төсвийн бодлогоо мэдэж байгаа учраас. Тэгээд жилдээ бол 400-гаад сая доллар гаднын зээлийн төлбөрт гэсэн энэ төсвийн ном дотор бол ингээд ганцхан дүн явж байгаа юм. Тэгээд энэ яг ямар, хэзээ авсан зээлийн төлбөр юм, зарцуулалт нь яасан юм гээд ийм ерөөсөө Их Хурлын парламентын мэдэлд мэдээлэл байдаггүй. Тэгээд би бол тодорхой хэлж байсан шүү дээ. Энэ Сангийн сайд нарын тойрогт л зээл аваад, тэрийг нь ард түмнээрээ төлөөд байх юм гэж.

Тэгээд миний анзаарч байгаагаар бол улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой тийм асуудлуудыг бас шийддэг. Тэр 50 сая доллароор малчдад хашиа барьчихъя гээд төсөл өнгөрсөн парламентад орж ирж байсан. Тэр нь 7 сумд байсан юм. Тэгснээ дараа нь 14 сум болчихсон байсан. Тэгээд ингээд дураараа тэр сайд нарын түвшинд өөрчлөөд байдаг. Энийг нэг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Шинэ Их Хурал байгуулагдаад ЗГ анхныхаа төсөвтэй холбоотой тодотголоо оруулж ирж байна. Бид нар энэ өр зээлийн асуудлыг бол хэдийгээр бусад гишүүд ярьсан ч байлаа дахин давтан ярихаас өөр арга байхгүй. Иргэний Зориг ногоон намын мөрийн хөтөлбөрт энэ өр зээл дотроос тухайлбал нэг зээлийг улсад мэдээж эдийн засгийн аргаар үүссэн өр. Зээл, өр гэж хэлээд яах вэ зээл. Монголын Төв банк Хятадын Ардын банкттай своп хэлцлээр үүссэн бараг 4 тэрбум орчим дөхөж очсон. Би яг нарийн тоог нь мэдэхгүй байна. Тэр долларын зээлийг улс төр, эдийн засгийн аргаар тэглэх хэрэгтэй гэдэг, тэглэнэ гэдэг ийм заалт Иргэний Зориг ногоон намын мөрийн хөтөлбөрт орсон. Энэ бол Ардын банк Хятадын ардын банканд Монгол төгрөгийг хадгалуулаад, Монголд Монголын Төв банканд Хятадын юанийг авчраад,

хэрэглээд, зараад юань нь алга болчихсон, хэрэглэчихсэн. Төгрөг бол тэнд хадгалагдаж байдаг ийм байдалтай зээл байгаа.

Иймэрхүү эрсдэл бүхий шийдэх шаардлагатай, сая бол нэлээн хэдэн бондын асуудлыг шийдлээ гээд бид нар зээлүүдийг дарлаа гээд нэлээн олон удаа дараалаад Сангийн сайд болон Ерөнхий сайд, Төсвийн байнгын хорооны дарга эд нар нь бол мэдэгдлүүд хийгээд байсан өнгөрсөн хугацаанд. Тийм болохоор иймэрхүү зээлүүд дээр ирээдүйд бид нар хэрхэн яаж энэ нөгөө ямар хэмжээтэй, зөв зориулалттай буюу яг үнэхээр зайлиггүй шаардлагатай зээлүүд дээрээ анхаарч авч үлдээд бусад зээлүүдээ шийдэх тал руугаа бас их анхаармаар байгаа юм. Энийг бол цааш цаашидаа мэдээж төсвийн тодотгол дээр ийм юмыг оруулаад шийдчихнэ гэж байхгүй. Ирэх 2, 3 чиглэлийн үндсэн чиглэл, Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсөв өргөн барихдаа оруулаад шийдэх талаар нь ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо бол энэ өр зээлийн асуудалтай холбоотойгоор бол тусдаа нэг хуралдаж, бүр зайлиггүй анхаарахыг Байнгын хорооны даргаас бас хүсэж байна. Тийм хурал, тийм сонсголыг зохион байгуулах хэрэгтэй.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна гэж үзлээ. Одоогоор гаргасан саналын томъёолол байхгүй байна. Ингээд Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд танилцуулах учиртай байгаад байгаа. Энхбаяр гишүүн танилцуулчих уу Төсвийн байнгын хороон дээр? Манайхаас ганцхан би л байгаа юм байна. Тэгвэл Энхбаяр гишүүн танилцуулъя. Ингээд ажлын хэсэгт баярлалаа. 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

дууссаныг мэдэгдье. Байнгын хорооныхоо гишүүдэд баярлалаа.

14.33 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал
дууссан тул Байнгын хорооны хуралдаан

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА